

МОНГОЛ УЛСЫН НОГООН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА



БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ



ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Partnership for Action on
GREENeconomy

PAGE

Төслийн нэр: Ногоон эдийн засгийн төлөө түншлэл – Нэгдсэн үндэстний байгууллагын (НҮБ) салбар байгууллагууд болох НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын Үйлдвэрлэл хөгжлийн байгууллага, НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгийн хамтарсан төсөл

Судалгааны ажил: [Ногоон эдийн засгийн төлөв байдлын судалгаа](#)

Гүйцэтгэгч: Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ)

Хаяг: Сан бизнес центр, 9-р давхар
Ерөнхий сайд Амарын гудамж 29
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол Улс

Утас: (+976) 11-321927

Факс: (+976) 11-321926

И мэйл: info@ecrc.mn

Вэбсайт: www.ecrc.mn

Улаанбаатар 2014

ӨМНӨХ ҮГ

Дэлхийн улс орнуудын төр, засгийн тэргүүд оролцсон 2012 оны Рио+20 чуулга уулзалтын үр дүнд даян дэлхийн тогтвортой хөгжлийн зарчим, үзэл баримтлал, тунхаглалыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон “Ногоон хөгжил”-ийн замыг сонгохыг улс орнуудаас уриалсан билээ.

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Ногоон хөгжлийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгох”, ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэн “Ногоон соёл иргэншил” үзэл баримтлал, хөтөлбөрийг боловсруулж, загваруудыг бий болгохоор заасан билээ

Монгол Улсын Засгийн газар уул уурхайгаас хамааралтай эдийн засгийн эрчимтэй өсөлтийн энэ цаг үед Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг хангах, ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилтыг тавьж байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд ихээхэн идэвхи гарган байгаль орчны хуулиудад иргэд, аж ахуйн нэгжийн байгаль орчинд ээлтэй, нийгэмд хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг хангаж ажиллаж байна. Мөн ногоон хөгжлийн бодлогыг боловсруулан эдийн засгийн үйл ажиллагааг байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхээргүй төлөвлөн хэрэгжүүлж, байгаль хамгаалал, экосистемийн үйлчилгээг тэтгэх, хүний хөгжил, цэвэр технологид хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг баримталж байна.

Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл-ийн хөтөлбөрт нэгдэн орох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу 2013 оны 6 дугаар сард Дэлхийн байгаль орчны өдрийг Улаанбаатар хотноо тэмдэглэн өнгөрүүлэх үеэр зохион байгуулагдсан Ногоон хөгжлийн үндэсний чуулганаар НҮБ-ын системийн дөрвөн байгууллагын санаачилсан энэ хөтөлбөрт Монгол Улс албан ёсоор элсэх болсныг зарласан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тогтвортой хөгжлийг хангах хүрээнд ногоон эдийн засагт чиглэсэн бодлого боловсруулах, хөгжлийн хөтөлбөр, арга хэмээг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэх, ногоон эдийн засгийн хөгжилтэй холбоотой мэдлэг, мэдээллийг түгээх нэгдсэн тогтолцоо, техникийн бааз бүрдүүлэх чухал ач холбогдолтой болно.

Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжих Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн хамтын ажиллагаа нь шинэ санаа, нөөц бололцоог илрүүлж улмаар нийгмийн тэгш байдал, хүлэмжийн хий багатай, байгаль орчинд ээлтэй эдийн засгийн хөгжлийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагааны талаархи хэлэлцүүлгүүдийг өрнүүлж шинэ шатанд гаргана гэдэгт итгэж байна. Ногоон хөгжлийн эхлэлийг тавих, шилжих эхний үе шатны нөхцөл байдлыг судалсан тойм судалгаа нь ирээдүйд бидний хөгжлийн үр дүнг харьцуулах томоохон суурь болох ач холбогдолтой.

Оролцогч талуудын идэвхитэй оролцоо, хэлэлцүүлгийн үр дүнд боловсруулсан ногоон эдийн засгийн төлөв байдлын тухай энэхүү тойм судалгаа нь олон нийт, төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, удирдан чиглүүлэх, олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагааг харилцан уялдуулах бололцоог олгоно гэдэгт гүнээ итгэж байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд



Санжаасүрэнгийн Оюун

ТАЛАРХАЛ


Энэхүү судалгааг НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөө түншлэл (НЭЗТТ) төслийн хүрээнд Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны (БОНХЯ) захиалгаар гүйцэтгэв. НЭЗТТ төслийг Монгол Улсад хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг эхлүүлэхэд БОНХЯ-ны зөвлөх Др.Т.Чулуун чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Судалгааны ажлын явцад тус яамны Цэвэр технологи, шинжлэх ухааны хэлтсийн дарга А.Энхбат зөвлөн, чиглүүлж ажилласан. Үүний зэрэгцээ, Эдийн засгийн хөгжлийн яам, Уул уурхайн яам, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Дэлхийн банк зэрэг бидэнтэй уулзсан төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчдөд тусгайлан талархал илэрхийлж байна.

Судалгааны ажлыг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын төвөөс гүйцэтгэсэн бөгөөд тэр дундаа Боожоогийн Лакшми, Ихбаярын Одончимэг болон Николос Пламмер нар мэдээлэл цуглуулах, уулзалт хэлэлцүүлэг зохиох болон тайланг бичих ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн.

НЭЗТТ хөтөлбөрийн зүгээс НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн дарга Др.Стивэн Стоуны удирдлага дор ажиллав.

Судалгааны бүтэц, ерөнхий агуулга, чиглэлийг ноён Фулай Шенг гарган Ричард Скотни төслийн удирдагчаар ажиллав. Оскар Гарсиа, Аким Халпаап нар (НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн) НЭЗТТ хөтөлбөрийн Монгол Улс дахь үйл ажиллагааг хамтран удирдан чиглүүлж буй билээ. Мөн энэхүү тайлан нь НЭЗТТ хөтөлбөрийн үндэсний зохицуулагч Чойжилжавын Батхуяг, Женев дахь НҮБ-ын төлөөлөгчид болох Лувсангийн Нараа, Асад Накви, Энхбатын Анггар, Зенгзэнг Кию (НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр), Мустафа Камал Гию (Олон улсын хөдөлмөрийн байгууллага), Клаудиа Линке Хийп (НҮБ-ын Үйлдвэрлэл хөгжлийн байгууллага) болон Алис Дауриа (НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн) нарын тусламж дэмжлэгтэйгээр гүйцэтгэгдэнэ.

Кавех Захади тэргүүтэй НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн төвийн хамт олон болон Стефанос Фотиу нарт талархал илэрхийлж байна. НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагч хатагтай Сезин Синаноглу, дэд зохицуулагч Томас Эриксон болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь төлөөлөгчийн газрын хамт олны төлөөлөл болох Базарцэрэнгийн Бүнчингав, Жамбалын Должинсүрэн нарт талархал илэрхийлж байна.



НЭР ТОМЪЁОНЫ ТОВЧЛОЛ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АОУХА	Австралийн Олон улсын хөгжлийн агентлаг
АХБ	Азийн хөгжлийн банк
АЧС	Агаарын чанарын стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ГОУХАН	Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ДБ	Дэлхийн банк
ДДНХХ	Даян дэлхийн ногоон хөгжлийн хүрээлэн
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЖХУУГАО	Жижиг хэмжээний уул уурхай, гар аргын олборлолт
МАБТ	Монголын агаарын бохирдлын төсөл
МАОЗНХ	Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МСС	Мянганы сорилтын сан
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МҮЭХ	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо
МХЗ	Мянганы хөгжлийн зорилтууд
НЗБС	Ногоон зээлийн баталгааны сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХБОХ	НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НХС	Ногоон хөгжлийн стратеги
НЭЗТТ	Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл
ОТ	Оюу толгой
ОУНӨХ	Олон улсын ногоон өсөлтийн хүрээлэн
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ОУХА	Олон улсын хөгжлийн агентлаг
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СЭХҮТ	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТХ	Үнэ тогтворжуулах хөтөлбөр
ҮХАЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ҮХХ	Үндэсний хөгжлийн хүрээлэн
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ХХС	Хүний хөгжлийн сан
ХЯ	Хөдөлмөрийн яам
ШХА	Швейцарийн Хөгжлийн агентлаг
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төв
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам

АГУУЛГА

Хураангуй.....	7
1. Танилцуулга.....	12
1.1 Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл төслийн танилцуулга	12
1.2 Судалгааны ажлын зорилго.....	12
1.2 Судалгааны арга зүй.....	12
2. Нийгэм, эдийн засгийн өнөөгийн төлөв байдал ба тулгарч буй гол сорилтууд.....	13
2.1 Төв Азид орших өргөн уудам газар нутаг бүхий, далайд гарцгүй орон.....	13
2.2 Хур тунадас багатай эрс тэс уур амьсгал	13
2.3 Нягтаршил сийрэг боловч өсөн нэмэгдэж буй хүн ам	13
2.4 Хотжилт улам нэмэгдсээр	13
2.5 Эдийн засгийн хурдацтай өсөлт	14
2.6 Уул уурхайн салбарын хамаарал.....	15
2.7 Тулгарч буй сорилтууд	15
2.8 Хүрээлэн буй орчинтой холбоотой тулгарч буй гол асуудлууд.....	18
3. Сорилтуудыг даван туулах нь: Төрийн зүгээс баримтлах Ногоон хөгжлийн стратегийн бодлогууд.....	21
3.1 Ногоон эдийн засгийн цар хүрээг тодорхойлогч стратегиуд	21
3.2 Нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогууд ..	23
3.3 Хот төлөвлөлт, тээвэр	24
3.4 Орон сууцжуулалтыг дэмжих нь	25
3.5 Инфляцтай тэмцэх нь	25
3.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд.....	25
3.7 Халамжийн бодлогууд.....	26
3.8 Хүйсийн эрх тэгш байдал.....	26
3.9 Хүн ам ба хүн амын бодлого	27
3.10 Хүрээлэн буй орчинтой холбоотой хууль тогтоомж.....	27
3.11 Сэргээгдэх эрчим хүч ба эрчим хүчний хэрэглээний ашигт байдал.....	28
3.12 Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ.....	29
3.13 Ногоон уул уурхайг хөгжүүлэх	29
3.14 Хөдөө аж ахуй, газрын менежмент	29
3.15 Ойн аж ахуйн хөтөлбөрүүд	30
3.16 Ус, хог хаягдлын менежмент	31
3.17 Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх нь	31
4. Засгийн газраас чинад: Ногоон эдийн засгийг хөгжүүлэх нь	32
4.1 Хувийн хэвшил дэх ногоон стратеги	32
4.2 Ногоон бүтээгдэхүүнийг дэмжих нь.....	34
4.3 Ногоон банк, ногоон зээл	34
4.4 Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь.....	35
4.5 Эрчим хүчний ашигт байдал болон цэвэр үйлдвэрлэл	35
4.6 Сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх хувийн хэвшлийн санаачилгууд	36
4.7 Улаанбаатарын агаарын бохирдолтой тэмцэх нь	37
4.8 Хүрээлэн буй орчны засаглал.....	38
4.9 Тогтвортой уул уурхайг дэмжих нь	39
4.10 Хөдөө аж ахуйн төслүүд.....	40
4.11 Ойн аж ахуйн төслүүд.....	40
4.12 Усны менежментийн стратеги.....	41
4.13 Тээврийн салбарыг “ногооруулах” нь.....	41
4.14 Байгаль орчинд ээлтэй санхүүжилт	42
5. Хамтын ажиллагаа: НЭЗТТ-ийн зорилтуудыг биелүүлэхийн төлөө талууд хамтран ажиллах нь.....	43
5.1 Засгийн газар	43
5.2 Хөдөлмөр эрхлэгч болон ажил олгогчдын холбоод	45
5.3 Хувийн хэвшил:	46
5.4 Олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд	47
5.5 Төрийн бус байгууллагууд.....	50
6. НЭЗТТ-ийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд.....	51
6.1 Мэдлэг, мэдээллийн зөрүү ба мэдээллийн эх сурвалж.....	51
6.2 Тэргүүлэх салбарууд.....	52
6.3 НЭЗТТ-ийн ажиллагаанд оролцох, хамтран ажиллах гол талууд.....	52
6.4 НЭЗТТ-д өгөх санал зөвлөмжүүд	53
Ашигласан материалын жагсаалт.....	57

Хураангуй

Уул уурхайн салбараас улбаатай эдийн засгийн хурдтай өсөлт Монгол Улсын хувьд боломжуудыг нээхийн хэрээр бэрхшээлүүдийг авчирч буй. Хэрэв нөөц бололцоогоо зөв зохистой удирдаж чадвал ядуурлын түвшингээ бууруулж, Азийн чинээлэг орнуудын нэг болон хөгжил цэцэглэлтийн зөв замд орох боломж бий. Зэс, алт, нүүрс зэрэг эрдэс баялгийн арвин их нөөцтэй манай улс эдийн засгийн өсөлтийн хурдаар ирэх жилүүдэд ч дэлхийд тэргүүлсээр байна гэсэн хүлээлт байгаа билээ.

Хэдий тийм боловч, Монгол Улс юуны түрүүнд эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны холбогдолтой олон сорилт бэрхшээлүүдийг даван гарах ёстой. Өнгөрсөн жилүүдийн уул уурхайн болон гадаадын хөрөнгө оруулалтын “тэсрэлт” нь Монгол Улсын эдийн засгийг уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг бий болгосон. Экспорт болон гадаадын хөрөнгө оруулалтын эрсдлүүд нь эдийн засгийн савласан, тогтворгүй байдлыг өдөөж байгаа бөгөөд ингэснээрээ инфляцын тогтмол өсөлт болон төгрөгийн ханшийн сулрал үргэлжлэхэд сөргөөр нөлөөлсөөр байна. Эрчим хүч, усны хангамж, зам тээвэр гэх мэт дэд бүтцийн хоцрогдлууд нь аж үйлдвэржилт болон хөдөө аж ахуйн салбарын хөгжилд чөдөр, тушаа болж байна.

Хүний хөгжлийн үзүүлэлтүүдэд ахиц дэвшил ажиглагдаж, иргэдийн орлого нэмэгдэж байгаа хэдий ч орлогын тэгш бус байдал асуудал хэвээр байсаар байна. Түүнчлэн Улаанбаатар хот болон хөдөөгийн хөгжлийн ялгаа анхаарал татахуйц их байна. Мөн уул уурхай хөгжсөн бүс нутаг болон бусад аймаг сумдын хөгжлийн түвшин ч харилцан адилгүй байсаар байгаа.

Нөгөө талаас Улаанбаатар хотын агаарын бохирдол, усны зохисгүй менежмент, усны бохирдол, хөрсний бохирдол болон цөлжилт зэрэг байгаль орчны ноцтой асуудлууд нь нэг талаар шинээр олон барилга байгууламж баригдаж, уул уурхайн үйл ажиллагаа, бэлчээрийн мал аж ахуй нэмэгдсэн зэргээс үүдэлтэй боловч нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлт болон ойн нийт сан багасаж буйтай холбоотой. Ирээдүйд тулгарч болох бэрхшээлүүдийг даван туулахын тулд шийдвэр гаргагчид одооноос анхаарах нь үр дүнтэй юм. Эдгээр алсын ирээдүйд учирч болох сорилт бэрхшээлүүдийн талаар “Монгол Улсын ногоон эдийн засгийн төлөв байдлын судалгаа”-ны нэгдүгээр бүлэгт дурдсан билээ.

Хүрээлэн буй орчны асуудлууд нь эдийн засгийн хөгжлийн нэгэн чухал хэсэг юм. Эдгээр асуудлуудыг

шийдвэрлэхийн сацуу аж үйлдвэржилтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх стратегийн бодлогуудыг хэрэгжүүлэх нь улс орны ирээдүйд чухал нөлөөтэй. Иймд Монгол улс “Хүрээлэн буй орчны эрсдэл болон экологийн хомсдолыг бууруулах, нийгмийн эрх тэгш байдал, хөгжлийн үр шимийг хүртээмжтэйгээр хангахад чиглэсэн Ногоон эдийн засагтай болох зорилтыг дэвшүүлж байна.

Байгаль орчинд ээлтэй бодлого хэрэгжүүлж, эдийн засгийг бүхэлд нь тогтвортой хөгжлийн замд оруулахын тулд Монгол Улсын засгийн газрын зүгээс “Ногоон хөгжлийн талаар баримтлах Монгол Улсын үндэсний үзэл баримтлал” бодлогын баримт бичгийг батлуулахыг зорьж байгаа билээ.

Үүний зэрэгцээ хувийн хэвшлийн байгууллагууд ч мөн тодорхой санаачилгууд гаргасаар байна. Тухайлбал бизнесийн байгууллагуудын томоохон төлөөлөл болох Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАУТ) өөрийн “Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “5x20” зорилтыг дэвшүүлсэн. Хас болон Голомт банкууд ногоон зээл, хөрөнгө оруулалтын төслүүдийг бизнесийн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бол Ньюком групп ногоон эрчим хүчний төсөл амжилттай хэрэгжүүлж буйг тэмдэглүүштэй.

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд агаарын бохирдлыг бууруулах, усны менежментийг сайжруулах төслүүдийг санхүүжүүлж ирсэн бөгөөд мөн сэргээгдэх эрчим хүчний дэд бүтцийг сайжруулах төслийн зээл олгож байна. Даян дэлхийн ногоон хөгжлийн хүрээлэн (ДДНХХ) болон Дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг төрийн бус байгууллагууд ч мөн тодорхой төслүүдийг хэрэгжүүлж зөв хандлага төлөвшүүлэх замаар шийдвэр гаргагчдад нөлөөлөх ажлууд хийдэг. Эдгээр болон бусад төсөл, санаачилгуудын тухай судалгааны тайлангийн 3-р бүлэгт тайлбарлаж, жагсаалт гаргав.

Энэхүү төлөв байдлын судалгаагаар бид дээр дурдсанчлан эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үр шимээ өгөхөд чиглэсэн бодлого, санаачилгуудыг нэгтгэн тодорхойлохын зэрэгцээ ногоон эдийн засгийн хөгжлийг хойш татаж буй голлох учир шалтгаануудыг тодруулахыг зорилоо. Ингэхдээ зөвхөн илэрч буй шинж тэмдгүүдийг оношлохыг урьтал болгосонгүй. Судалгааны тайлангийн 1 болон 2-р бүлэгт цаашид ногоон эдийн засагт шилжих бодлого болон хөтөлбөрүүдийг 1-р бүлэгт засгийн газрын санаачилгуудыг, 2-р бүлэгт хувийн хэвшил болон олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар тойм танилцуулга оруулсан. Хүснэгт 1-д одоо хэрэгжиж байгаа төслүүдийг жагсаан ач холбогдлоор нь их, дунд буюу бага гэж ангилан тус бүрийн хамрах хүрээ, ач холбогдлыг нь тодорхойллоо. Төсөл, хөтөлбөр тус бүрээр санхүүгийн мэдээллийг нарийвчлан авах боломжгүй байсан тул бид судалгаанд оролцогчдоос авсан ярилцлага, өөрсдийн цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн үнэлэлт, дүгнэлт өгсөн. Төслийн санхүүжилтийн хэмжээ нь харьцангуй их, 5-аас дээш жилийн хугацаатай төслүүдийг өндөр ач холбогдолтой, бусад төслүүдтэй харьцуулахад санхүүжилтийн хэмжээ нь дунд зэргийн, хугацааны хувьд 1-5 жилийн хооронд хэрэгжих төслүүдийг дунд зэрэг ба хэрэгжих хугацаа нь богино эсвэл үргэлжлэх цаг хугацаа нь тодорхойгүй төслүүдийг ач холбогдол харьцангуй бага гэж үнэлэв.

Судалгааны явцад *Ногоон эдийн засгийн төлөө түншлэл* хөтөлбөрийг хэрэгжүүлэх тэргүүлэх салбарууд буюу МУ-ын ногоон эдийн засгийг хөгжүүлэх голлох салбарууд нь: **хөдөө аж ахуй, уул уурхай** болон **эрчим хүчний** салбарууд байна. Үүнээс гадна бусад салбарууд жишээлбэл тээвэр, бохирын менежмент болон аялал жуулчлалын салбарууд нь Монгол Улсын хөгжилд чухал ач холбогдолтой.

МУ-ын засгийн газар “Ногоон хөгжлийн талаар баримтлах Монгол Улсын үндэсний үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд НЭЗТТ төслийн техник туслалцаа, хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой. Судалгаанаас харахад дараах таван чиглэлд анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

1. **Ногоон хөгжлийн үзэл баримтлалыг урт хугацааны хөтөлбөр болгон хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах.** Улмаар одоогийн засгийн газрын үйл ажиллагаа болон дараа дараагийн засгийн газруудын мөрийн хөтөлбөрүүд энэхүү стратегийн баримт бичигтэй уялдан гарч байх угтвар нөхцлүүдийг бүрдүүлэхэд анхаарах;

2. **Яамд болон бусад холбогдох байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжин сайжруулах.** Энэхүү стратегийн хөтөлбөр нь зөвхөн нэг яамны ажил хэрэг бус бусад яамд, холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлэгч байх. Ингэхдээ одоогийн байгаа баримт бичгүүдэд тулгуурлан ногоон хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлоход чиглэсэн хэлэлцүүлгүүд өрнүүлж санал асуулга авах, ногоон хөгжлийн холбогдолтой төсөл, санаачилгуудыг цогцоор судлан оруулах;
3. **Хөрөнгө оруулалтын үр ашигтай, тасалдахгүй байх нөхцлийг сайжруулахад анхаарч бодлогын хүрээнд шийдвэрлэх арга замуудыг эрэлхийлэх.** Тухайлбал одоогийн хөрөнгө оруулалтууд болон тодорхой зорилтууд бүхий төслүүдийн үр дүнг үнэлэн хэмжихэд дэмжлэг үзүүлэн шийдвэрлэхээр зорьж буй зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч хамтран ажиллах. Улмаар санхүүжилт, хөрөнгө оруулалтын тасалдалтыг нөхөх арга замыг тодорхойлоход туслах.
4. **Ногоон хөгжлийн талаар сургалт, сурталчилгааны дутмаг байдлыг нөхөхөд анхаарах;**
5. **Шинэ дэвшилт технологи, инновацийг нэвтрүүлэх, бусад улс орнуудад хэрэгжсэн сайн жишээнүүдээс туршлага солилцох;**



ХҮСНЭГТ 1:

МОНГОЛ УЛСАД ОДОО ХЭРЭГГИЖ БҮЙ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ НОГООН ЭДИЙН ЗАСАГТАЙ ХОЛБОГДОЛТОЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Төрөл	Ач холбогдол	Хэрэгжиж буй бодлого, стратеги буюу төсөл, хөтөлбөр	
		УИХ, МУЗГ-с баталсан хууль тогтоомж болон бодлогын баримт бичгүүд	Хувийн хэвшил, олон улсын байгууллага, ТББ-ын санаачилгууд
Монгол Улсын хуулиуд	Өндөр	Эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон дэд бүтэцтэй холбоотой хуулиуд. Тухайлбал "Байгаль орчны шинэчлэгдсэн хууль. 2012", "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль", "Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2007)", "Сэргээгдэх эрчим хүчинд мөрдөгдөх татвар болон сэргээгдэх эрчим хүчний сангийн тухай", "2012 оны Нийгмийн хамгааллын хууль", "Жендерийн тэгш байдлыг нэмэгдүүлэх тухай хууль (2011)", "МУ-ын аялал жуулчлалын хууль" гэх мэт, www.legalinfo.mn)	-
Үндэсний хэмжээний бодлого, стратеги	Өндөр	Ногоон хөгжлийн талаар баримтлах Монгол Улсын үндэсний стратеги	-
	Дунд	- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ-ын 2008 оны 12-р тогтоол - Засгийн газрын 4 жилийн мөрийн хөтөлбөр - Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2004-2015), УИХ-ын 2004 оны 21-р тогтоол - Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001-2020 он), УИХ-ын 2001 оны 57-р тогтоол - Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, УИХ-ын 2013 оны 39-р тогтоол - Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, УИХ-ын 2001 оны 81-р тогтоол - Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого, УИХ-ын 2011 оны 65-р тогтоол - Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, УИХ-ын 2010 оны 34-р тогтоол - Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2003-2015 он), УИХ-ын 2003 оны 29-р тогтоол - Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (2001-2020 он), УИХ-ын 1997 оны 106-р тогтоол - Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014-2025 он), УИХ-ын 2014 оны 18-р тогтоол - Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөр (2011-2020), УИХ-ын 2011 оны 22-р тогтоол - Улаанбаатар хотын Засаг дарга Э.Бат-Үүл болон БОНХЯ-ны сайд С.Оюун нарын үзэглэсэн "Харилцан ойлголцлын санамж бичиг"	-

Эдийн засаг, нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төсөл, хөтөлбөрүүд	Өндөр	- Дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн “Чингис бонд”-ын зарцуулалт (1.5 тэрбум ам.доллар) - Япон улсын зах зээл дээр арилжаалагдсан “Самурай бонд” (30 тэрбум иен) - МУ-ын хөгжлийн банкны дэд бүтцийн хөгжилд зориулсан хөрөнгө оруулалт (580 сая ам.доллар)	Ядуурал болон байгаль орчин санаачилга (НҮБХХ)
	Дунд Буюу бага	“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”, МУЗГ болон Монголбанкны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг - Урт хугацааны, $\pm 8\%$ хүүтэй орон сууцны зээлийн хөтөлбөр, МУЗГ-ын 2013 оны 135-р тогтоол - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд - Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2006-2015 он), МУЗГ-ын 2005 оны 245-р тогтоол	
Байгаль орчны холбогдолтой голлох төсөл, хөтөлбөрүүд	Өндөр	-	- НҮБХХ: МУ-ын байгаль орчныг хамгаалах, засаглалыг сайжруулах хөтөлбөр. (1, 2-р үе) - МУ-ын тусгай хамгаалалтад багтсан бүс нутгийн холбоог сайжруулах (НҮБХХ) - ЖАЙКА-гийн ЖДҮ-г хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах “Хоёр үе шаттай зээлийн төсөл”
	Дунд	- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2011-2021 он), УИХ-ын 2011 оны 2-р тогтоол - Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998-2015+ он), УИХ-ын 1998 оны 29-р тогтоол “Монгол мал” үндэсний хөтөлбөр (2010-2021), УИХ-ын 2010 оны 23-р тогтоол “Ус” үндэсний хөтөлбөр (2010-2021 он), УИХ-ын 2010 оны 24-р тогтоол, - Бүх нийтэд экологийн боловсрол Үндэсний хөтөлбөр (1997-2029), МУЗГ-ын 1997 оны 255-р тогтоол - Ойн хортон шавьж болон өвчинтэй тэмцэх дэд хөтөлбөр (2004-2015 он), МУЗГ-ын 2004 оны 5-р тогтоол - Ойн тухай үндэсний хөтөлбөр (2001-2015 он), МУЗГ-ын 2001 оны 248-р тогтоол - Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр, МУЗГ-ын 2006 оны 99-р тогтоол - Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр (1999-2030), МУЗГ-ын 1999 оны 129-р тогтоол - Чанарын болон байгаль орчны удирдлага/ менежмент/-ийг дэмжих үндэсний хөтөлбөр (2002-2015), МУЗГ-ын 2002 оны 146-р тогтоол - Ус, цаг уур орчны шинжилгээний салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, МУЗГ-ын 2002 оны 182-р тогтоол - Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020), МУЗГ-ын 2003 оны 90-р тогтоол - Цэвэр агаар сан - Баянхонгор аймагт хэрэгжсэн “Экологийн эмзэг байдалд нь тулгуурлан төсвийг дахин хуваарилах” хөтөлбөр, 2014 онд 6 аймагт хэрэгжинэ	- Ногоон ном (МУХАҮТ) - ДДНХХ-с хэрэгжүүлж буй төсөл, судалгааны ажлууд - Биологийн төрөл зүйл, ойн нөөцийг нэмэгдүүлэх болон экосистемийн доройтол цаг агаарын өөрчлөлтийн эсрэг Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтарсан хөтөлбөр “REDD+” хөтөлбөр - Байгал орчныг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр - Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл (ДБ) - Улаанбаатарын цэвэр агаар санаачилга 2-р үе (ЕСБХБ хэрэгжиж дууссан) - Эрчим хүч болон хүрээлэн буй орчны төсөл (АНУ-ын МСС 2010 онд дууссан) - Монголын агаарын бохирдлын төсөл (МУЗН болон ЭМШУИС) - Байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцогчдыг нэмэгдүүлэх (Азийн сан) - Дахин ойжуулах хөтөлбөр (МУХАҮТ) - Говийн өмнөд хэсэг дэх гүний усны менежмент. (ДБ, Австралийн ЗГ-ын хөгжлийн агентлаг) - Экосистемд тулгуурласан усны аюулгүйн тогтвортой байдлыг хангах хөтөлбөр (НҮБХХ) - Экосистемд тулгуурлан усны аюулгүй байдлыг хэвээр хадгалах, Монголын усны хомсдолтой газар нутагт борооны усыг ашиглах. (НҮБХХ) - Усны эрүүл ахуйг сайжруулах НҮБ-ын хамтарсан хөтөлбөр - Ундны усыг хамгаалах болон бохир ус зайлуулах системийг сайжруулах НҮБ-ын хамтарсан хөтөлбөр

Дэд бүтцийн холбогдолтой төсөл, хөтөлбөрүүд	Өндөр	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр (2010-2016 он), УИХ-ын 2010 оны 36-р тогтоол “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль” (2012-2016 он), МУЗГ-ын 2011 оны 359-р тогтоол “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр” (2005-2020 он), УИХ-ын 2005 оны 32-р тогтоол	-
	Дунд	100,000 нарны эрчим хүч хураагуур хөдөөгийн айл өрхүүдэд тараасан. (2010 онд хэрэгжиж дууссан) - Улаанбаатар метро төсөл	- Салхитын салхин цахилгаан станцын бүтээн байгуулалт (Ньюком групп) - Сэргээгдэх эрчим хүч болон хөдөө орон нутгийг эрчим хүчээр хангах төсөл (Дэлхийн банк)
	Бага	-	- Гурван сургуулийн шинэчлэл (ГХАН болон АНУ-ын хөгжлийн агентлаг) - Эрчим хүчний үр ашгийг бий болгох төсөл (НҮБХХ)
Бусад төсөл хөтөлбөрүүд	Дунд	- Боловсрол үндэсний хөтөлбөр (2010-2021 он), МУЗГ-ын 2010 оны 31-р тогтоол - Монгол Улсад Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр (2007-2015 он), МУЗГ-ын 2007 оны 306-р тогтоол - Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж	- Тогтвортой бичил уул уурхай төсөл - Малын индексжүүлсэн даатгал (МУ-ын ЗГ ДБ-тай хамтарсан) - Монголын мал аж ахуй болон хөдөө аж ахуйн маркетингийн төсөл (ДБ) - Газар тариалан, хүнсний аюулгүй байдал - Биологийн төрөл зүйл, ойн нөөцийг нэмэгдүүлэх, экосистемийн доройтол цаг агаарын өөрчлөлтийн эсрэг хөтөлбөр “Германы хамтын ажиллааны нийгэмлэг” - Хөдөө орон нутагт амьдралын таатай орчинг бүрдүүлэх (ДБ) “Эко, ногоон зочид буудал” шошго ашиглах - Ногоон бүтээгдэхүүнийг шошгожуулах (МУХАҮТ) - Органик бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх (МУХАҮТ) - Ногоон эдийн засгийг дэмжсэн зээлүүд - Ногоон эдийн засгийг дэмжсэн зээлийн батлан даалтын сан - Хас банкны бичил зээл - Голомт банкны ногоон эдийн засгийг дэмжих зээлүүд - Үндэсний аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэл (МУХАҮТ) - МУ-ын нийтийн тээврийг байгальд ээлтэй болгох (ДДНХХ)

1. Танилцуулга

1.1 НОГООН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Бидний хүсэж буй ирээдүй” сэдвийн дор 2012 онд зохион байгуулагдсан Рио+20 бага хурлын үеэр ногоон эдийн засаг нь тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах гол арга зам юм хэмээн санал нэгдсэн байдаг. Энэхүү чуулганы тунхаглалаар Нэгдсэн үндэстний байгууллагаас илүү хүртээмжтэй ногоон эдийн засагт шилжих эрмэлзэл бүхий орнуудад шаардлагатай туслалцаа үзүүлэхийг уриалсан билээ.

Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл хөтөлбөр (НЭЗТТ) нь Рио+20 бага хурлын тунхаглалын хүрээнд гарсан санаачилга юм. Энэхүү түншлэлийг НҮБ-ын салбар байгууллагууд болох НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр (UNEP), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO), НҮБ-ын Үйлдвэрлэл хөгжлийн байгууллага (UNIDO), НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн (UNITAR) гэсэн байгууллагууд хамтран санаачилсан бөгөөд нөөцийн үр дүнтэй ашиглалт бүхий хүртээмжтэй, нүүрстөрөгчийн хийн ялгарал багатай эдийн засгийн загварыг нэвтрүүлэхэд улс орнуудад туслалцаа зорилготой. НЭЗТТ-ийн хэтийн зорилго нь 2020 он гэхэд хөтөлбөрт хамрагдан, хамтран ажиллах улс орнуудад хүрээлэн буй орчинд ээлтэй, ажлын байрны нийлүүлэлт дунджаас дээгүүр, ядуурлын түвшин бага, иргэдийн сайн сайхан амьдрах орчин дээшилсэн эдийн засаг руу тогтвортой байдлаар шилжихэд дэмжин ажиллахад оршино.

Ирэх 7 жилийн хугацаанд НЭЗТТ-ийн зүгээс нийт 30 оронд ажлын байр шинээр бий болгох, шаардлагатай үр чадварт сургах, хүрээлэн буй орчинд ээлтэй цэвэр технологийг нэвтрүүлэх, хүрээлэн буй орчинд учрах эрсдэл болон ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахаар зорьж байна. Үүний зэрэгцээ, НЭЗТТ нь үндэсний ногоон эдийн засгийн стратеги боловсруулж хэрэгжүүлэн, цэвэр технологи нөөцийн хэмнэлт бүхий дэд бүтэц, үр ашигтай экосистемийг нэвтрүүлэх, “ногоон” чиг хандлага бүхий мэргэжлийн үр чадварыг хөгжүүлэх, сайн засаглалыг дэмжих бодлого, хөрөнгө оруулалтын чиглэлүүдэд түлхүү анхаарах замаар бодлогын хэрэгжилтийн таатай орчныг бүрдүүлнэ.

Төсөл хэрэгжиж эхлэх эхний 2 жилийн хугацаанд 7 оронд туршилтын журмаар үйл ажиллагаа явуулах ба аажмаар цар хүрээгээ нэмэгдүүлэн

2020 он гэхэд нийт 30 орныг хамруулах юм. Энэ хүрээнд Монгол Улс эхний 7 орны нэгээр сонгогдоод байна. Хөтөлбөрийн эхний үе шатанд Ногоон эдийн засгийн төлөв байдлын судалгаа, ногоон ажлын байрны зураглал дүн шинжилгээ, ногоон эдийн засгийн загварчлал гэсэн 3 үндсэн чиглэлээр техник туслалцаа, судалгааны ажлууд хийгдэнэ.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс *“Монгол Улсын ногоон эдийн засгийн төлөв байдлын судалгаа”* хийж гүйцэтгэлээ. Төвийн зүгээс энэхүү хөтөлбөрийн хүрээнд *Ногоон ажлын байрны зураглал* судалгааг мөн хийж гүйцэтгэсэн.

1.2 СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү судалгааны гол зорилго нь Монгол Улсад тулгарч буй эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны бэрхшээлүүдийг тодорхойлж, эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд төрийн зүгээс ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа, мөн ижил зорилгоор бусад байгууллагууд ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар нэгдсэн мэдээлэл тэдгээр бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд НЭЗТТ-ийн хамтын ажиллагааны боломжит хувилбаруудыг тодорхойлоход оршино.

1.3 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БОЛОН ХУГАЦАА

Энэхүү төлөв байдлын судалгааг 2013 оны 9 дүгээр сараас 2014 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Ингэхдээ өмнө нь энэ чиглэлээр хийгдэж байсан судалгаа, баримт бичгүүд болон хэрэгцээтэй статистикийн тоо баримтыг нягтлан шалгах, гол оролцогч талуудтай ганцаарчилсан уулзалт ярилцлагууд хийхийн зэрэгцээ 2014 оны 3-р сард “Дэлхийн хөгжлийн чиг хандлага: Хөгжлийн сорилтууд ба шинэ хандлага” сэдэвт тусгайлсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт яамд, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудын 30 орчим төлөөлөгч оролцов. Судалгааны санал зөвлөмжүүдийг боловсруулахдаа ганцаарчилсан ярилцлага болон хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын хэлсэн болон бичгэн хэлбэрээр авсан санал асуулгад дурдагдсан санал, зөвлөмжүүдийг нэгтгэн дүгнэсэн болно.

2. Нийгэм, эдийн засгийн өнөөгийн төлөв байдал ба тулгарч буй гол сорилтууд

Монгол Улс эдийн засгийн өсөлтөөр дэлхийд тэргүүлсээр буй билээ. 1990-ээд оны үед төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн нийгэмд шилжих үед нийгэм, эдийн засгийн сорилт бэрхшээлүүд олноор тулгарч байсан хэдий ч сүүлийн жилүүдэд улсын төсвийн орлого нэмэгдэхийн хэрээр ядуурлын түвшин буурсан үзүүлэлттэй гарч байгаа нь сайшаалтай. Гэсэн хэдий ч уул уурхайн салбараас голлон улбаатай энэхүү өсөлт нь эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчинд нөлөөлөхүйц томоохон сорилтуудыг дагуулсаар байна. Монголын ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийг дэмжихийн тулд эдгээр тулгарч буй сорилт, бэрхшээлүүдийг шийдвэрлэх урт хугацааны, үр дүнтэй арга замуудыг тодорхойлох нь чухал юм.

Үүний тулд Монгол орны байгаль экологи, эдийн засаг, нийгмийн төлөв байдал, онцлог шинжүүдийг анхааран үзүүштэй.

2.1 ТӨВ АЗИД ОРШИХ ӨРГӨН УУДАМ ГАЗАР НУТАГ БҮХИЙ, ДАЛАЙД ГАРЦГҮЙ ОРОН

Орос, Хятад хоёр гүрний дунд орших Монгол Улс нь далайд гарцгүй дэлхийн хоёр дахь том орон бөгөөд 1.564 сая кв.км газар нутагтай. Далайн түвшнээс дээш дунджаар 1,580 метрийн өндөрт орших бөгөөд газар нутгийн 81% нь далайн түвшнээс дээш 1,000 метрт оршино.¹ Умард хэсэгтээ ой тайгаар бүрхэгдсэн уулархаг газар нутагтай бол өмнөд хэсгээр говь, тал хээрийн бүсэд хамаардаг. Түүнчлэн, Монголын газар нутаг баруун талаараа Алтай, Хангайн уулсаар хүрээлэгдсэн бөгөөд зүүн хэсгээрээ зах хязгааргүй тал газар бүхий аагим дулаан цаг агаартай.²

Монголын газар нутгийн дөнгөж 0.4%-ийг үржил шимтэй гэж үздэг бөгөөд газар нутгийн ихэнх нь бэлчээрийн мал аж ахуйд ашиглагддаг.³ Уулархаг нутгаар мөнх цэвдэг элбэг ба эдгээр нь газар нутгийн 63%-ийг эзэлдэг.⁴ Түүнчлэн Монгол Улс нь эрдэс баялгийн арвин их нөөцтэй бөгөөд нүүрс, зэс, алт, молибден, хар тугалга, никель, хөнгөн цагаан, цагаан тугалга, вистумын ихээхэн нөөцтэй.

2.2. ХУР ТУНАДАС БАГАТАЙ ЭРС ТЭС УУР АМЬСГАЛ

Монголын цаг агаарын онцлог нь урт бөгөөд хүйтэн өвөл, харьцангуй богино зун, маш бага хэмжээний хур тунадаснаас бүрдэнэ. Агаарын хэм өвөлдөө -40°C хүрч хүйтрэх ба зундаа 40°C хүрэх нь бий. Улаанбаатар нь дэлхийн хамгийн хүйтэн

нийслэл гэгддэг бөгөөд өвлийн хоногийн дундаж температур нь -3.3°C.⁵

Эрс тэс, хүйтэн цаг агаартай хэдий ч Монгол нь “цэнхэр тэнгэрийн орон” гэж нэрлэгддэг ба жилд дунджаар 3,000 цаг, өдөрт дунджаар 8 цаг хурц нартай цэлмэг байдаг. Жилд унах хур тунадасны хэмжээ бага (200-220 мм), Говийн бүсэд ойролцоогоор 38.4 мм, умард бүсүүдэд 389 мм байна. Хамгийн элбэг хуртай үе нь 6-8 дугаар сар бол хамгийн хуурай үе нь 11-3 дугаар сарууд. Монголд ойролцоогоор 10 жилд 1 удаа ган болдог бөгөөд үүнээс Говийн бүс нутагт 5 жилд 1 удаа болдог гэсэн тооцоо бий.⁶

Монгол орон хэдий хатуу ширүүн уур амьсгалтай ч амьтан, ургамлын баялаг нөөцтэй. Үүнд, цасны ирвэс, хос бөхт тэмээ, мазаалай гэхчлэн ховордсон буюу нэн ховордсон ан амьтад багтана.⁷

2.3. НЯГТАРШИЛ СИЙРЭГ БОЛОВЧ ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ХҮН АМ

Монгол Улсын хүн ам 2012 онд 2.87 сая байв. Нэг кв.км газар нутагт 1.8 хүн ноогддог гэсэн үзүүлэлтээрээ Монгол Улс нь хүн амын нягтаршил хамгийн бага орнуудын нэгд ордог. Гэсэн хэдий ч хүн амын өсөлт жилийн 1.4% байгаа бөгөөд 2015 он гэхэд 3 саяд хүрэх төлөвтэй байна.⁸

2.4. ХОТЖИЛТ УЛАМ НЭМЭГДСЭЭР

Монголчууд уламжлалт нүүдлийн хэв маягаас улам бүр хөндийрч, хот суурин газар руу шилжилт хөдөлгөөн ихэссэн. Энэхүү шилжих хөдөлгөөн нь

1 Тортелл. (2008). Монгол орны байгаль орчны менежментийн тогтолцоо. Хуудас-10

2 Мөн адил.

3 Үржил шимт газар нутаг гэдэг нь Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас тодорхойлсоноор газар тариалан эрхэлж буй болон эрхлэхэд тохиромжтой газар.

4 Н.Чойбалсан (1998). Монгол дахь мөнх цэвдэг, ул хөрсний шинж чанар

5 Climateps.com (2013) Монгол Улс, Улаанбаатарын агаарын дундаж температур.

6 Тортелл. (2008). Монгол орны байгаль орны менежментийн тогтолцоо.


7 Мөн адил, X-11.

8 Үндэсний статистикийн хороо (2013). 1212 Мэдээллийн сан.

1924-1992 онуудаас эхтэй бөгөөд 1963 онд нийт хүн амын 60% нь орон нутагт, 40% нь хот суурин газар амьдарч байв. Харин 1993 гэхэд хүн амын дөнгөж 44% нь орон нутагт амьдарч байв. Нэн ялангуяа сүүлийн жилүүдэд хотжилт хөдөлгөөн эрс нэмэгдэж, хүн амын 3-ны 2 буюу 1.9 сая хүн хот суурин газар ажиллаж, амьдарч байна.⁹

Нийслэл Улаанбаатар хотын хүн ам 1993 онд 0.87 сая байсан бол 2012 онд 1.32 сая болж, 20 хүрэхгүй жилийн дотор 40%-иар өсчээ (Зураг 2). Хүн амын 46% нь Улаанбаатарт төвлөрсний улмаас тус хотын ачаалал өдрөөс өдөрт нэмэгдэж байна.¹⁰ Нэн ялангуяа, замын түгжрэл, агаарын бохирдол, дэд бүтцийн доройтол зэрэг ужиг асуудлууд тулгараад байна.

Зураг 2: Монгол Улсын хүн ам



Эх үүсвэр: Статистикийн бюллетень: УСХ, Улаанбаатар болон бусад хот суурин газруудын хүн ам 1989 оноос өмнө.

Хот руу чиглэсэн нүүдлийн бас нэгэн шалтгаан нь цаг агаарын таагүй нөхцөл байдал юм. Зарим өвөл онцгой хүйтэрч, зуд болсны улмаас зузаан цас, мөсөн бүрхүүл тогтон саяар тоологдох толгой мал хорогддог. 1999-2002 онуудад дараалан 3 жил тохиосон зудын уршгаар 11 сая толгой мал хорогджээ.¹¹ Үүний дараа 2009-10 онд дахин зуд болоход олон малчид нутгаа орхихоос өөр аргагүйд хүрсэн. Зөвхөн 2009-2010 онд л гэхэд хот суурин газрын хүн ам 7.8%-иар өсч, 1.77 саяас 1.91 сая болсон.¹²

Үүний зэрэгцээ эдийн засгийн өсөлтөөс үүсэн гарч буй боломжууд нь хот суурин газрыг зорих өөр нэгэн шалтгаан болж байна. Шилжин ирэгсдийн ихэнх нь орон сууцанд орох боломжгүйгээс гэр хороололд буюу “хагас нүүдлийн” байдалтайгаар амьдарч байгаа юм. Улаанбаатар хотын хүн амын 40-45% нь л орон сууцанд амьдардаг гэсэн тооцоо бий.

9 Үндэсний статистикийн хороо (2013). 1212 Мэдээллийн сан.

10 Мөн адил.

11 Үндэсний статистикийн хороо (2013). 1212 Мэдээллийн сан.

12 Мөн адил.


2.5. ЭДИЙН ЗАСГИЙН ХУРДАЦТАЙ ӨСӨЛТ

Сүүлийн жилүүдэд Монгол Улс эдийн засгийн өсөлтийн хурдаар дэлхийд тэргүүлэгчдийн нэг болсон. Дэлхийн эрдэс баялгийн хамгийн том хэрэглэгч болох Хятадтай хөрш зэргэлдээ байрлал нь Монгол руу хөрөнгө оруулалтын урсгалыг татаж, нэн ялангуяа уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт огцом нэмэгджээ. 2011 онд ДНБ-ний бодит өсөлт 17.4%, 2012 онд 12.6% байв (Зураг 3).¹³

Олон улсын валютын сангаас Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг ирэх таван жилийн турш жилд дунджаар 8.5%-ийн байна гэж таамаглаж байна.¹⁴

Нэг хүнд ноогдох ДНБ арван жилийн дотор 6 дахин өсч, 2002 онд 524 ам.доллар байсан бол 2012 онд 3342 ам.доллар болсон ба Дэлхийн банкнаас Монголыг дунджаас доогуур орлого бүхий орнуудын тоонд албан ёсоор оруулжээ.¹⁵ Мөн Дэлхийн банкны тооцоогоор ядуурлын түвшин 2010 онд 38.7% байснаас 2012 онд 27.4% болж буурсан байна.¹⁶ Хөрөнгө оруулалтаас гадна өрхийн хэрэглээний түвшин нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлсөн бас нэгэн хүчин зүйл болжээ. (Зураг 3).

Зураг 3: ДНБ-ий өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо. *ОУВС-гийн тооцоо, Дэлхийн эдийн засгийн төлөв байдал 2013 оны 10 дугаар сар.

Хүн амын орлого нэмэгдэхийн хэрээр хэрэглээ мөн нэмэгдсэн. Нийт цалингийн хэмжээ 2013 оны 3 дугаар сар хүртэлх 1 жилийн дотор 40% орчмоор өссөн. Ялангуяа эрэгтэйчүүдийн орлого ихэд нэмэгдсэн бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд 25.2%-иар өссөн бол эмэгтэйчүүдийнх 19.9%-иар өсчээ.¹⁷

13 ОУВС-ийн тооцоо, Дэлхийн эдийн засгийн төлөв байдал 2013 оны 10 дугаар сар

14 Мөн адил.

15 Дэлхийн банк (2013). Улс орнууд болон зээлдүүлэгч бүлгүүд

16 Дэлхийн банк (2013). Ядуурлын түвшин 2012 онд 27.4% болж буурлаа. Ядуурлын түвшинг 2010 онд хийгдсэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны өгөгдлөөс гаргасан амьдралын баталгаажих түвшинд үндэслэн тооцсон болно.

17 Үндэсний статистикийн хороо (2013). 1212 Мэдээллийн сан.

Уул уурхайн салбараас улбаатай ажил эрхлэлтийн байдал мөн сайжирч, 2009-2012 онд 90,000 ажлын байр шинээр бий болсон байна. 2009 оны 12 дугаар сард ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр буюу 12.8%-д хүрсэн. Түүнээс хойш нөхцөл байдал аажмаар сайжирч 2012 оны 6 дугаар сард 6.3%-д хүрсэн хэдий ч сүүлийн жил орчмын хугацаанд ажиглагдаж буй эдийн засгийн хүндрэлийн улмаас бага зэрэг өсч 2013 оны 6 дугаар сард 7.3% болжээ. Гэвч Дэлхийн банкны зүгээс албан ёсны тоон үзүүлэлтүүд хөдөлмөрийн зах зээл дээрх бодит нөхцөл байдлыг илэрхийлж чадах эсэхэд эргэлзэж, уул уурхайн салбараас цомхотгогдсон ажиллах хүч зөвхөн улирлын чанартай барилга, бүтээн байгуулалтын ажил, эсвэл бүр албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрээр шингэсэн байх магадлалтай хэмээн үзэж байгааг анхаарууштай (худалдааны мухлаг, гудамжны наймаа г.м).¹⁸

2.6. УУЛ УУРХАЙН САЛБАРААС ХАМААРАЛТАЙ БАЙДАЛ

Монголын эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай болжээ. Уул уурхай, ил олборлолт бодит ДНБ-ий 18,5%-тай тэнцэж байсан бол аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар 14,4% орчмыг эзэлж байв. Эрдэс баялаг, эрчим хүчний түүхий эд 2013 онд Монголын нийт экспортын 81,9%-ийг эзэлж байсан ба дийлэнх нь Хятад руу гарчээ (Зураг 4). Төсвийн орлого мөн уул уурхайгаас ихээхэн хамааралтай бөгөөд тус салбар төсвийн орлогын 40% орчмыг дангаараа бүрдүүлдэг байна.¹⁹

Уул уурхайн хамгийн том төслүүд нь зэс, алтны Оюу толгой уурхай болон нүүрсний Таван толгой уурхай бөгөөд аль аль нь Өмнөговь аймагт оршдог. Энэ хоёр төслийн цар хүрээ өргөн, Монголын эдийн засагт үзүүлэх нөлөө туйлын их. Оюу толгойн бүтээн байгуулалт 2009 оноос эхэлсэн бөгөөд нийт өртөг нь 6.6 тэрбум ам.долларт хүрсэн гэсэн тооцоо бий. Түүнчлэн 2020 он гэхэд тус уурхай нь Монголын ДНБ-ийг 36.4%-иар, нэг хүнд ноогдох ДНБ-ийг хамгийн багадаа 34%-иар өсгөнө гэсэн тооцоог эдийн засгийн загварууд харуулж байна.²⁰

Зураг 4: Нийт экспортын бүтэц, 2012

Эх сурвалж: УСХ, 1212 Мэдээллийн сан.



Дээрх хоёроос гадна хэрэгжиж буй уул

уурхайн өөр төслүүд ч олон бий. Тухайлбал олон жилийн туршид Монголын эдийн засгийг тэтгэсэн гэгддэг их бүтээн байгуулалт “Эрдэнэт” үйлдвэр өнөө хэр эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Үүний зэрэгцээ, 2013 оны 12 дугаар сарын байдлаар 1753 аж ахуйн нэгж 17.5 сая га газрыг хамарсан 3285 уул уурхайн лиценз эзэмшиж байв. Үүнээс 908,900 га буюу лицензэд хамрагдсан газар нутгийн 11.2%-д эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагаа идэвхтэйгээр явагдаж байгаа бол 16.6 сая га газар буюу 10.6%-д ирээдүйд үйл ажиллагаа явуулахаар лиценз олгожээ.²¹

Өргөн цар хүрээ бүхий эдгээр төслүүдээс гадна жижиг хэмжээний уул уурхай болон гар аргын олборлолт ихээр явагддаг. Гар аргаар олборлогчдын дийлэнх нь (80-90%) алт олборлодог бол үлдсэн хэсэг нь ихэвчлэн том уурхайн хаягдсан цооногийг ашиглан жонш, нүүрс олборлодог.

“Нинжа” хэмээн нэрлэгддэг жижиг хэмжээний болон гар аргын олборлолтын оргил үе 2003 оны хавьцаа байсан гэсэн судалгаа байдаг бөгөөд энэ үед 100,000 хүн энэ аргаар хөдөлмөр эрхэлж байсан нь орон нутгийн ажиллах хүчний 20%-тай тэнцэж байв. Энэхүү үйл ажиллагааны ихэнх нь 1999-2002 онд эхэлж, энэ жилүүдэд дараалан тохиосон зудын дараа амьжиргааны эх үүсвэрээ алдсан малчдын орлогын эх үүсвэр болсон байна. Төрөөс жижиг хэмжээний олон уурхайг хаасан, мөн мөнгөн ус ашиглан боловсруулалт хийхийг хориглосноор энэ салбарт ажиллагсдын тоо 2008 оны байдлаар 54,000-д хүрч буурчээ.²² Одоогийн байдлаар жижиг хэмжээний хэдэн уурхай үйл ажиллагаа явуулж буй нь тодорхойгүй байна.

2.7. ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД

Ийнхүү нэг салбараас хэт хамааралтай байдал нь Монголын эдийн засаг дэлхийн зах зээл дээрх эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлд хэт мэдрэмтгий, огцом өсөлт уналт бүхий циклд орох эрсдэл нүүрлэж байна. Үүний улмаас гадаад худалдааны тэнцвэр ч ихээхэн алдагдсан.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, гадаад худалдааны алдагдал ихэссэн нь үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг үнэгүйдэж, инфляц хөөрөгдөхөд хүргэсэн.

Үүний зэрэгцээ гадаад худалдааны голлох түнш Хятад улсын түүхий эд, тэр дундаа нүүрсний эрэлт буурч эдийн засгийн өсөлтийн хурд нь харьцангуй саарсан нь Монгол Улсын эдийн засагт сөргөөр нөлөөлсөн. Экспортын орлого 2013 оны 8 дугаар сар хүртэлх нэг жилийн дотор 6%-иар буурч, түүний дотор нүүрсний экспорт огцом буурчээ

21 Ашигт малтмалын газар (2013). Уул уурхайн салбарын статистик мэдээ, 2013 оны 8-р сар.

22 Пүрэвжав, Болормаа (2011). Жижиг хэмжээний уул уурхай, гар аргын олборлолт, Бүлэг 11, АИС.

18 Дэлхийн банк (2013). 11 дүгээр сарын Эко мэдээлэл, Хуудас 19

19 НУБХХ (2013). Монголын тухайд.

20 Б. Фишер, (2011).

(мөн жилд 44%-иар унасан). Гадаадын хөрөнгө оруулалт 2012 оны эхний хагаст 43%-иар унаж, сүүлийн 2 жилд төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 27%-иар суларсан байна.²³

Түүнчлэн, хэрэглээний үнийн индексийн өсөлт 2012 онд 15%, 2013 онд 11%-д хүрчээ.²⁴ Дундаж буюу бага орлоготой иргэдийн орлогын түвшний өсөлт инфляцын хурдыг гүйцэж чадаагүйн улмаас энэхүү үнийн өсөлт нь баян ядуугийн ялгааг улам гааруулж, орлогын тэгш бус байдал газар авсаар байна.

Цалин нэмэхийн зэрэгцээ их хэмжээгээр бэлэн мөнгө тараасны улмаас Засгийн газрын зардал 2011 онд урьд өмнө байгаагүй өндөр хэмжээ буюу ДНБ-ий 44.2%-д хүрчээ. 2012 онд шинээр сонгогдсон Засгийн газар зардлаа танаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан ДНБ-ий 2%-ийн босгыг баримтална гэж амласан. Гэсэн хэдий ч төсөв 2013 оны 6 дугаар сараас дахин алдагдалд орж, ДНБ-ий 47%-д хүрэх төлөвтэй байна. Нэн ялангуяа бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтэд зориулан олон улсын зах зээлд гаргасан 1.5 тэрбум ам.долларын “Чингис” бонд зэрэг их хэмжээний гадаад өрийг Засгийн газрын зардалд албан ёсоор оруулахгүй байгаа гэдгийг харгалзан үзэх аваас энэ тоо ихээхэн нэмэгдэх юм.²⁵

Уул уурхай, ханган нийлүүлэлтийн компаниуд дотоодын чадварлаг ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс харьцангуй өндөр цалин амлаж байна. ЭЗБӨЧСТ-өөс 2012 онд гаргасан “Удирдах ажилтны санаа асуулга”-с харахад мэдээллийн технологи, санхүүгийн өндөр мэдлэг чадвар бүхий ажилчдын хүрэлцээ хангалтгүй бөгөөд мэргэжлийн инженер, ахлах түвшний менежерүүдийг олоход хэцүү байдаг гэж гарчээ.²⁶


Үүний зэрэгцээ тэгш бус байдал газар авсаар байна. Тодруулбал нийслэл (1) Улаанбаатар хот, Эрдэнэт, Дархан зэрэг хот суурин газрууд, (2) Оюу толгой, Таван толгойн орд газруудыг тойрсон эрдэс баялаг арвинтай бүс нутаг болон (3) өнөөг хүртэл харьцангуй буурай хөгжилтэй байгаа хөдөө, орон нутаг хэмээн хуваагдсан өөр хоорондоо адилгүй дүр зургууд харагдаж байна. ЖИНИ (GINI) коэффициент буюу орлогын тэгш хуваарилалт ба бодит орлого хоорондын зөрүү 1990-ээд онд 33.2 байсан бол 2008 онд 37 болж өсчээ.²⁷ Цаашилбал, хөдөө орон нутагт ядуурал харьцангуй өндөр буюу

оршин суугчдын 36% нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой байхад хот суурин газарт 23% байна.²⁸

Уул уурхай, бизнесийн үйлчилгээний салбарт ажилладаг олон монголчуудын амьдрал сайжирч буй хэдий ч бусад олон хүнд энэ боломж олдохгүй байна. Хэдий энэ салбар ДНБ-ий томоохон хэсгийг бүрдүүлдэг ч, нийт ажиллах хүчний дөнгөж 4% буюу 47,000 хүнийг ажлын байраар хангадаг (Зураг 5).

Үүний зэрэгцээ, нийт ажиллах хүчний 35% буюу 370,000 хүн хөдөө аж ахуйн салбарт ажилласаар байна.²⁹ Уламжлалт мал ахуйгаас хамаарах энэхүү хамаарал нь зарим талаар 1990-ээд онд төрийн өмчит үйлдвэрийн газрууд татан буугдсаны дараа малчид, малын тоо хэмжээ өссөнтэй холбоотой гэхэд болно.

Зураг 5: Ажил эрхлэлт салбараар, 2012



Эх сурвалж: YCX, 1212 Мэдээллийн сан.

Түүнээс гадна хөдөлмөрийн зах зээл дээр хүйсийн тэгш бус байдал давамгайлсаар байна. Дэлхийн банкнаас үзэж буйгаар нэн ялангуяа ажил үүргийн төрлүүдэд хүйсийн тэгш бус байдал илүүтэй ажиглагдаж байгаа ба эмэгтэйчүүд голлон цэвэрлэгээ хийх, жижиг мухлаг ажиллуулах зэрэг албан бус, үнэлгээ багатай ажил хөдөлмөр эрхэлж байна. Бүрэн дунд болон дээд боловсрол эзэмшигчдийн дунд эмэгтэйчүүд зонхилдог хэдий ч дээд түвшний удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй бага хэвээр байгаа юм.³⁰

Тэгш бус байдал газар авсаар байгаа ч хүний хөгжилд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүд тэдгээрийн үр дүн сайжирч байна. Монгол Улсын хүний хөгжлийн индекс буюу наслалт, боловсрол, орлогыг хамруулсан дундаж үзүүлэлт 1985-2012 оны хооронд 0.536-аас 0.675 болж (26%-иар) өсчээ. Гэсэн хэдий ч Монголын дундаж оноо бүс нутгийн дундаж болох 0.683-аас доогуур хэвээр байгаа ба 187 орноос 108-д жагсч байна.³¹

23 Үндэсний статистикийн хороо (2013). 1212 Мэдээллийн сан. Бюллетень: Шинжээчид 2012 оны Стратегийн ач холбогдол бүхий ААН дэх гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг ГШХО-ын уналтад нөлөөлсөн гэж үзэж буй бөгөөд, үүнд Оюу толгойн 2 дугаар шатны үйл ажиллагаа гацаад байгаа ч мөн холбоотой.

24 Мөн адил.

25 Дэлхийн банк (2013). Монголын эдийн засгийн тайлан.

26 ЭЗБӨЧСТ (2012), Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан

27 АХБ (2012). Азийн хөгжлийн дүр зураг 2012: Ази тив дэх өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлыг шийдвэрлэх арга замууд. Хуудас -47.


28 Дэлхийн банк (2013). Мэдээллийн сан

29 Үндэсний статистикийн хороо (2013). 1212 Мэдээллийн сан.

30 Дэлхийн банк (2013) Монгол: Хүйсийн тэгш бус байдал...

31 НҮБХХ (2013). Монгол Улс: ХХИ-ийн үзүүлэлтүүд.

Зураг 6: Нярайн эндэгдэл ба дундаж наслалт



Эх сурвалж: YCX, 1212 Мэдээллийн сан.


Шилжилтийн үеэс хойш эрүүл мэндийн салбарт олон ахиц дэвшил гарсан. Тухайлбал, 1000 амьд төрөлт тутам дахь нярайн эндэгдэл 1990 онд 65.4 байсан бол 2012 онд 15.5 болж буурчээ. Түүнчлэн 1980-2012 оны хооронд дундаж наслалт 11.2 жилээр өсч, 57.3-68.5 болжээ (Зураг 6).³²

1990-ээд оноос хойш үндэсний дархлаажуулалтын хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлсний дүнд халдварт өвчин нас баралтын голлох 5 шалтгааны нэг байхаа больжээ. Харин зүрх судас, хорт хавдар, осол гэмтэл зэрэг амьдралын хэв маяг, зан үйлтэй холбоотой өвчнүүд өвчлөлт, нас баралтын үндсэн шалтгаан болсон байна.³³

Хэдийн тийм боловч энэ салбарт бодлого, зохицуулалтын илүү боловсронгуй орчин, шинэ дэвшилт технологи, хөрөнгө оруулалт үгүйсгэгдэж байна.

Өнөөдөр Монгол Улсад хүн амын өсөлтийн нэн таатай цонх үе тохиож байгаа бөгөөд хөдөлмөрийн насны хүний тоо тэтгэврийн насны хүмүүсээс хол давж байна. 2012 онд Монголын нийт хүн амын 69%-ийг 15-64 насныхан эзэлж байсан бөгөөд 47% нь 25-аас доош настай байв (Зураг 7). Энэхүү залуу ажиллах хүч ирэх олон жилийн туршид эдийн засгийн өсөлтийг хангана. Гэсэн хэдий ч ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байгаа.

Зураг 7: Монголын хүн амын пирамид 2012 онд



Эх сурвалж: YCX, 1212 Мэдээллийн сан.

32 Үндэсний статистикийн хороо (2013). 1212 Мэдээллийн сан.

33 Ази, Номхон далайн эрүүлийг хамгаалах тогтолцоо, бодлогын ажиглалт. (2013). Монгол Улсын эрүүлийг хамгаалах тогтолцоонд хийсэн дүн шинжилгээ.

Боловсрол салбарт ч мөн ахиц дэвшлүүд ажиглагдсан. 1980-2012 онд сургуульд хамрагдах дундаж хугацаа 2.6 жилээр өссөн. Бичиг үсэг тайлагдсан насанд хүрэгсдийн тоо 2010 онд 97.4% байсан нь дэлхийн дундаж 84.1%-аас өндөр байв.³⁴

Монгол Улсад тулгарч буй хамгийн том бэрхшээлүүд нь ихэвчлэн дэд бүтцийн хөгжил хангалтгүй байгаатай шууд хамааралтай байна.

Эрчим хүч: Өнөөгийн байдлаар Монгол Улс 922 мега ватт эрчим хүчний үйлдвэрлэх чадавхтай. Үүний ихэнхийг буюу 91.6%-ийг дулааны цахилгаан станцуудад (ДЦС) нүүрс ашиглан үйлдвэрлэдэг бол 3.1%-ийг усан цахилгаан станцаас, 5.1%-ийг дизель цахилгаан станцуудаас, 0.1%-ийг сэргээгдэх эх үүсвэрээс (нар, салхи) гаргаж авдаг байна.³⁵ Дан Улаанбаатар хотод л гэхэд 4 ДЦС байдаг.

Улаанбаатарт шинээр баригдаж буй барилгууд ихэвчлэн холбогдох зөвшөөрөлгүйгээр цахилгааны сүлжээнд холбогдсон байдаг. Үүний зэрэгцээ эрчим хүчний эрэлт огцом өссөний улмаас нийтийг хамарсан доголдол, саатал гарах эрсдэл бий болоод байна. Монгол Улс эрэлт нийлүүлэлтийнхээ энэхүү зөрүүг арилгахын тулд эрчим хүчний нийт хэрэглээнийхээ 7.6%-ийг импортолдог ба 2014 он гэхэд хэрэглээгээ нийтэд нь дотоодоос хангадаг болохыг зорьж байгаа юм.³⁶ Эрчим хүч хэрэглээний ашигт байдал муу, түгээх сүлжээ хоцрогдсон учир аж үйлдвэрийн зориулалтын эрчим хүчний хэрэглээ дэлхийн дунджаас 7 дахин өндөр байдаг аж.³⁷

Хурдтай өсөн нэмэгдэж буй эрэлтээ хангахын тулд Монгол Улс ойрын хугацаанд эрчим хүчний үйлдвэрлэлээ яаралтай нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. Эрчим хүчний яамны тооцоолсноор 2030 он гэхэд Монголын нийт эрчим хүчний хэрэгцээ 3,800 мега ваттад хүрэх ба энэ эрэлтийн гуравны нэгийг уул уурхайн салбар дангаараа эзлэх аж.³⁸ Хэдийгээр сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлт нэмэгдэх хандлагатай боловч, ирээдүйд эрчим хүчний хэрэглээний ихэнхийг нүүрснээс гаргаж авах төлөвтэй байна. Ирэх 5-10 жилийн хугацаанд шинээр 15 нүүрсний цахилгаан станц байгуулахаар яригдаж байгаа юм. Гурав болон Дөрөвдүгээр дулааны цахилгаан станцыг өргөтгөх, түүнчлэн Улаанбаатарт Амгалангийн буюу 5 дугаар ДЦС-ыг нэмж байгуулах, Таван толгойн нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станц байгуулах асуудлууд яригдаж байна.³⁹

34 НҮБХХ(2013). Монгол Улс: ХХИ-ийн үзүүлэлтүүд, 2013 оны ХХИ-д гарсан өөрчлөлтүүд

35 П.Товуудорж (2013). Монголын эрчим хүчний үндэсний хөтөлбөр, бодлогын арга хэмжээнүүд: Дэд бүсүүдийн хүрээнд ...

36 Б.Хаш-Эрдэнэ (2013). Mongolia to be energy self-sufficient by 2014, says minister. UB Post.

37 YCX, Статистикийн жилийн тайлан, 2012

38 П.Товуудорж (2013).

39 Мөн адил.

Тээвэр: Өргөн уудам газар нутаг, тархан суурьшсан хүн амтай Монгол Улсын хувьд тээврийн тогтолцооны буурай хөгжил нь өрсөлдөх чадвар, хөгжил дэвшлийг хойш чангааж байна. Авто зам, төмөр зам, агаарын тээврийн үйлчилгээ бүгд томоохон хотууд болон бүс нутгийн төвүүдээр хязгаарлагдаж байгаа юм. Нийт авто замын 92% орчим нь шороон зам бол засмал, сайжруулсан зам нийлээд дөнгөж 8%-тай тэнцэж байна.⁴⁰ Ази тивийн бусад орнуудтай харьцуулахад авто болон төмөр замын нягтрал өндөр хэдий ч хамрах талбайн хэмжээ бага. Энэ нь цөөн, тархай бутархай суурьшсан хүн амтай, өргөн уудам газар нутаг бүхий оронд тулгардаг нийтлэг сорилт гэхэд болно.

Ус, хог хаягдлын дэд бүтэц: Монгол дахь ус, бохирын шугам сүлжээний нягтаршил Азидаа хамгийн багад ордог бөгөөд үүнээс үүдэлтэй хөрс, усны бохирдлын асуудлууд тулгамдаж байна. 2000 онд нийт хүн амын 49% нь цэвэр усаар хангагдаж бохир ус татан зайлуулах төвлөрсөн шугамд холбогдож үйлчилгээ авч байсан нь 2012 онд 53% болж багахан өсжээ. Хот суурин газар, хөдөө орон нутаг дахь ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүртээмжийн ялгаа улам бүр ихэссээр байгаа бөгөөд 2011 онд хөдөө орон нутгийн иргэдийн дөнгөж 29% нь цэвэр усны хангамж, бохир ус татан зайлуулах үйлчилгээгээр үйлчлүүлж байсан бол энэ үзүүлэлт хот суурин газарт 64% байв. Нэн ялангуяа гэр хороолол дахь нүхэн жорлонгийн хэрэглээ томоохон асуудал дагуулж буй бөгөөд нүхэн жорлонгийн урсгал ундны үсны эх үүсвэрийг бохирдуулах эрсдэлтэй байдаг.⁴¹

Сүүлийн жилүүдэд ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хүртээмж харьцангуй сайжирч, 2000 онд хүн амын 65%-ийг хангаж байсан бол 2011 онд 85% болж өсжээ. Гэсэн хэдий ч өмнөхийн нэгэн адил хот, хөдөөгийн эрс тэс ялгаа хэвээр байгаа бөгөөд хот суурин газрын бараг бүх хүн ам, харин хөдөө орон нутгийн иргэдийн дөнгөж 53% сайжруулсан эх үүсвэрээс ундны усны хэрэглээгээ хангаж байв. Цаашилбал, хот суурин газарт ч иргэдийн дөнгөж 26% нь төвлөрсөн шугам сүлжээгээр дамжуулан цэвэр усны хэрэглээгээ хангадаг байна.⁴²

Хатуу хог хаягдлын менежмент мөн адил хангалтгүй гэж үздэг ч чухам хэр хэмжээний хог хаягдал үлдээж байгааг тодорхойлоход бэрх. ДЭМБ-ын судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотын нийт хог хаягдлын 75%-ийг нийслэлийн мэдлийн хогийн машинууд, 15%-ийг байгууллагууд өөрсдийн машинаар, харин 5-10%-ийг цуглуулалгүй үлдээж байгаа гэжээ. Энэ үлдсэн хог хаягдал хотын гудамж, зам талбай, усны даланг бохирдуулан үлддэг байна.⁴³

40 АХБ (2008), Тээвэр, худалдааны нөхцөл.

41 ДЭМБ ба НҮБ-ын Хүүхдийн сан (2013). Хуудас -24

42 Мөн адил. Хуудас -25

43 Д.Алтантуяа (2012).

2.8. ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ТУЛГАРЧ БҮЙ ГОЛ АСУУДЛУУД

(1) Агаарын бохирдол

Монгол Улс хот суурин газрын агаарын бохирдлын хэмжээгээр дэлхийд тэргүүлж байна. ДЭМБ-ын мэдээллийн сангаас үзвэл, 2008 онд Улаанбаатарын агаар дахь PM_{10} буюу том ширхэгт тоосонцорын агууламж дэлхийд доороосоо 3 дугаарт орж, олон улсын жилийн дундаж 71-ээс маш өндөр буюу 279 байв. Харин агаар дахь $PM_{2.5}$ буюу нарийн ширхэгт тоосонцорын агууламжаар дэлхийд сүүл мушгисан бөгөөд олон улсын жилийн дундаж 11 байхад Улаанбаатар хотын мөн үзүүлэлт 63.0 байсан байна.⁴⁴

Хотын төвийн хэсэг болон захын гэр хорооллын агаарын бохирдлын түвшин харилцан адилгүй. Гэр хорооллын агаарын бохирдлын түвшин Монгол Улсын Агаарын чанарын стандартад заасан хэмжээнээс 35 дахин өндөр байх нь бий. (АЧС) (Хүснэгт 1).

Хүснэгт 1: Улаанбаатар хотын агаар дахь нарийн ширхэгт тоосонцорын агууламжийн жилийн дундаж хэмжээ, 2008.06– 2009.05

Хэсэг	PM_{10} микрометр/ м ³		Хэтрэлт: АЧС-д заасан хэмжээтэй харьцах харьцаа	
Хотын төв	150-250	75-150	3-6	7-15
Гэр хороолол	350-700	200-350	7-14	17-35

Эх сурвалж: Дэлхийн банкны судалгаанаас тооцож гаргав (2011), X-14

Агаарын бохирдлын хамгийн том бохирдуулагч нь гэр хорооллын галлагааны зуух болон бойлуурүүд болон цахилгаан станцууд, авто машин байна. Гэрийг халаалтад хэрэглэдэг нүүрсэн галлагаатай зуухны утааны улмаас өвлийн улиралд агаарын бохирдол онцгой их байдаг. Дэлхийн банкнаас 2011 онд хийсэн судалгаагаар Монголын АЧС-д заасан үзүүлэлтэд хүрэхийн тулд гэр хорооллоос ялгаруулж буй бохирдуулагч (тоос, бойлуурын хийн ялгаралт)-ийг 94%-иар бууруулах шаардлагатай гэжээ.⁴⁵

Тоосонцорын агууламж өндөр байх нь эрүүл мэндийн томоохон эрсдлийг дагуулдаг. Улаанбаатар хотын Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс гаргасан судалгааны дагуу амьсгалын замын өвчнөөр өвчлөгсдийн тоо 2004-2008 оны хооронд 45%-иар нэмэгдсэн байна. Түүнчлэн 2011 онд Бритиш Колумб дахь Саймон Фрэйзерийн их сургуулиас хийсэн судалгаанд

44 ДЭМБ (2013). Мэдээллийн сан: Хот суурин газрууд дахь агаарын бохирдол.

45 Дэлхийн банк (2011). Улаанбаатар хотын агаарын чанарын шинжилгээ.

Улаанбаатар хот дахь 10 нас баралт тутмын 1-ийг агаарын бохирдолтой холбоотой гэж үзэж болно гэжээ.⁴⁶ ДЭМБ ч мөн Улаанбаатар хот дахь нас баралтын 9% (шууд)-иас 15% (шууд бус) нь агаарын бохирдолтой холбоотой гэсэн байна. Энэ бүхний зардлыг мөнгөн дүнгээр тооцоход 500 сая ам.доллар буюу Улаанбаатар хотын ДНБ-ий 20%-тай тэнцэж байна.⁴⁷

(2) Уур амьсгалын өөрчлөлт

Монгол орны агаарын температур 1940-2008 оны хооронд 2.14оС-ээр нэмэгдсэн нь агаарын температурын дэлхийн дундаж өсөлт болох 0.74оС-аас даруй 3 дахин өндөр юм.⁴⁸ Хөгжиж буй олон орны нэгэн адил Монголын нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт хурдацтай өсч, нэг хүнд ноогдох хэмжээ нь 2000 онд 3.1 тонн байсан ч 2010 онд 4.2 тонн болж 10 жилийн дотор 35%-иар нэмэгджээ. Гэсэн хэдий ч 2010 онд Монгол Улс дэлхийн хэмжээнд ялгаруулж буй нүүрстөрөгчийн хийн дөнгөж 0.03%-ийг эзэлж байсан бөгөөд нэг хүнд ноогдох нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтаар 80 дугаарт жагссан байна.⁴⁹

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цөлжилт эрчимтэй явагдаж, гол нуурууд ширгэн, мөсөн гол хайлж, мөнх цэвдэг нимгэрэх зэрэг олон сөрөг үзэгдэл гарч байна. Энэ нь эргээд газар тариалан, мал аж ахуйд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ цаг агаарын төлөв байдалд нөлөөлж, улирал хоорондын огцом хэлбэлзлийг бий болгон, “зуд” зэрэг цаг агаарын гамшигт үзэгдлийн давтамжийг ихэсгэж байх магадлалтай юм.

(3) Уул уурхайн үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд учруулж буй сөрөг нөлөөлөл

Уул уурхайн үйл ажиллагаа Монголын хөдөө нутагт ихээхэн хор хохирол учруулсан. Үүнийг нэг талаас хүрээлэн буй орчны хамгааллын стандарт, хууль журмыг хэрэгжүүлж, мөрдүүлэх чадавх хангалтгүйтэй холбоотой гэхэд болно. Өргөн цар хүрээтэй уул уурхайн ажиллагаа хүрээлэн буй орчныг эвдэж сүйтгэхийн хажуугаар жижиг хэмжээний уул уурхайн үйл ажиллагаа, гар аргын олборлолтод мөнгөн ус, цианит зэрэг химийн хорт бодисыг хараа хяналтгүй ашигласны улмаас байгаль орчинд асар их хор хөнөөл учруулж байна.

Дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслээр саяхан мэдээлснээр Засгийн газрын нэгэн шалгалтаар уул уурхайн үйл ажиллагаа явуулсан 22,752 га газраас 4,256 га-д нөхөн сэргээлтийн ямар нэг үйл ажиллагаа явуулалгүй орхисон

байгааг илрүүлжээ. Зөвхөн 9,100 га газарт ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээлт хийгдсэн бөгөөд түүнээс 4,175 га-д нь бактери, ургамал ногоо зэрэг агент ашиглан бохирдуулагч бодисыг саармагжуулах, бүр мөсөн арилгах био-нөхөн сэргээлт хийгдсэн байна.⁵⁰

Уул уурхайн бүс нутагт оршин суудаг малчид хэт тоосжилт, усны бохирдол, бэлчээрийн доройтолд нэрвэгдэх явдал гарсаар байна. Жишээлбэл, Өмнөговь аймгийн зарим малчид Оюу толгойн уурхайн улмаас үржил шим дорой нутагт шилжин суурьшихаас өөр аргагүйд хүрсэн. Эдгээр малчид нөхөн төлбөр авсан хэдий ч хангалттай хэмжээнийх байгаагүй гэж үзэх нь бий.⁵¹

Монголын нийт газар нутгийн 25% төдийд геологийн судалгаа хийгдсэн ч уул уурхайн олон орд илэрч, өнөөдөр олборлолтын ажиллагаа харилцан адилгүй түвшинд явагдаж байна. Цаашид уул уурхайн ажиллагаа нэмэгдэхийн хэрээр хүрээлэн буй орчинд хор хохирол учруулсаар байх магадлал өндөр юм.⁵²

(4) Бэлчээр болон хөрсний доройтол, цөлжилт

Монголын тал хээр нутаг дэлхийд унаган төрхөөрөө үлдсэн цөөн бэлчээрийн эко системийн нэг хэдий ч сүүлийн жилүүдэд ихээхэн доройтжээ. Хиймэл дагуулын зураглал ашиглан гүйцэтгэсэн судалгаагаар 1988-2008 оны хооронд Монголын хээр тал бараг бүхэлдээ биомассын алдагдалд орсон байна. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас саяхан хэвлэсэн цөлжилтийн атласт Монголын нийт газар нутгийн 77.8% нь ямар нэг хэмжээгээр цөлжилтөд өртсөн бөгөөд дахин 10% нь цөлжилтөд өртөх өндөр эрсдэлтэй хэмээсэн нь 2006 онтой харьцуулахад 2-3%-иар өсжээ.⁵³ Монголын хээр тал, төвийн бүсийн нутаг дэвсгэр цөлжилтөд хамгийн ноцтой өртсөн бөгөөд нөхөн сэргээлт яаралтай хийх шаардлагатай байна.

Бэлчээрийн доройтол уур амьсгалын өөрчлөлт эсвэл бэлчээрийн даац хэтэрсэнтэй, үгүй бол аль алинаас хамаарсан эсэх талаар судлаачид харилцан адилгүй байр суурь баримталж байна. Тухайлбал, Хилкер тэргүүтэй судлаачид (2008) бүс нутаг бүрийн бэлчээрийн доройтлын шалтгаан харилцан адилгүй ч, өвс ургамлын доройтлын 80% орчим, нэн ялангуяа томоохон суурин газрын ойр орчим дахь малын тоо өссөнөөс үүдэлтэй гэж дүгнэжээ.⁵⁴ Хэдийгээр ургамлын бүрхүүл сайтай

50 - (2012). 4,256 га газар нутаг уул уурхайн үйл ажиллагааны улмаас сүйтгэгджээ, News.mn, 2013 оны 4 дүгээр сарын 11. Анхны эх үүсвэрийг тогтоох боломжгүй.

51 Социологийн судалгааны Европын консорциум- (2012).

52 Ашигт малтмалын газар (2013). Уул уурхайн салбарын статистик мэдээ, 2013 оны 8-р сар.

53 М.Золжаргал (2013). Desertification affects 77% of Mongolian territory. UB Post, 2013 оны 9-р сарын 20

54 1990-ээд улсын үйлдвэрийн газруудад хөдөлмөр эрхлэлт буурснаар малчдын тоо 2 дахин өссөн.

46 Kohn, M. (2013). Severely Polluted Mongolia Tries a Cleaner Power Source, New York Times, 2012

47 Монголын агаарын бохирдлын төсөл (2013). ДБ

48 МУХАУТ (2012). Ногоон ном: Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу, Улаанбаатар, Монгол Улс 2013.

49 ДЭМБ (2013). Мэдээллийн сан, Монгол Улс

газар нутгийн 50% хүртэлх мөн нүүрлээд буй нийт доройтлын 30% гаруйг хур тунадасны өөрчлөлттэй холбон үзэж болох ч, температурын өөрчлөлт тун бага нөлөө үзүүлсэн гэсэн байна.

Харин Лю тэргүүтэй судлаачид (2013) хөрсний доройтлын 40% орчмыг малын тоо толгойн өсөлт, хээрийн түймэр зэрэг хүний хүчин зүйлтэй холбон үзжээ. Тиймээс үлдсэн 60% нь хур тунадас буурсан, температур өссөн зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хүчин зүйлсээс хамааралтай гэжээ.

Ерөнхийдөө, учир шалтгаанаас үл хамааран цаашид асуудал улам бүр дордох төлөвтэй байна. Ирэх 30 орчим жилийн турш Монгол оронд агаарын дундаж температур өсөж, хур тунадасны хэмжээ буурна гэж Лю тэргүүтэй судлаачид үзжээ. Тийм ч учир уур амьсгалын өөрчлөлтийг Монгол дангаараа хянах боломжгүй тул “Монголын хээр талыг унаган байдлаар нь хадгалж үлдэхийн тулд бэлчээр ашиглалтын үр ашигтай, тогтвортой стратегийг нэвтрүүлж, түймрээс урьдчилан сэргийлэх, хор хохирлыг бууруулах арга хэмжээ авах шаардлага нэн түрүүнд тулгамдаж байна” гэж дүгнэсэн байна.⁵⁵

(5) Ойн хэмжээ багасаж байна

Монголын газар нутгийн ихэнх хэсэг нь бэлчээрийн хээр тал хэдий ч, газар нутгийн томоохон хэсгийг ой мод эзэлдэг. 2012 оны байдлаар ойн бүс нутаг 18.6 сая га газар буюу нийт газар нутгийн 11.9%-ийг эзэлж байв. Нийт 140 гаруй төрөл зүйл мод, бутлаг ургамал бүхий ойн бүрхүүл 12.5 сая га буюу нийт газар нутгийн 8%-ийг эзэлж байв.

Түлш болон орон байрны зориулалтаар ой модыг огтлох болсноор ойн бүс хурдацтай багасаж байна. Дэлхийн банкны үзэж буйгаар 2000-2011 онд ойн бүс жилд дунджаар 0.7%-иар багассан нь дэлхийн дундаж болох 0.1%-тай харьцуулшгүй өндөр юм.⁵⁶ Түүнээс гадна 1990-ээд оны үед ойгүйдэл жилд 40,000 га байсан бол өнөөдөр 80,000 га болж нэмэгджээ.

Эдгээр асуудлын гол нь ойн оновчгүй менежмент болоод байна. Ойн нөөцийг хэтрүүлэн ашиглах явдал газар авсны дээр ойн аж ахуйн арга барил хэт үрэлгэн бөгөөд үр дүнгүй-тухайлбал, огтолсон модныхоо дөнгөж 60% орчмыг үр дүнтэйгээр ашигладаг гэсэн тооцоо бий.⁵⁷ Ойн огтлолт тогтвортой түвшнээс дунджаар 4 дахин их бөгөөд 36-80% орчим нь хууль бус байдаг. Энэ бүх бэрхшээлийн зэрэгцээ тус салбарыг шинэчилж, орчин үеийн түвшинд хүргэхэд шаардлагатай

санхүүжилтийг татаж чадахгүй байсаар байна.⁵⁸

Дэлхийн банкны үзэж буйгаар ойн аж ахуй хямралд автахад улам бүр ойртсоор байгаа атал салбарын гол оролцогчид энэ талаар огт бэлтгэлгүй хэвээр байна. Түлшний илүү тогтвортой өөр эх үүсвэр олоогүй тохиолдолд түлшний модны хомсдолд орох ноцтой эрсдэл нүүрлээд байгаа юм.

(6) Усны эх үүсвэрийн эрсдэл

Газар зүйн хүчин зүйлсийн улмаас Монгол оронд нэг жилийн турш орох хур тунадасны хэлбэлзэл өндөр, гүний усны хэрэглээнд голлон түшиглэдэг учир усны нөөц хязгаарлагдмал гэж үздэг. Монголын умард хэсэгт гол нууруудын томоохон сүлжээ бий хэдий ч өмнөд бүс болон хүн ам олноор суурьшсан төвийн бүсэд усны нөөц хангалтгүй. Үүний зэрэгцээ усны гамгүй хэрэглээ, бохирдол, улирлын цаг агаарын хэлбэлзэл, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүчин зүйлсийн улмаас усны нөөц улам хомсодсоор байна.

Улаанбаатар хотын хувьд усны хэрэглээнийхээ 98% орчмыг газрын гүнээс хангадаг. Зарим тооцоогоор, 2015 он гэхэд өнөөгийн эх үүсвэрүүдээр тус хотын усны хэрэглээг хангах боломжгүй болно гэжээ.⁵⁹ Түүнээс гадна, хөрсний бохирдол, гэр хороолол дахь гүний худгийн хэрэглээний улмаас үүсэж болзошгүй гүний усны хомсдол зэрэг асуудлууд сэтгэл түгшээсээр байгаа юм.

Хуурай тарчиг хэдий ч уул уурхайн томоохон ордуудыг агуулсан Өмнөд говийн усны нөөц мөн эрсдэлд ороод байна. Уурхайн үйл ажиллагаанд их хэмжээний ус шаардлагатай байдгаас гадна уурхай орчмын бүс нутгийн хөгжил эрчимжсэнээр усны эрэлт өсөх хандлагатай байдаг. Урьдчилсан таамгаар гэхэд тус нутаг дахь усны эрэлт 2009-2020 онд өдөрт 82,000 шоо метрээс 400,000-450,000 шоо метр болж өсөх ба үүний 300,000 шоо метр нь дангаараа уул уурхайн үйл ажиллагаанд зарцуулагдах болно гэсэн тооцоо гарчээ.⁶⁰

⁵⁵ Лю (2013), Хуудас -3

⁵⁶ ДЭМБ (2013). Мэдээллийн сан, Монгол Улс.

⁵⁷ НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр (2001), Монгол Улс: Хүрээлэн

⁵⁸ Дэлхийн банк (2003). Монголын ойн аж ахуйн тайлан

⁵⁹ Арена, А. (албан бус захидал, 2013 оны 1-р сарын 21)

⁶⁰ Дэлхийн банк (2010). Монгол Улс: Өмнийн Говийн бүс нутгийн гүний усны үнэлгээ, 2010 оны 4-р сар

3. Сорилтуудыг даван туулах нь: Төрийн зүгээс баримтлах Ногоон хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд

Нэгдүгээр бүлэгт дурдсанчлан Монгол Улсад эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчинд хэд хэдэн голлох сорилтууд нүүрлээд байна. Эдгээр сорилтуудыг даван туулж, тогтвортой хөгжлийг цогцлоохын тулд Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) ногоон эдийн засгийг хөгжүүлэх хэд хэдэн бодлогын шийдлийг дэвшүүлээд байна.

Ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөрийн жагсаалтыг гаргахын тулд юуны өмнө НҮБХБОХ-өөс гаргасан ногоон эдийн засгийн тодорхойлолтыг эргэж харах нь чухал. “Ногоон эдийн засаг нь байгаль орчны эрсдэл, экологийн доройтлыг багасгахын зэрэгцээ хүний аж байдлыг сайжруулах, нийгмийн тэгш байдлыг хангах, бага нүүрстөрөгч бүхий нөөц, баялгийн үр ашигтай ашиглалтыг хангах” гэж тодорхойлжээ.⁶¹ Энэхүү бүлэгт өндөр нөлөө бүхий зарим баримт бичиг, бодлого, хөтөлбөрийн талаар мэдээлэл орууллаа.

3.1 НОГООН ЭДИЙН ЗАСГИЙН ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОГЧ СТРАТЕГИУД

Засгийн газраас баримтлах цар хүрээг тодорхойлдог бодлогын хоёр баримт бичиг бий. Үүний нэг нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого бөгөөд нөгөө нь Засгийн газрын 4 жилийн мөрийн хөтөлбөр юм. Эдгээр баримт бичгийг Ногоон хөгжлийн стратегийн суурь гэж үзэж болно.

4.1.1 МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО, 2008–2021⁶²

Монгол Улсын Засгийн газар 2008 онд 2008–2021 онд Монгол Улсыг хөгжүүлэх Үндэсний хөгжлийн цогц бодлогыг баталсан. Энэхүү бодлого нь урт хугацааны бодлогыг томъёолсон анхны баримт бичиг байсан бөгөөд ирэх 14 жилд Монгол Улсын төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон юм. Энэхүү бодлогын баримт бичгийг УИХ-ын тогтоолоор 2005 онд баталсан Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ)-ад тулгуурлан боловсруулсан бөгөөд Тэргүүлэх 6 чиглэл, Стратегийн 124 зорилт, Хэрэгжүүлэх 523 үйл ажиллагааг тусгасан байна.

ҮХЦБ-д 2021 гэхэд хүрсэн байх үндэсний хөгжлийн түвшинг дараах байдлаар төсөөлөн тодорхойлсон байна:

Монгол Улс нь өргөн уудам нутаг, байгалийн их нөөц баялаг, бахархам түүхтэй, итгэл найдвар дүүрэн, ирээдүйн зол жаргалтай орон мөн. Бидний монголчууд түүх, соёлоо эрхэмлэн хүндэлж, үндэсний бахархалтай, өндөр боловсролтой, өөрсөддөө итгэлтэй байж, хүсэл тэмүүлэлдээ хүрч, эх орондоо тав тухтай, чинээлэг, сэтгэл хангалуун аж төрнө.

Мөн ҮХЦБ нь дараах **зарчмуудад** тулгуурласан байна:

- Улс орны хөгжилд иргэн бүр оролцох, хувь нэмрээ оруулах, манлайлах нөхцөлийг бүрдүүлэх;
- Хөгжлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх чадамж, бүтцийг бий болгох;
- Зах зээлийн эдийн засагт суурилсан хөгжил эрчимтэй, тогтвортой байх;
- Хөрөнгө нөөцийг бодлогын тэргүүлэх чиглэл, эрэлт хэрэгцээнд суурилан хуваарилах, түүнийг ил тод байлгах, зарцуулалтыг хянан гүйцэтгэлийн үр дүнг үнэлж дахин төлөвлөх;
- Бүх талын түншлэлд суурилах;
- Өөрчлөгдөмтгий нөхцөл байдалд уян хатан зохицох чадамжтай болох;
- Бүх шатанд хариуцлага хүлээх чадвартай болох, ил тод байх, хууль дээдлэх.

ҮХЦБ-д тусгасан эрхэмлэх зүйлс:

- Монгол Улсын Үндсэн хуулийг баримтлах;
- Шударга амьдарч, ажиллах, нийгмээ эвсэг, найрсаг байлгах;
- Бие хүн, нийгмийн хөгжил дэвшлийг өөрсдийн гараар бусадтай хамтран бүтээн байгуулах;
- Эх оронч үзэл нь улс орноо хөгжүүлснээр тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хамгаалан бэхжүүлэх зарчим дээр тогтох.

Энэхүү алсын харааг биелүүлэхийн тулд энэхүү стратегийг дараах хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ гэж заажээ:

- 2007-2015 он: МХЗ-уудыг биелүүлж, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана
- 2016-2021 он: мэдлэгт суурилсан эдийн засаг руу шилжих

61 НҮБХБОХ (2013). Ногоон эдийн засаг гэж юу вэ?

62 МУ-ын Засгийн газар (2008).

ҮХЦБ-ын тэргүүлэх 6 чиглэл:

1. Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, монгол хүнийг бүх талаар хөгжүүлнэ;
2. Экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн өндөр технологи, үүний дотор мэдээлэл, харилцаа, био, нанотехнологи, транзит тээвэр, логистик, санхүүгийн зуучлалын үйлчилгээ, уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг гүн боловсруулахад суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоно;
3. Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглан хуримтлал бий болгож, эдийн засгийн эрчимтэй, өндөр өсөлтийг хангаж, орчин үеийн боловсруулах салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ;
4. Бүс нутаг, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана;
5. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон арга чадавхыг бий болгох, экосистемийн тэнцвэрт байдлын алдагдлыг зогсоох, хамгаалах замаар хөгжлийн тогтвортой орчин бий болгоно;
6. Улстөрийн ардчилсан тогтолцоог боловсронгуй болгож, авлига, хүнд суртлаас ангид, ил тод, хариуцлагатай, шударга тогтолцоог бүрдүүлнэ.

ҮХЦБ-ын хэрэгжилтийг үнэлсэн 2011 оны үнэлгээний тайланд юуны өмнө тус бодлогыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн суурь баримт бичиг гэж ойлгож хүлээн авах явдал дутмаг байна гэжээ. Түүнчлэн, бодлогын төлөвлөлт, тайлангийн тогтолцоо боловсронгуй бус бөгөөд МХЗ-д тулгуурласан стратегийн зорилго, хэрэгжилт, үр дүн хомс байгааг тэмдэглэсэн байна. Мөн ихэнх зорилго, үйл ажиллагаа нь бодит бус харин улс төрийн амлалт, нөхцөл дээр тулгуурлаж байна гэжээ. Хэдийгээр бодлогын шинэчлэлтэй холбоотой зарим чухал ахиц дэвшил гарсан ч нийтдээ “ядуурал, ажилгүйдлийг бууруулах, шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх, байгаль орчин, бүс нутгийн хөгжилд чиглэсэн бодлогын хэрэгжилт удаашралтай” хэмээн дүгнэсэн байна.⁶³

Маршал, Никсон, Уалтерс нарын гүйцэтгэсэн (2008) ҮХЦБ-ын бас нэгэн үнэлгээнд төрийн оролцоог багасгахад суурилсан эдийн засгийн өсөлт нь Монгол Улсын хөгжлийг хангах гол арга зам хэвээр байна гэж дүгнэжээ. Тус баримт бичгийн үндсэн хэсэг болох ядуурлыг бууруулах загварыг уул уурхайгаас олох орлого, эрдэс баялгийн үнийн өөдрөг төсөөлөлд тулгуурлан боловсруулжээ. Энэ нь ҮХЦБ дангаараа Монголын Ногоон хөгжлийг хангах боломжгүй гэдгийг харуулж байна.

3.1.2 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2012-16 (2012)⁶⁴

2012 онд Ардчилсан нам, Иргэний зориг-Ногоон нам, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвсэл хамтран Шинэчлэлийн Засгийн газар байгуулж, ирэх 4 жилийн мөрийн хөтөлбөрөө боловсруулсан юм. Мөрийн хөтөлбөрт үндсэн 5 зорилт дэвшүүлжээ. Үүнд:

1. Ажилтай, орлоготой Монгол хүн: Засгийн газраас хүн амын үндсэн хэрэгцээг тогтвортой хангахуйц, өөрийгөө тэтгэх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөв, санхүү, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Түүнчлэн, хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангах, тэдний цалин хөлс амьдрал ахуйд нь хүрэлцдэг болгох, хавтгайрсан нийгмийн халамжийн бодлогоос татгалзаж, халамж шаардагдах хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихийн сацуу төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, бизнест ээлтэй орчин бүрдүүлнэ гэсэн байна.

2. Эрүүл чийрэг Монгол хүн: Энэ зорилтын хүрээнд шударга өрсөлдөөн, чөлөөт сонголтод суурилсан, олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрд олгохыг зорино гэжээ.

3. Эрдэм боловсролтой Монгол Хүн: Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд Монголын онцлог бүхий, олон улсын стандартад нийцсэн, хөрвөх чадвартай боловсролыг эх орондоо олж авах, эзэмшсэн мэдлэг, мэргэжлээрээ ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой байх, эх орны хөгжлийн ирээдүй монгол хүнээ сургаж бэлтгэх нь боловсролын салбарын гол зорилт байх болно. Мөн Монгол соёл, өв уламжлал, их спорт, биеийн тамирыг хөгжүүлж Монгол эх орноо дэлхийд данстай байлгана гэжээ.

4. Эрүүл орчинтой Монгол хүн: Эдийн засгийн өсөлтийг хангахаас гадна байгаль дэлхийтэйгээ зохицон амьдарч, байгалийн нөөцийг тогтвортой ашиглаж, нөхөн сэргээж, хүрээлэн байгаа орчныг хамгаалах замаар нийгэм, эдийн засаг, хөгжлийн бодлого нь ногоон хөгжлийн бодлоготойгоо уялдаж, экологийн тэнцвэртэй аюулгүй орчинд амьдарч, ажилладаг байхыг зорилт болгоно. Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх шинэчлэлийн нэгийг “ногоон хөгжлийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгох” гэсэн нь Ногоон хөгжлийн стратегийн хувьд чухал ач холбогдол бүхий заалт болжээ.

5. Эрх чөлөөтэй Монгол хүн: Төр засгийг олон нийтэд тунгалаг, нээлттэй болгож, хариуцлага, хяналтыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим

⁶³ Б.Даринчулуун (2011).

⁶⁴ ДЭМБ (2012). 2012-2016 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Албан бус орчуулга.

болгон мөрдүүлж, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг бий болгож, улмаар төрийн албыг нийтийн алба, төрийн үйлчилгээг нийтийн үйлчилгээ болгон үндсээр нь өөрчилж, хууль дээдлэн, хүн бүр эрх тэгш, эх орондоо, аймаг, хотдоо сайхан амьдрах нийгмийг цогцлоход энэ чиглэлийн эрхэм зорилго оршино хэмээн заажээ.

Дөрвөн жилийн мөрийн хөтөлбөрийн хүрээнд жил тутмын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, яамдад ажил үүргийн хуваарилалт хийн, төсөв болон биелэлтийн гол үзүүлэлтүүдийг хуваарилдаг бодлогын баримт бичгүүдтэй харьцуулан дүгнэдэг байна.

Түүнчлэн МУЗГ одоогоор Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах гарын авлага боловсруулахаар ажиллаж байна.

4.1.3 НОГООН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны үндсэн чиг үүргийн хэмжээнд боловсруулаад байгаа НХҮБ нь 2012 оны Рио+20 бага хурлын хариу болж гарсан бөгөөд Засгийн газрын 2012-2016 оны Мөрийн хөтөлбөрт заасанчлан ногоон хөгжлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн суурь бодлого болгох зорилготой юм.

Ногоон хөгжлийн стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор Ногоон хөгжлийн үзэл баримтлал⁶⁵, Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр⁶⁶ гэсэн өндөр түвшний хоёр баримт бичиг боловсруулагдсан. Ногоон хөгжлийн үзэл баримтлалд 2030 он хүртэл баримтлах ногоон хөгжлийн зорилго, зорилтуудыг тусгасан бол дунд хугацааны хөтөлбөрт эдгээр зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх бодлого, стратегиудыг тодорхойлжээ.⁶⁷

Эдгээр бодлогын баримт бичгийг 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан ба мөн оны Намрын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна.

3.2 НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГУУД

МУЗГ-ын үндэсний бүтээн байгуулалтыг өрнүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 2011 оны 5 дугаар сард Хөгжлийн банкныг байгуулсан. Энэ банк нь нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой салбаруудыг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх зорилго бүхий томоохон хэмжээний төслүүдийг санхүүжүүлэх үүрэгтэй. Хөгжлийн банкнаас 2012

оны 3 дугаар сард 580 сая ам.долларын бонд гаргаж, дэд бүтцийн олон төслийг санхүүжүүлж эхлүүлээд байна. Тус банкнаас санхүүжүүлж буй төслийн тоонд төмөр зам, авто зам байгуулах, болон барилга орон сууцны хангамжийг сайжруулах төслүүд орж байгаа юм. (Тодруулга 1).⁶⁸

Эдийн засгийн хөгжил, төрөлжүүлэлтийн чухал ач холбогдол бүхий бас нэг төсөл нь Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын бүтээн байгуулалт мөн. Тус цогцолбор ашиглалтад орсноор боловсруулалт, үйлдвэрлэлийн дэвшилт технологи ашиглан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжүүлж, улмаар эдийн засгийн төрөлжилтөд ихээхэн хувь нэмэр оруулах юм. Тус цогцолборын хүрээнд коксжих нүүр, ган, зэс боловсруулах, барилгын материалын, нүүрс-химийн үйлдвэрүүд байгуулна гэж төлөвлөөд байна.

Дэд бүтцийн хөгжлийг улам эрчимжүүлэх зорилгоор МУЗГ 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 1.5 тэрбум ам.долларын бонд олон улсын зах зээлд гаргасан. “Чингис бонд” хэмээгдсэн энэхүү зээлийн гол зорилго нь Монгол Улсын хөгжлийг дэмжих дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх явдал байв. 2013 оны 4 дүгээр сарын байдлаар бондын мөнгөнөөс 1.253 тэрбум ам.долларыг төрөл бүрийн төслүүдэд хуваарилсан байв. (Тодруулга 1).⁶⁹ Эдгээр төслийн дийлэнх нь төмөр болон авто замын бүтээн байгуулалт хэдий ч аж үйлдвэрийн суурийг бэхжүүлэх олон тооны төсөл, нэн ялангуяа хөдөө аж ахуй, бөс барааны аж үйлдвэрийг дэмжих төслүүд мөн олноор багтсан байна. Засгийн газраас 2013 оны сүүлээр гаргасан бас нэгэн бонд нь Япон улсын зах зээлд гаргасан “Самурай” бонд юм. Энэхүү бонд нь мөн л эдийн засгийг тогтворжуулах, хямд өртөгтэй санхүүжилтийн эх үүсвэр болж байна.

МУЗГ-аас эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогын бас нэгэн хэрэгсэл нь Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн хөтөлбөр юм. ЖДҮ-үүд нийт аж ахуйн нэгжийн 2/3-ыг эзэлдэг ба ДНБ-ий 20% орчмыг үйлдвэрлэдэг, түүнчлэн 738,800 ажлын байр (хөдөлмөрийн зах зээлийн 70% орчим) бий болгодог гэдгийг харгалзах аваас, ЖДҮ-ийг дэмжих нь эдийн засгийн хөгжилд нэн чухал ач холбогдолтой гэдэг нь харагдана.⁷⁰

Тус хөтөлбөрөөр дамжуулан ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрны чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх, экспортод чиглэсэн болон импортыг орлох үндэсний үйлдвэрлэлийг дэмжихээр зорьж байна. МУЗГ-аас Жижиг, дунд үйлдвэрлэлийн тухай хуулийг дагалдуулан “2014-2016 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжүүлэх

65 МУЗГ (2013). Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралт, Ногоон хөгжлийн үзэл баримтлал

66 МУЗГ (2013). Тогтоолын төслийн 2 дугаар хавсралт, Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр

67 Хүдэр (2013).

68 Хөгжлийн банк(2013).

69 InfoMongolia (2013). Өнөөгийн байдлаар, 347 сая...

70 InfoMongolia (2013). ЖДҮ-ийг хөгжүүлэх хөтөлбөрийг хандивлагч байгууллагуудад танилцуулгаа ...

Тодруулга 1: Хөгжлийн банк болон Чингис бондны эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийн жагсаалт

Хөгжлийн банк 580 сая ам.долларын зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлж буй гол төсөл, хөтөлбөрүүд:

- Улсын хэмжээнд 2012-2015 онд баригдах 5600 км урттай төмөр замын сүлжээ. Уг төсөл нь 3 үе шаттайгаар хэрэгжинэ.
- Оюу толгой, Таван толгой, мөн зүүн аймгууд дахь газрын тосны ордуудын дунд баригдах Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор. Тус цогцолбор нь төмөр зам, хурдны авто замуудын сүлжээн дээр байрлах ба ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх чухал төв болох боломжтой;
- 2012 он гэхэд 21,600 орон сууц, 2016 он гэхэд 53,400 орон сууц ашиглалтад оруулах замаар Улаанбаатар хотын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх.
- 2012 онд шинээр 112 км зам ашиглалтад оруулж, 150 км зам засварлах, 3 байрлалд тэгш уулзвар байгуулах. 2016 он гэхэд Хөгжлийн банкнаас дахин 100 км шинэ зам ашиглалтад оруулж, 200 км зам засварлан, 4 байрлалд тэгш уулзвар байгуулахаар төлөвлөж байна.
- Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн 990 км хурдны зам шинээр байгуулах.

Чингис бондын 1.5 тэрбум ам.долларын эх үүсвэрээс дараах төслүүдийг санхүүжүүлэхээр зарласан байна. Үүнд:

- Таван толгойн орд газрын бүсийг түшиглэн 1,800 км төмөр зам барихад 200 сая ам.доллар;
- Улаанбаатар хотод “Гудамж” төсөл хэрэгжүүлэн, шинээр замын уулзвар, хурдны зам байгуулахад 200 сая ам.доллар;
- 300 мега ваттын хүчин чадал бүхий Таван толгойн цахилгаан станц байгуулах эхний үе шатыг хэрэгжүүлэхэд 50 сая ам.доллар;
- Замын бусад төсөл хөтөлбөрт 570 тэрбум төгрөг;
- Ноолуурын салбарыг шинэчлэхэд 68.8 сая ам.доллар;
- Улаанбаатарын гэр хорооллыг дахин төлөвлөх, шинээр орон сууцны хороолол байгуулахад 200 тэрбум төгрөг;
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд 27.7 сая ам.доллар;
- Улаанбаатар хот, 21 аймгийн төвд хүлэмжийн ногооны ферм байгуулахад 17.7 сая ам.доллар;
- Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд 45 сая ам.доллар;
- Бөс бараа, оёдлын үйлдвэрүүдийг дэмжихэд 13.5 сая ам.доллар;
- Барилгын материалын үйлдвэр байгуулахад 14 сая ам.доллар.

Эх сурвалж: InfoMongolia (2013). “Өнөөдрийн байдлаар Чингис бондны мөнгөнөөс 347 сая ам.доллар үлдээд байна гэж ерөнхий сайд Н.Алтанхуяг хэллээ”. Монгол Улсын Хөгжлийн банк (2013).

хөтөлбөр”-ийн төслийг боловсруулсан хөтөлбөрийг санхүүжүүлэх хандивлагч талуудыг судалж байгаа аж.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас (ЭЗХЯ) инновацийн төслийн концесс байгуулах хэлцлүүдийг хийж байна.

Инновацийн тухай хууль дахь холбогдох заалтууд төр болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, тухайлбал, эрчим хүчний зэрэг салбарт төсөл хамтарч хэрэгжүүлэх боломжийг нээж өгсөн.⁷¹ Одоогийн байдлаар ЭЗХЯ хэрэгжүүлэх төслийн жагсаалтад үнэлгээ хийж, эдгээр концессыг ажил хэрэг болгох бодит механизмуудыг судалж байна. Үүний зэрэгцээ, шинээр байгуулагдсан компаниудаас тус хуулийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрэлдүүлэх зорилгоор шаардлагатай дүрэм, журмын жагсаалтыг мөн боловсруулж байгаа аж. Ногоон технологи, ногоон эдийн засаг нь тус яамны тэргүүлэх чиглэлийн нэг бөгөөд БОНХЯ-тай ойр хамтран ажиллаж байна.

Гэсэн хэдий ч чухам ямар хэмжээний хөрөнгө мөнгийг МУЗГ-аас эдгээр концессийн үйл ажиллагаанд зориулан гаргахыг тодорхой хэлэх боломжгүй байна.

3.3 ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ТЭЭВЭР

Монгол Улсын нийт хүн амын тал нь ажиллаж амьдардаг, нийт ДНБ-ий 60%-ийг үйлдвэрлэдэг нийслэл Улаанбаатар хотын тогтвортой хөгжил нь Монголын ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ.

Энэ чиглэлээрх нэгэн чухал санаачилга нь БОНХЯ-ны сайд С.Оюун, Улаанбаатар хотын захирагч бөгөөд нийслэлийн засаг дарга Э.Бат-Үүл нарын 2013 оны 1 дүгээр сард байгуулсан Улаанбаатар хотод ногоон эдийн засгийг хөгжүүлэх талаарх харилцан ойлголцлын санамж бичиг юм. Тус санамж бичигт Улаанбаатар хотын оршин суугчдын эрүүл, тухтай амьдрах орчин бүрдүүлж, хот төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажилд хүрээлэн буй орчны ач холбогдлыг харгалзаж үзэхэд чиглэсэн Үйл ажиллагааны хөтөлбөрийг 2013-2016 онд хэрэгжүүлэхээр заасан байна.

Энэхүү Үйлажиллагааны хөтөлбөрт нийслэлийн хүн амын төвлөрлийг сааруулах зорилгоор дагуул хотууд байгуулах, гэр хорооллыг орон сууцжуулах, ус, цахилгааны нэгдсэн сүлжээнд холбох зэргээр дэд бүтцийг хөгжүүлэх, эрчим хүч ашиглалтын үр ашгийг сайжруулах зэрэг арга хэмжээ багтжээ.

⁷¹ П.Товуудорж (2013). Монголын эрчим хүчний үндэсний хөтөлбөр, бодлогын арга хэмжээнүүд: Дэд бүсүүдийн хүрээнд ...

Мөн хөтөлбөрт Улаанбаатар хотын захад аж үйлдвэрийн парк байгуулах замаар арьс шир, ноолуурын болон бусад үйлдвэрүүдээс ялгаруулж буй бохирдлыг бууруулахаар заасан байна. Түүнчлэн, санамж бичигт заасны дагуу уул уурхайн үйл ажиллагааг хориглож, Туул, Сэлбэ голуудын урсцыг сайжруулж, хамгаалах, хог хаягдлын оновчтой менежментийг нэвтрүүлэх талаар тусгасан ба хог хаягдлыг боловсруулах үйлдвэр нэн шаардлагатай хэмээн онцолсон байна.⁷²

Монголд нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, ногоон тээврийг хөгжүүлэх хэд хэдэн арга зам бий. Тэдгээрийг ҮХЦБ-д Улаанбаатар хотын бохирдлыг бууруулахын тулд экологийн хувьд цэвэр нийтийн тээврийг хөгжүүлнэ гэж заасанд тулгуурлан хэрэгжүүлэх юм.

МУЗГ-аас Улаанбаатар хотыг 2020 он гэхэд метротой болгож, ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна. Метроны нийт замын урт 17.7 км байх бөгөөд 1.5 тэрбум ам.долларын зардалтай байх тооцоо гарчээ. Японы олон улсын хөгжлийн агентлаг (ЖАЙКА)-аас шаардлагатай хөрөнгийн 49%-ийг гаргаж, улс, нийслэлийн төсвөөс үлдсэн хэсгийг санхүүжүүлэх аж. Зураг төслийг 1.6 жилийн дотор хийж гүйцэтгэх ба барилгын ажил 2016 оны хавар эхэлж, 2020 он гэхэд ашиглалтад оруулахаар заагаад байна.

Дэлхийн банкнаас тус хөтөлбөрт хэд хэдэн асуудлаар шүүмжлэлтэй хандаж байгаа юм. Юуны өмнө, метро байгуулах хөтөлбөрийг төсвийн гадуурх үйл ажиллагаа хэмээн үзэж, Засгийн газрын төсвийн төлөвлөгөөнд багтаагүй аж.

3.4 ОРОН СУУЦЖУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НЬ

МУЗГ-аас дундаж давхаргын орон сууцжуулалтыг дэмжих зорилгоор орон сууцны зах зээлд оролцож эхэлсэн. Монголбанк 2013 оны 1 дүгээр сарын 17-ноос эхлэн ердийн ханшаар жилийн 15%-ийн хүүтэй байсан орон сууцны зээлийг санхүүжүүлж, $8\% \pm 1$ хүртэл хөнгөлөх хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Шинэ нөхцлийн дагуу 10-30%-ийн урьдчилгаа төлөх ба зээлийг 20 жилийн дотор барагдуулах ёстой аж. Зээлийг 80 м.кв буюу түүнээс бага талбай бүхий орон сууцанд олгож байгаа. Зээлэнд хамрагдагсад тогтмол ажилтай байх шаардлагатай ба зээлийн сарын төлбөр нь өрхийн нийт орлогын 45%-иас хэтрэх ёсгүй.⁷³ 2013 оны 11 дүгээр сарын байдлаар тус хөтөлбөр эрэлт ихтэй байж, 470.1 тэрбум төгрөгөөр 16,712 зээлийг дахин санхүүжүүлж, 640.3 тэрбум төгрөгөөр 11,058 шинэ зээлийг санхүүжүүлжээ.⁷⁴

Энэ хөтөлбөрийг орон сууцны зах зээл дэх

инфляцыг бууруулахын зэрэгцээ Улаанбаатар хотын захаар баригдсан барилгуудыг эзэнжүүлнэ хэмээн найдаж байгаа аж. Түүнчлэн, гэр хорооллын оршин суугчид энэ хөтөлбөрт хамрагдсанаар гэр хорооллын өрхийн тоог цөөлж, агаар болон хөрсний бохирдлыг бууруулах боломжтой юм.

3.5 ИНФЛЯЦТАЙ ТЭМЦЭХ НЬ

МУЗГ-аас эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогуудыг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ инфляцыг хянахад ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Монголбанкнаас энэ чиглэлээр ердийн мөнгөний бодлогын арга хэрэгслээс гадна Үнэ тогтворжуулах хөтөлбөр (ҮТХ)-ийг хэрэгжүүлж байна.

МУЗГ болон Монголбанк 2012 оны 10 дугаар сард “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх” тухай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурснаар ҮТХ-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх 3 жилийн хугацаанд нийт 720 тэрбум төгрөг зарцуулах бөгөөд дараах 4 дэд хөтөлбөрөөс бүрдэх юм.

Үүнд:

1. Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах;
2. Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах;
3. Өргөн хэрэглээний импортын бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах;
4. Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах.

Энэ хөтөлбөр нь улирлын чанартай үнийн хэлбэлзэлд зонхилох нөлөө үзүүлдэг гэгдэх зарим гол нэрийн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдлыг бууруулах замаар бүтцийн гажуудлыг арилгах зорилготой юм. Хөтөлбөрийн дагуу голлох салбаруудад хөнгөлөлттэй зээл олгож, үнийг тогтвортой байлгах хэлэлцээ хийдэг байна. 2013 оны 9 дүгээр сарын байдлаар 642 тэрбум төгрөгийн зээлийг газрын тос, мах, гурил, барилгын салбарууд дахь олон тооны аж ахуйн нэгжид олгоод байна.

3.6 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРҮҮД

Чадварлаг ажиллах хүч бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор МУЗГ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг дагалдуулан ажил эрхлэлтийн болон мэргэжлийн сургалтын хэд хэдэн хөтөлбөрийг авч хэрэгжүүлж байна. Тус хуулийг анх 2001 онд баталсан ба 2011 онд шинэчлэн найруулжээ. Хөдөлмөрийн яамнаас хуулийн шинэчилсэн найруулгаар орсон

⁷² (2103). Сайд С.Оюун, Захирагч Э.Бат-Үүл нарын байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг.

⁷³ Б.Баяртогтох (2013).

⁷⁴ Монгол банк (2013).

өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ЗГ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг мөн өөрчилж байгаа юм. Одоогийн байдлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүждэг 8 хөтөлбөр бий. Үүнд:⁷⁵

1. Хөдөлмөрт сургах хөтөлбөр: Энэ хөтөлбөрийн дагуу барилга, зам, уул уурхайн ажлын байранд ажиллах хугацаандаа суралцах ажлын байран дээрх сургалт, түүнчлэн ажил идэвхтэй хайгчид болон ажилгүй иргэдэд зориулсан богино хугацааны сургалтуудыг хэрэгжүүлдэг байна;
2. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр: Энэ хөтөлбөрт гол 3 их сургууль, тэдний салбар сургуулиудыг түшиглэн байгуулсан оюутны ажил эрхлэлтийг дэмжих төвүүдийг хамруулдаг;
3. Ажил олгогчдыг дэмжих хөтөлбөр;
4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр: Энэ хөтөлбөр нь малчдын хөдөлмөрийн ур чадварыг сайжруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, тэднийг эрсдлээс хамгаалах зорилготой юм. 2010 онд гэхэд нийт 1276 малчин 17 төрлийн сургалтад хамрагдсан бөгөөд “Гэр бүлийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулжээ. Эдгээр сургалт, үйл ажиллагааны үр дүнд 244 малчин өрх 2010 оны зудын хохирлоос өрхийн орлогын эх үүсвэрээ хамгаалж чадсан байна.
5. Хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
6. 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг хамгаалах хөтөлбөр: Энэ хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхэлж явуулдаг 152 жижиг бизнес хамрагдсан бөгөөд 483 ажлын байр шинээр бий болгожээ.
8. Олон нийтийн ажлын хөтөлбөр.

Түүнээс гадна, МУЗГ сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж буй барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартыг сайжруулахаар ажиллаж байна. Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөрийн сайд, Хүн амны хөгжил, нийгмийн хамгааллын сайд нарын 2013 оны №52.а 50.а 26 дугаар бүхий хамтарсан тушаал гаргаж, барилгын үйлдвэрлэлийн салбарт “Цэнхэр карт”-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Цэнхэр карт авах шаардлагыг хангахын тулд тухайн аж ахуйн нэгж нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 4 дэх хөтөлбөрт заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, ариутгалын стандартуудын талаар тогтмол сургалт зохион байгуулах ёстой аж.

3.7 ХАЛАМЖИЙН БОДЛОГУУД

Монгол Улсад авч хэрэгжүүлсэн халамжийн бодлогуудаас хамгийн өргөн цар хүрээтэй нь Хүний хөгжлийн сан (ХХС) байв. МУЗГ 2009 онд Рио Тинто компанитай Оюу толгойн (ОТ) ордыг ашиглах талаарх гэрээнд гарын үсэг зурсны дараахан ХХС-г байгуулсан юм. ХХС-ийн эхний хөрөнгө оруулалт зөвхөн ОТ бус харин Таван толгойн роялти төлбөрийн урьдчилгаанаас ч мөн бүрдсэн байлаа.

Тус сангийн зорилго нь өсөн нэмэгдэж буй орлогын тэгш бус байдлыг бууруулах, сургалтын төлбөрөөс хөнгөлөх зэрэг халамжийн бусад арга хэрэгслийг ашиглан уул уурхайгаас олсон орлогын тэгш хүртээмжийг сайжруулах явдал байв. Гэсэн хэдий ч ХХС-гийн хөрөнгийн дийлэнх хэсгийг иргэдэд бэлэн мөнгө тараах хэлбэрээр зарцуулсан байна. 2010 оны 2 дугаар сард монголын иргэн бүр 70,000 төгрөгийн хувь авсан ба үүний дараах бага хэмжээний мөнгөн халамжуудыг оруулаад дахин 50,000 төгрөгийн хувь авчээ. 2011 онд сар тутмын халамжийн мөнгө 21,000 төгрөг байсан ба нийт зарцуулсан хөрөнгийн 4-ний 1-ийг оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт хэлбэрээр тараажээ.

Бэлэн мөнгөний энэхүү үрэлгэн зарцуулалт 2012 оны 1 дүгээр сард Нийгмийн халамжийн тухай хууль батлагдсанаар төгсгөл болсон. 2012 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн энэ хууль нь бэлэн мөнгө тараах тогтолцооны оронд илүү үр дүнтэй ядуурлыг бууруулах халамжийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлжээ. Энэ хууль батлагдсанаар хүн амын ядуу, нэн ядуу хэсэгт халамж үзүүлэхийн зэрэгцээ санхүүгийн хувьд тогтвортой нийгмийн халамжийн тогтолцоо бүрдүүлэх чухал алхам болсон байна.

Тус хуулийн дагуу сар тутмын 40,000 төгрөгийн халамжийн мөнгийг 130,000 гаруй ядуу өрхөд тараадаг ба энэ нь Монгол Улсын нийт өрхийн 20 хувь болж байна. Энэ халамжид хамрагдахын тулд тухай өрх дэх хөдөлмөрийн насны ажилгүй хүн бүр улирал тутам бүртгүүлэх, сургалтад хамрагдах, олон нийтийн ажил хийх гэсэн шалгууруудыг хангах ёстой аж.⁷⁶

3.8 ХҮЙСИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

Монгол Улс 2011 онд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталсан. Өмнө нь жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар үндэсний хууль тогтоомжгүй байсан улсын хувьд энэ хууль нь нэн чухал алхам болсон ба жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн

⁷⁵ Илүү дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй

⁷⁶ Б.Хүдэр (2012).

байгууллагуудын гүйцэтгэх үүргийг нарийвчлан зааж өгснөөрөө давуу болжээ. Мөн хуулинд улс төрийн төв болон орон нутгийн байгууллага дахь төлөөллийн 25%-аас доошгүй хувь нь эмэгтэй байхаар заажээ.⁷⁷

3.9 ХҮН АМ БА ХҮН АМЫН БОДЛОГО

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас Монгол Улсын төрөөс хүн амын өсөлтийн талаар баримтлах бодлогын төслийг боловсруулсан бөгөөд Засгийн газрын хуралдаанаар 2014 оны хавар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Хүн амын насжилтын бүтцэд томоохон өөрчлөлт орж, нэн ялангуяа хөдөлмөрийн насныхан болон хүүхдүүдийн эзлэх хувь буурч байгаа, хотжилт эрчимтэй явагдаж, олон монголчууд гадаадын улс орнуудад ажиллах болсон зэрэг асуудал байна. Монгол Улс 2025-2030 он гэхэд хөгшин хүн амтай улс болох төлөвтэй байгаа тул МУЗГ-аас дараах зорилтуудыг тавьсан:

- Хөдөлмөрийн насны хүн амд зориулж ажлын байр бий болгох замаар амьжиргааны түвшинг сайжруулах
- Хүүхдийн эрүүл мэнд, эх барих үйлчилгээний чанарыг сайжруулах
- Хүүхэд, залуусыг соёлжуулах, боловсрол олгох
- Хөгшин хүн амын бүлэгт удахгүй шилжих иргэдийг мэдлэг мэдээллээр хангах, хараат бус байж, өөрсдийн хуримтлалыг бий болгох талаар сургах, таатай, аюулгүй амьдрах орчноор хангах
- Гэр бүлийн хөгжлийг дэмжиж, амьжиргааны түвшинг сайжруулах

Энэхүү бодлогод 2025 онд гэхэд дундаж наслалтыг 72-т хүргэж өсгөх, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн наслалтын зөрүүг арилгах зорилгыг тусгайлан дэвшүүлжээ. Төслийг эцэслэн боловруулж, УИХ-аас баталснаар Монгол Улсын төрөөс хүн амын өсөлтийн талаар баримтлах бодлого нь нийгмийн хувьд хүртээмжтэй, ногоон эдийн засгийг бий болгоход хувь нэмрээ оруулна гэж үзэж байна.

3.10 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Шинэ Үндсэн хууль 1994 онд батлагдсан цагаас эхлэн МУЗГ хүрээлэн буй орчныг хамгаалах хууль эрх зүйн бат бэх тогтолцоог бүрдүүлэхийг зорьж ирсэн. Азийн хөгжлийн банкны үзэж буйгаар⁷⁸ хүрээлэн буй орчны хамгаалалтай холбоотой Монголын хууль тогтоомж, зохицуулалтуудыг

дараах 5 давхаргад ангилж болох аж. Үүнд:

1. Үндсэн хууль (1994)
2. Олон улсын гэрээ, конвенц (тухайлбал, Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдах тухай конвенц, РАМСАР г.м)
3. Хүрээлэн буй орчны ерөнхий хууль (буюу Байгаль орчныг хамгаалах тухай хууль 1995)
4. Байгалийн нөөцтэй холбоотой хуулиуд (тухайлбал, ус, ой, агаар, хөрс, ургамал, агнуур, тусгай хамгаалалттай бүс, зэрлэг ургамал, жийрэг бүсүүд, газрын хөрсөн доорх нөөц, шатахуун, уул уурхайн хууль тогтоол г.м);
5. Торгууль, хураамжтай холбоотой хуулиуд (усны, агнуурын, ой ашигласны, зэрлэг ургамлын нөөцийг хадгалж хамгаалах болон байгалийн нөөцийг нөхөн сэргээх).

Ихэнх хуулиудыг дагалдан илүү нарийн тодорхой зохицуулалт бүхий тушаал, дүрэм, журам, шаардлага, стандартуудыг гаргадаг байна.

Сүүлийн жилүүдэд МУЗГ хүрээлэн буй орчны хамгаалах хууль эрх зүйн зохицуулалтын чиглэлээр томоохон шинэчлэл хийж байна. 2012 оны 5 дугаар сарын 17-нд Засгийн газраас хүрээлэн буй орчны хууль тогтоомжуудад хэд хэдэн өөрчлөлт хийсэн. Энэхүү шинэчлэлийн дүнд өмнө нь хүчин төгөлдөр байсан 18 хуулийн оронд 8 хууль батлагдсан ба шинээр 2 хууль боловсруулан 2012 оны 5 дугаар сард УИХ-аар батлуулсан байна.

Энэ үед хийсэн томоохон өөрчлөлтүүдийн нэг гэвэл хүрээлэн буй орчныг бохирдуулагч нь учруулсан хохирлын нөхөн төлбөрийг хийдэг болсон явдал юм. Түүнчлэн, байгалийн нөөц ашиглалттай холбоотой үйл ажиллагаа явуулах ямар ч байгууллага хуулийн дагуу 2 жил тутамд 1 удаа хүрээлэн буй орчны үнэлгээ хийлгэх үүрэг хүлээдэг болсон байна.⁷⁹

Алдрих ба Мелвилл нарын хийсэн судалгаанд дурдсанаар байгаль орчинтой холбогдолтой зарим хууль, журмын төслүүд нь дуустал нь бичээгүй, дутуу орхигдсон эсвэл хойшлуулагддаг байна.⁸⁰

Үүний зэрэгцээ, дөнгөж хөлөө олж буй гэж хэлж болохуйц байгаль орчны хамгааллын салбарт ур чадвар, арга, техникийн чадавх, хараат бус байдал хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд бий эсэх нь тодорхойгүй байна. Алдрихын үзэж буйгаар “хүрээлэн буй орчны нуугдмал үнэ цэнэ”-ийн талаарх субъектив ойлголтыг нэвтрүүлснээр зардлын тооцоо улам ч тодорхой бус болох магадлалтай аж.

Энэ чиглэлээр ихээхэн маргаан дагуулсан бас

77 Дэлхийн банк (2013) Монгол Улс: Хүйсийн тэгш бус байдал...

78 АХБ (2005).

79 Алдрих ба Мелвилл. (2012). Монгол Улсын хүрээлэн буй орчны хууль тогтоомжийн өөрчлөлт, түүний уул уурхайн салбарт үзүүлсэн нөлөөлөл, 2012 оны 10-р сарын 8

80 Мөн адил.

нэгэн хууль бол “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль буюу “Урт нэрт” хууль юм. МУЗГ уг хуулийг хүрээлэн буй орны төлөө тэмцэгчид, малчдын нөлөөгөөр 2009 онд баталсан. Ингэснээр ойн болон гол мөрний эхээс 200 метрийн дотогш зайд үйл ажиллагаа явуулж байсан 200 гаруй эрэл хайгуулын болон олборлох лицензүүд цуцлагдсан байна. Гэнэтийн энэхүү арга хэмжээ нь уул уурхайн салбарынхны хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан ба, нөгөө талаар хуулийн хэрэгжилтийг чангатгах, уул уурхайн болон хүрээлэн буй орчны хууль тогтоомжийг сайжруулах олон нийтийн хүлээлтийг өндөрсгөсөн юм.

УИХ-ын 2013 оны Намрын чуулганы үеэр уг хуулийг хүчингүй болгох оролдлого гарсан хэдий ч хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч, “Гал үндэстэн” хөдөлгөөний гишүүд 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр Төрийн ордонд халдахыг завдсан байна. Тус хөдөлгөөний зүгээс “Урт нэрт” хуулийг цуцалснаар уул уурхайн үйл ажиллагаа огцом нэмэгдэж, хүрээлэн буй орчинд эргэж буцашгүй хохирол учирч болзошгүй хэмээн болгоомжилж байгаа аж.⁸¹

3.11 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ БА ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ АШИГТ БАЙДАЛ

Монгол Улсад сүүлийн жилүүдэд сэргээгдэх эрчим хүчний салбарт мэдэгдэхүйц ахиц дэвшлүүд гаргасан. Жишээ нь МУЗГ-аас хэрэгжүүлсэн “100,000 нарны гэр” хөтөлбөр нь айл өрхүүдэд эрчим хүчний хэрэглээг ойртуулсан хөтөлбөр юм. Тус хөтөлбөр нь 1999 оноос эхэлсэн ба хөтөлбөрт хамрагдсан өрхүүдэд үнэгүй нарны зай, хавтан тараасан. Ингэснээр гэрт оршин суудаг өрхүүдийг эрчим хүчний үнэ төлбөргүй, цэвэр эх үүсвэрээр хангахын зэрэгцээ хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнийг сааруулахад нөлөөлөх эерэг үр дүн гарсан юм. Тус хөтөлбөрийг 2000–2010 онд хэрэгжүүлсэн ба өнөөгийн байдлаар нийт малчин өрхийн 70-90% нарны болон салхины эрчим хүчний эх үүсвэрээр хангагджээ.⁸²

Үүний дараачийн алхам болгож 2005 оноос сэргээгдэх эрчим хүчний салбарыг өргөн хүрээний эрчим хүчний эх үүсвэр болгон хөгжүүлэх асуудалд анхаарал хандуулж эхэлсэн. Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 6 дугаар сард батлагдсан “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр (2005-2020)”-т 2010 онд нийт эрчим хүчний 3-5%-ийг, 2020 он гэхэд 20-25%-ийг сэргээгдэх эх үүсвэрээс үйлдвэрлэдэг болох зорилго тавьжээ. Хөтөлбөрийн хүрээнд эрчим хүч хангамжийн

тогтолцоог сайжруулж, хөдөө орон нутаг дахь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах юм. Үүний зэрэгцээ, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах чиглэлээр Мастер төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

УИХ-аас Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг 2007 онд баталсан. Уг хуулийн зорилго нь ногоон эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, үнийг бодлогоор зохицуулах замаар сэргээгдэх эх үүсвэрээс эрчим хүч үйлдвэрлэхийг дэмжих, урамшуулах явдал юм. Мөн хуулийн дагуу сэргээгдэх эрчим хүчний сан байгуулсан ба сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрүүдээс эрчим хүч худалдан авах тусгайлсан тарифыг тогтоосон байна. Үүнд:

- Салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх: 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.08 - 0.095 ам.доллар.
- 5000 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг: 0.045 - 0.06 ам.доллар.
- Нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг: 0.15 - 0.18 ам.доллар.

Тарифыг ингэж тусгайлан тогтоосон нь 2013 оны 6 дугаар сард ашиглалтад орсон Салхитын салхин цахилгаан станцыг байгуулахад чухал нөлөө үзүүлсэн юм. МУЗГ Монголын анхны салхины эрчим хүчний “Клин Энержи” компанитай эрчим хүч худалдан авах гэрээ байгуулж, 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 9.5 центээр худалдан авах болсон.

Түүнчлэн МУЗГ-аас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийг импортын болон НӨАТ-ын чөлөөлөх шийдвэр гаргасан нь 2011 оны 4 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн байна. 2012 оны 12 дугаар сарын байдлаар нар, салхины эрчим хүчний үүсгүүрт шаардлагатай 33 нэр төрлийн тоног төхөөрөмж, эд ангийг татварын хөнгөлөлтөд хамааруулах жагсаалтад багтаасан байна.⁸³

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс дотоодын хэрэглээгээ хангахаас гадна сэргээгдэх эрчим хүч экспортлогч орон болохоор төлөвлөж байна. Эрчим хүчний яамнаас хийсэн судалгааны дагуу Монгол Улс нь салхины эрчим хүчний бололцоо асар их бөгөөд 1,100 гига ватт цахилгааны хүчин чадал бүхий “сайн - маш сайн” түвшинд үнэлэгдэх салхины нөөцтэй гэжээ.⁸⁴

Үүний зэрэгцээ, Засгийн газраас Говийн бүсэд дахин олон тооны салхин парк, том хэмжээний

⁸¹ InfoMongolia (2013).

⁸² НҮБХХ (2012).

⁸³ МУ-ын Засгийн газар (2012).

⁸⁴ П.Товуудорж (2013).

фотовольтаик цахилгаан станц байгуулахаар зорихын зэрэгцээ Монголоор дамжуулан Орос, Хятадыг холбосон өндөр вольтын цахилгаан дамжуулах шугам барих асуудалдаг холбогдол өгөн сурталчилж байна. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн сурвалжлагчдад хэлсэнчлэн “Монгол нь салхи, нар болон бусад сэргээгдэх эрчим хүчээр Азийг хангах супер үүсгүүр байх боломжтой.”⁸⁵ Харин эдгээр төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллах шаардлагатай бөгөөд энэ талаар Бүлэг 3-т дэлгэрэнгүй оруулсан болно.

Монгол орон нүүрсний арвин их нөөцтэй бөгөөд өнөөгийн байдлаар эрчим хүч үйлдвэрлэж буй ДЦС-ууд дийлэнх хувь нь нүүрсээр ажилладаг тул энэ чиглэлийн нүүрсний хэрэглээ цаашид ч байсаар байх юм. Иймд, эрчим хүчний нүүрсний дэвшилт технологи, хүлэмжийн хий багатай хэрэглээг дэмжин судлах нь зүйтэй:

3.12 АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

МУЗГ сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэхээр хэрэгжүүлж буй арга хэмжээний хамгийн эхний арга хэмжээ болгож агаарын бохирдолтой тэмцэх Засгийн газрын тусгай сан болох Цэвэр агаар санг байгуулжээ. Тус санд 2011-2013 онд Засгийн газрын төсвөөс 92.5 тэрбум төгрөг байршуулсан бөгөөд гол үйл ажиллагаа нь гэр хорооллын өрхүүдэд зориулсан утаагүй түлшний үйлдвэрлэл, утааны шүүлтүүр бүхий зуухны үйлдвэрлэлд санхүүгийн туслалцаа, татаас олгоход чиглэдэг байна. 2013 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар тус сан төсвийнхөө 67 тэрбум төгрөгийг зарцуулаад байв. Агаарын бохирдлыг бууруулахаар хэрэгжүүлж буй бусад төсөл, мөн улам дордож буй агаарын бохирдлын улмаас тус сангийн үр дүнг тодорхой үнэлэх боломжгүй юм.⁸⁶

3.13 НОГООН УУЛ УУРХАЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Засгийн газраас уул уурхайн салбарын хор хохирлыг багасгаж, орон нутгийн иргэд, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилго бүхий хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Одоогийн байдлаар Уул уурхайн яам ногоон уул уурхайн бодлогын төслийг боловсруулж батлуулсан.

Үүний зэрэгцээ, хэд хэдэн шийдмэг арга хэмжээ авсны нэг нь 2013 оны 6 дугаар сард БОНХЯ-наас байгаль орчинд хохирол учруулж буй үндэслэлээр Хятад руу нүүрс импортлох гол суваг болох Цагаан хадны боомтыг хаасан явдал байв. Түүнчлэн Уул уурхайн яам Засгийн газрын төсвөөс 1 тэрбум

төгрөг гаргуулан нөхөн сэргээлтийн мэргэжлийн компаниар уул уурхайн үйл ажиллагаанаас үлдэж хоцорсон нутаг дэвсгэрт нөхөн сэргээлт хийлгэх талаар судалж байгаа юм.⁸⁷

Жижиг хэмжээний уул уурхай, гар аргын олборлолтыг (ЖХУУГАО) хуульчлах, зохицуулалт хийх, шинэчлэх зорилготой хэд хэдэн ажлууд хийгдэж байна. Монгол Улсын Их Хурлаас 2010 онд ЖХУУГАО-ыг албажуулан баталгаажуулжээ. Тус салбар олон хүнийг ажлын байраар хангадаг учир хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулдаг, эрүүл мэндийн өндөр эрсдэлтэй гэх үндэслэлээр тус ажиллагааг хориглох санаачилга амжилтад хүрээгүй байна. Түүний оронд Засгийн газраас ЖХУУГАО-ыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, чадавх бүтээмж нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтуудыг авч явуулсан байна.

3.14 ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ

Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлээр мөн арга хэмжээ аван ажиллаж байна. Тухайлбал, 2009 оны 6 дугаар сард малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилго бүхий “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд энэ бодлогын хүрээнд малчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжих, нийгмийн даатгалд хамруулах болон бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх зэрэг зорилготой юм.⁸⁸ Энэ бодлогын зорилгын хэрэгжилтийг хангахын тулд малчин өрхөд газар өмчлүүлэх, орлогын албан татвараас чөлөөлөх зэрэг хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөр нь мөн хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зорилготой. Энэ хөтөлбөр нь 2010-2015, 2016-2021 гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжих бөгөөд хууль, эдийн засаг, тогтолцооны орчныг бүрдүүлэх, мал эмнэлэг, үржлийн үйл ажиллагааг сайжруулах, цаг уур, экологийн нөхцөлд дасан зохицсон сүрэг бий болгох, мал, малын гаралтай бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг бий болгох гэсэн 5 зорилготой юм.⁸⁹

Түүнчлэн Засгийн газар саяхан Хөдөө аж ахуйн бирж байгуулсан бөгөөд 2013 оны 5-ны өдөр анхны арилжаагаа хийсэн байна. Биржийн гол зорилго нь малчдад бараа бүтээгдэхүүнээ илүү өндөр үнээр борлуулах боломж олгох, тэднийг зах зээл дэх үнийн савлагаанаас хамгаалах явдал юм. Биржийн

85 Т.Эдвардс (2013).

86 UBPost (2013).

87- (2012). Уул уурхайн үйл ажиллагааны улмаас 4,256 га газар бохирдож, хаягджээ, News.mn, 2013 оны 4 дүгээр сарын 11.

88 Гадаад харилцааны яам (2010).

89 Гадаад харилцааны яам (2009).

үйл ажиллагаа явуулсан эхэн үед арилжаалсан гол түүхий эд нь ноолуур байсан байна.

Зудад өртөн малын тоо толгой буурах, хохирол амсахаас сэргийлэх зорилгоор Засгийн газар, Дэлхийн банкттай хамтран малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн байна. Уг даатгал нь төр, дотоодын даатгалын компаниудын түншлэлээр дамжин хэрэгждэг бөгөөд малчдыг хямд төсөр даатгалын үйлчилгээ авах боломжоор хангахын зэрэгцээ, даатгагч компаниудыг том хэмжээний алдагдал хүлээхээс сэргийлдэг аж.

Энэ бодлогын дагуу мал сүрэгт учирсан 6% хүртэлх бага хэмжээний хохирлыг малчид өөрсдөө, 6-30% хүртэлх хохирлыг даатгагч аж ахуйн нэгж, 30-аас илүү хувийн хохирлыг төр хариуцахаар заасан байна. Энэ хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш хамгийн өндөр нөхөн төлбөр буюу 1.3 тэрбум ам.долларыг 2009-2010 оны зуднаар нийт мал сүргийн 22% хорогдох үед төлж байжээ.

Түүнээс гадна зөгийн аж ахуй дахин сэргэж, Монголын ногоон эдийн засгийн нэгэн чухал хэсэг болоод байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжих үед зөгийн аж ахуй огцом уналтад орсон. Гэсэн хэдий ч Дэлхийн зөн, Дэлхийн байгаль хамгаалах сан болон олон улсын бусад байгууллагын хүчин чармайлтын дүнд олон эерэг өөрчлөлтүүд гарч байна. Тухайлбал, 2012 онд Монгол Улсад нийт 89 зөгийн аж ахуйн үйл ажиллагаа явуулж, 500 хүнийг ажлын байраар хангасан гэсэн тооцоо гаргажээ.

Засгийн газраас “Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2009-2016)”-ийг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд МУЗГ баруун болон зүүн бүс нутгаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг сэргээх, эрчимт фермерийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилго тавьжээ.⁹⁰ Нэн ялангуяа Халхын голын бүс нутаг дахь өмнө ашиглагдаж байсан болон шинэ тариан талбайг ашиглалтад оруулах зорилго бүхий “Халх гол” төсөлд ихээхэн ач холбогдол өгч байна.

Ногоон эдийн засгийг дэмжсэн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаарх бас нэг санаачилга бол “Ногоон ажлын байр –Чацаргана” үндэсний хөтөлбөр юм. Чацаргана нь Монголын байгальд ургадаг жимст ургамал. Энэ хөтөлбөрийн хүрээнд 620 га газарт суулгац тариалсан бөгөөд 215.6 га газрыг элсний нүүдлээс хамгаалсан уул уурхайн орхигдсон талбайг нөхөн сэргээсэн байв. МҮХАҮТ-ын “Органик Монголд үйлдвэрлэв” санаачилгын дор чацарганы тос, шүүсэнд Ногоон шошго өгсөн байна. Энэ хөтөлбөр нь нийт 4,591 ногоон ажлын байр шинээр бий болгосон гэсэн тооцоо бий.

Судалгааны байгууллагуудаас мөн орон нутгийн хөгжил, өнөөгийн нөхцөл байдлын талаар судалсан байна. Тухайлбал ЭЗБӨЧСТ-

өөс “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан” бие даасан иж бүрэн судалгааг жил тутам хийж буй бөгөөд энэхүү судалгаагаар нийт 21 аймгийн эдийн засаг, дэд бүтэц, засаглал, бизнесийн орчны төлөв байдлыг 180 орчим шалгуур үзүүлэлтээр хэмжин гаргадаг. Эдгээр үзүүлэлтүүд дунд ногоон хөгжилтэй шууд холбогдохуйц хэд хэдэн үзүүлэлт бий.

Үүний зэрэгцээ Үндэсний хөгжлийн хүрээлэнгээс (ҮХХ) Баянхонгор аймгийн сум тус бүрийн нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг судлах замаар тус аймгийн уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эмзэг байдлыг үнэлжээ. Харин 2013 Улсын төсвөөс энэ судалгааны дагуу сум тус бүрийн эмзэг байдлыг харгалзан төсвийн хуваарилалтыг хийсэн байна. Төсвийн хуваарилалтыг хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгэм, дэд бүтэц, ядуурлыг бууруулах гэсэн 5 үзүүлэлт дээр тулгуурлан хийжээ.

ҮХХ өөрийн судалгаан дээр үндэслэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, малчдыг сургах, мал аж ахуйн оновчтой менежментийг нэвтрүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байгаа аж. Тус хүрээлэн 2014 онд судалгаагаа дараагийн 6 аймагт үргэлжлүүлэх ба тус судалгааныхаа аргачлалыг үндэсний хэмжээнд ашиглах зорилготой байгаа юм.

3.15 ОЙН АЖ АХУЙН ХӨТӨЛБӨРҮҮД

МУЗГ 2001 оноос эхлэн Ойн тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөр нь Ой хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, нөхөн сэргээлт, ойн нөөцийн тогтвортой менежмент, Ойн хаягдлын хэрэглээ, гал түймэртэй тэмцэх, Ойд суурилсан аж ахуйг дахин сэргээх, шинэчлэх, Модон бус ойн бүтээгдэхүүн, Биологийн олон янз байдлыг хадгалах, тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцоо, Цөлжилтийн хяналт, Ойн судалгаа, технологийн дэвшил, Боловсрол, сургалт, олон нийтийг мэдээллээр хангах зэрэг зорилго бүхий 4 дэд хөтөлбөрөөс бүрддэг.

Одоогийн байдлаар хөтөлбөр 3 дугаар шатандаа хэрэгжиж буй бөгөөд энэ шат нь 2011-2015 онд үргэлжлэх юм. Тус хөтөлбөрийн зорилго нь экологийн тэнцвэр, тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чадавхыг дээшлүүлж байгаль орчин, ойн талаар төрөөс баримтлах бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход оршино.

Монгол Улс 2011 онд хөгжиж буй орнууд дахь ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах НҮБ-ын хөтөлбөрийн (REDD+) түнш орон болсон. Уг хөтөлбөр нь 1. Зохицуулалт

90 “Хүнсний аюулгүй байдал” Үндэсний хөтөлбөр (2009)

буюу REDD+ үйл ажиллагааг хэн удирдан зохицуулах, мөн оролцогч талууд хэрхэн хувь нэмрээ оруулах; 2. Үндэсний REDD+ стратегийг бэлтгэх буюу ойн хомсдол, доройтлыг бууруулахын тулд бодлогын баримт бичгийг батлах, байгаль орчны болон нийгмийн сөрөг нөлөөллөөс хэрхэн сэргийлэх; 3. Хүлэмжийн хийн ялгарлын хяналтын түвшин/хяналтын түвшин (ХХЯХТ/ХТ)-г тогтоох; 4. Хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт (ХТБ)-ын системийг бий болгох гэсэн үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй аж.

3.16 УС, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Засгийн газраас “Ус” үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөр нь усны нөөцийн хуримтлалыг бий болгох, уул уурхайн салбарт хаягдал бохир усыг эргүүлэн ашиглах зэрэг зорилтууд дэвшүүлсэн. Үүний үр дүнд, Энержи Ресурс ХХК хаягдал усныхаа 95%-ийг дахин ашиглаж эхэлсэн ба Оюу толгой ХХК-ийг хаягдал усныхаа дор хаяж 80%-ийг дахин ашиглах шаардлага тавиад байгаа юм.

Улаанбаатар хотын захиргаанаас хог ангилах үйлдлийг хэвшүүлэх зорилгоор өрх тус бүрийг 1 сарын хэрэглээний 15 хогийн уутаар хангаж эхлээд байна. Энэ нь ангилсан хогийг дахин боловсруулах зорилгоор тусад нь ачихад чиглэсэн алхам хэдий ч хог хаягдлыг ангилах талаарх олон нийтийг хамарсан соён гэгээрүүлэх ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна. Хотын захиргаанаас уг хогны уутыг үйлдвэрлэхэд 5.0 тэрбум төгрөг зарцуулсан хэдий ч одоогийн байдлаар тус уутанд хогийг ангилалгүй хийсэн хэвээр байгаа юм. Ангилан хийх эрмэлзэл байсан ч зориулалтын олон өнгөөр бус дан ганц ногоон өнгөтэй хийсэн тул ямар ч ялгаагүй юм. Хаягдал гялгар уутны био-задралын хугацаа урт учир энэ санаачилгыг дахин боловсруулах үйл ажиллагаатай хослуулан хэрэгжүүлэхгүй тохиолдолд хүрээлэн буй орчинд бүр ч илүү хор хохирол учруулах эрсдэлтэй.

3.17 ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Монгол Улсад аялал жуулчлалын салбарыг ажлын байр, орлогын эх үүсвэрийг бий болгож, хөдөө орон нутгийн хөгжлийг хурдасгах, эдийн засгийн төрөлжилтийг хангах тэргүүний ач холбогдол бүхий салбар болгон хөгжүүлэх бодит шаардлагатай тулгараад байна. Гэхдээ аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ хүрээлэн буй орчин, Монголын уламжлалт соёлыг хамгаалах шаардлагатай тул ногоон аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь үр дүнтэй юм. Ногоон хөгжлийн стратегид энэхүү ач холбогдлыг тусгасан бөгөөд үйл ажиллагааны нэгэн гол чиглэлийг “Аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгож, байгалийн, соёлын болон эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах” хэмээн тодорхойлжээ.

Энэ стратегийг дэмжих үүднээс Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас Аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн найруулсан төсөл боловсруулж байгаа аж. Энэ хууль батлагдсанаар тус яам хүрээлэн буй орчинд ээлтэй хог хаягдал, усны менежментийг нэвтрүүлэх замаар аялал жуулчлал, нэн ялангуяа эко аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах боломжтой болох юм.

4. Засгийн газраас чинад: Ногоон эдийн засгийг хөгжүүлэх нь

Засгийн газраас авч хэрэгжүүлж буй Ногоон хөгжлийн стратегиас гадна хувийн хэвшил, төрийн бус болон олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй санаачилгууд нь ногоон үйлдвэрлэлийг дэмжих тусгай хөтөлбөрүүд, агаарын бохирдлыг бууруулах, ойн хамгааллын, усны оновчтой менежментийг нэвтрүүлэх зэрэг хөтөлбөрүүдээр дамжин хэрэгжиж байна.

4.1 ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хувийн хэвшлийн байгууллагуудын зүгээс ногоон хөгжлийн бодлогод нийцэхүйц нийгмийн хариуцлагатай зарим санаачилгууд гарч буйг тэмдэглүүштэй. Зарим байгууллага өөрсдийн ногоон стратегийг боловсруулан ажиллаж байна.

Түүнчлэн, бизнесийн байгууллагуудын төлөөлөл болох Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрлэлийн танхим (МҮХАҮТ)-аас “Ногоон ном” хэвлэн гаргадаг.⁹¹

МҮХАҮТ-ын “Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих үндэсний хөтөлбөрт” “5x20” санаачилгыг тусгасан бөгөөд 2020 он гэхэд Монголын эдийн засгийн хүрэхийг зорих 5 үзүүлэлтийг жагсаажээ. Үүнд:

- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг нэгж ДНБ тутамд 20%-иар бууруулах;
- Эрчим хүч ашиглалтын ашигт байдлыг 20%-иар өсгөх;
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нийт эрчим хүчний үүсгүүрийн 20% хүргэж өсгөх;
- Байгалийн нөөц баялаг дахь хөрөнгө оруулалтыг 20%-иар өсгөх;
- “Ногоон худалдан авалт”-ыг төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын худалдан авалтын 20% болгож өсгөх.

Мөн уг стратегид жил бүрийн ДНБ-ий 2-оос доошгүй хувийг Ногоон хөрөнгө оруулалт болгон хийхийг уриалсан бөгөөд 2013-2015 он хүртэлх эхний 3 жилийг хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу шилжих шилжилтийн үе, 2016-2020 оныг нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт багатай, ногоон өсөлтийн загварыг нэвтрүүлэх, хөгжүүлэх үе хэмээн тооцоолжээ.

Хүснэгтэд үзүүлсэнчлэн МҮХАҮТ-аас дэвшүүлсэн стратеги нь Засгийн газрынхтай адил өргөн цар хүрээ, хэт өндөр зорилго дэвшүүлээгүй. Жишээ нь 2020 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 2006 оны суурь үзүүлэлттэй харьцуулахад 2 дахин бууруулна гэсэн бол МҮХАҮТ-ийн хувилбарт 2010 оны суурь үзүүлэлттэй харьцуулахад 20%-

иар бууруулна гэж заажээ. Өөрөөр хэлбэл, НХС-д нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг 2020 он гэхэд ДНБ-ий 1 ам.доллар бүрд 4.885 кг болгож бууруулах зорилт дэвшүүлсэн бол МҮХАҮТ-ийн хувилбарт ДНБ-ий 1 сая ам.доллар тутамд 6 тонноор бууруулахыг зорьсон байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг 20%-д хүргэнэ гэж дээрх 2 бодлогын баримт бичгийн аль алинд нь заасан хэдий ч энэ нь Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулинд заасантай холбоотой юм.

Тус стратегийн цар хүрээ өргөн биш бөгөөд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах болон эрчим хүчний үйлдвэрлэлтэд гол анхаарлаа хандуулж, дундаж наслалт, газрын менежмент зэрэг илүү өргөн цар хүрээ бүхий асуудлуудыг хамруулаагүй байна.

Хэдий хязгаарлагдмал цар хүрээтэй ч МҮХАҮТ-аас боловсруулсан стратеги нь Ногоон эдийн засгийг хөгжүүлэх асуудлаар тус байгууллагуудын эрмэлзлийг илэрхийлсэн баримт бичиг юм.

91 “Хүнсний аюулгүй байдал” Үндэсний хөтөлбөр (2009)

ХҮСНЭГТ 2: НХҮБ БОЛОН МҮХАҮТ-ИЙН 2012 ОНЫ НОГООН НОМОНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛГУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

НХҮБ-д дэвшүүлсэн зорилтууд	МҮХАҮТ-ийн 2012 оны Ногоон номонд дэвшүүлсэн зорилтууд	Суурь үзүүлэлт
Хүлэмжийн хийн ялгаруулалт		
Хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2020 он гэхэд 2006 оны түвшин болох 9.77 кг/ам.доллараас 2 дахин буюу ДНБ-ий 1 ам.доллар бүрт 4.885 кг-тай тэнцэх хэмжээгээр бууруулах.	Хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2020 он гэхэд 2010 оны түвшинтэй харьцуулахад ДНБ-ий 1 сая ам.доллар тутамд 6 тонноор бууруулах.	Одоогийн байдлаар хүлэмжийн хийн ялгаруулалт дэлхийн дунджаас 10 дахин их буюу ДНБ-ий 1 сая ам.доллар тутамд 7,5 тонн байна.
Сэргээгдэх эрчим хүч		
Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн нийт эрчим хүчний үүсгүүрт эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 20% хүртэл нэмэгдүүлэх.	Сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 20% хүртэл нэмэгдүүлэх.	Одоогийн байдлаар сэргээгдэх эх үүсвэрээс гаргаж авсан эрчим хүч нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн дөнгөж 4.5%-тай тэнцэж байгаа бөгөөд үлдсэн 95.5%-ийг нүүрсний цахилгаан станцуудаас гарган авч байна.
Эрчим хүч хэрэглээний ашигт байдал		
Холбогдох заалт байхгүй.	Эрчим хүч хэрэглээний ашигт байдлыг 2010 оны түвшинтэй харьцуулахад 2015 он гэхэд 5%-иар, 2020 он гэхэд 20%-иар нэмэгдүүлэх.	Өнөөдрийн эрчим хүчний ашиглалт дэлхийн дунджаас 7 дахин өндөр байна (3.04 кг нүүрс/ам.доллар харьцах нь 0.39 кг/ам.доллар), (НҮБ-ын Үйлдвэрлэл хөгжлийн байгууллага, UNIDO, 2011)
Ногоон худалдан авалт		
2020 он гэхэд төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын худалдан авалтын дор хаяж 20%-ийг ногоон худалдан авалтаар нийлүүлэх.	Ногоон худалдан авалтыг 2015 он гэхэд нийт худалдан авалтын 5%, 2020 он гэхэд 20% болгож нэмэгдүүлэх	Мэдээлэл байхгүй.
Байгалийн нөөц баялаг		
Холбогдох заалт байхгүй.	Байгалийн нөөц баялагт хийх хөрөнгө оруулалтыг 2015 он гэхэд 2010 оны түвшинтэй харьцуулахад 10%-иар, 2020 гэхэд 20%-иар өсгөх.	Мэдээлэл байхгүй.
Усны менежмент		
Нийт хүн амын дор хаяж 90%-ийг ариун цэврийн шаардлага хангасан ундны усаар хангах, ус цэвэршүүлэх байгууламжийн хүртээмжийг дор хаяж 80%-иар өсгөх, гэр ахуйн хаягдал ус болон саарал усыг дахин ашигладаг болох. Аж үйлдвэрийн хаягдал усыг стандартын дагуу цэвэршүүлэх технологи нэвтрүүлэх, ашиглагдсан усны дор хаяж 60%-ийг дахин ашиглах.	2015 он гэхэд гүний ус болон гадаргын усны хэрэглээний харьцааг 30:70-д хүргэх, гүний ус болон гадаргын усны хэрэглээний харьцааг 50:50 болгох.	2011 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 85% нь сайжруулсан эх үүсвэрээс ундны усаа авч байна. Энэ үзүүлэлт 2001 онд 67% байсан.
Ногоон хөрөнгө оруулалт		
Жил тутмын ДНБ-ий дор хаяж 2%-ийг ногоон хөгжилд зориулах.	Жил тутмын ДНБ-ий дор хаяж 2%-ийг Ногоон хөрөнгө оруулалтад зарцуулах.	Мэдээлэл байхгүй.

НХҮБ-д дэвшүүлсэн зорилтууд	МҮХАҮТ-ийн 2012 оны Ногоон номонд дэвшүүлсэн зорилтууд	Суурь үзүүлэлт
Дундаж наслалт		
2020 он гэхэд дундаж наслалтыг 72-т хүргэх	Холбогдох заалт байхгүй.	2001 онд дундаж наслалт 63.7 байсан бол 2011 оны байдлаар 68.5 болж өсчээ. Дундаж наслалт жил тутам дунджаар 0.5 жилээр өсөхөд 2020 он гэхэд 72.8 жил болох боломжтой
Газрын менежмент		
2020 он гэхэд нийт газар нутгийн дор хаяж 25%-ийг үндэсний цэцэрлэгт хүрээлэн болгож, хамгаалалтыг сайжруулах. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь: ховор буюу нэн ховордсон амьтан, ургамлын тархац нутгийн дор хаяж 70%, ойн бүрхүүл, томоохон гол нууруудын эхийн дор хаяж 60%-ийг хамарсан байх ёстой. Жил тутам төсвийн хөрөнгөөр 10,000 га ойг нөхөн сэргээж байх.	Холбогдох заалт байхгүй.	Дэлхийн банкны судалгаагаар өнөөгийн байдлаар Монголын нийт газар нутгийн 13.4% нь тусгай хамгаалалттай бүсэд багтаж байна.
Эдийн засгийн хөгжил/Бүтцийн өөрчлөлт		
2020 он гэхэд аж үйлдвэрийн салбарын 40%-ийг эзлэх.	Ногоон эдийн засгийн урамшуулал, санхүүгийн хөшүүрэг бий болгож нэвтрүүлэх.	2013 оны 6 дугаар сар хүртэл 1 жилийн хугацаанд аж үйлдвэрийн салбар нийт ДНБ-ий 6.2%-тай тэнцэж байв.

4.2 НОГООН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ДЭМЖИХ НЬ

Ногоон бүтээгдэхүүнийг шошгожуулах ажлын хүрээнд хэрэгжүүлж буй нэгэн ажил нь МҮХАҮТ-ын Ногоон зочид буудал, эко шошго санаачилга юм. Энэхүү сайн дурын шошгыг 2012 онд хүрээлэн буй орчинд ээлтэйгээр үйл ажиллагаа явуулж буй зочид буудлуудад олгож эхэлжээ. Тус шошго нь ус, эрчим хүчний хэмнэлт, хог хаягдлыг бууруулах, ажиллагсад болон зочдыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах зэрэг нийт 14 шалгуур үзүүлэлттэй аж.

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хувьд МҮХАҮТ нь БОНХЯ-тай хамтран олон улсын дүрэм журамд нийцсэн ногоон бүтээгдэхүүний шошгыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мөн тус танхим Амстердамын их сургуулийн харьяа тогтвортой байдал, зөвлөх үйлчилгээний IVAM хүрээлэн болон Австрийн GrAT ХХК-тай хамтран эко шошгожуулалтыг хөгжүүлэх замаар ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах Европын комиссын туршлага, экспертизийг нэвтрүүлэх зорилгоор “Ногоон бүтээгдэхүүний хөгжүүлэлт ба шошгожуулалт” төслийг хэрэгжүүлжээ. Энэхүү төсөлд Монгол даяар эко дизайн, ногоон үйлдвэрлэлийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг

22 үйлдвэрийг сонгон авч хамруулсан ба одоогийн байдлаар шошгожуулалтын асуудлаар дагнасан шинэ хүрээлэн байгуулахаар судалж байна.

Үүний зэрэгцээ МҮХАҮТ-аас органик хүнсний бүтээгдэхүүнийг сурталчлахад чиглэсэн “Органик Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд органик хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, шагнал олгох, худалдааны төвүүдэд ногоон бүтээгдэхүүний тусгай лангуу байрлуулах зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байна. Одоогийн байдлаар 23 орчим бүтээгдэхүүнд “Органик Монголд үйлдвэрлэв” шошго болон “ногоон бар код” олгоод байгаа аж.

4.3 НОГООН БАНК, НОГООН ЗЭЭЛ

Банк санхүүгийн байгуулагууд болон МҮХАҮТ ногоон санхүүжилт, зээлийн бүтээгдэхүүн болон тэтгэлгийн төслүүдийг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Нидерланд Улсын санхүүжилтээр МҮХАҮТ Ногоон зээлийн батлан даалтын сан байгуулан, эрчим хүчний хэмнэлт бүхий аж ахуйн нэгжүүдийг дэмжиж Бээжин дэх Нидерландын Вант Улсын Элчин сайдын яамны тэтгэлэг олгох үйл ажиллагаа явуулж байна.

Тус сангийн зорилго нь эрчим хүчний хэмнэлтийг сайжруулахад чиглэсэн өөрчлөлт,

ногоон хөрөнгө оруулалт, цэвэр үйлдвэрлэлийг санхүүжүүлэх зорилготой зээлд батлан даалт гаргах юм. НЗБДС нь эрчим хүчний хэмнэлт, хүрээлэн буй орны хамгаалалтай холбоотой бусад төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд тулгардаг батлан даалтын хөрөнгө хангалтгүй байх гэсэн гол бэрхшээлийг арилгахад тус болно хэмээн найдаж байгаа аж. Түүнээс гадна, батлан даалт гаргаснаар зээлийн эрсдлийг бууруулж, зах зээлийн хувиас илүү бага хүүтэйгээр зээл олгох боломжтой болно хэмээн үзэж байна.

Тус сангаас 2012 он хүртэл 3 жилийн хугацаанд нийт 415.5 сая төгрөгийн зээлийг түлш шатахуун, эрчим хүчний хэмнэлт, ус цэвэршүүлэлт, хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 аж ахуйн нэгжид олгожээ. Энэ зээлийн 20-80%-ийг тус сангийн өөрийн батлан даалтаар гаргасан аж.

Үүний зэрэгцээ НЗБДС 2007 онд Засгийн газраас 1 тэрбум төгрөгийн бага хүүтэй зээл авч эргэн төлөлтийн хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр 13 ЖДҮ-т тараажээ.

Түүнчлэн Хас болон Голомт банкууд ногоон бизнес, өрхийн аж ахуйд мөн хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээ үзүүлдэг байна.

Хас банкны хувьд өөрийн олон улсын түнш Микро Энэржи Кредитс компанитай хамтран шинэлэг арга барилаар ажилладаг ба ногоон бүтээгдэхүүнээ өрхийн болон бизнесийн зээл хэлбэрээр санал болгодог аж. Хувийн байшин эзэмшигчид Хас банкаар дамжуулан байшингийн дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй халаалтын зуух худалдан авах зориулалтаар бичил зээл авахаар хандаж болно. Одоогийн байдлаар тус банк 3 төрлийн өрхийн бичил зээл санал болгож байгаа нь: эрчим хүчний хэмнэлттэй зуух, гэрийн дулаалга, эрчим хүчний хэмнэлттэй түлш. Түүнчлэн бүтээгдэхүүний үнийг харьцангуй хямд байлгахын тулд Засгийн газрын татаасыг ашигладаг байна. Ийм зээлд хамрагдсан ихэнх өрхүүдийн хувьд эхний сараасаа эхлэн санхүүгийн хэмнэлт гаргаж эхлэхийн зэрэгцээ дулаан гэр, илүү цэвэр агаар гэсэн давуу талтай болох юм.

Мөн Хас банкнаас дотоодын утаагүй зуух, гэрийн дулаалга үйлдвэрлэгчдийг дэмжихэд зориулсан эхлэлийн зээлийг олгодог байна.

Голомт банкны хувьд эко зээлийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлсэн ба хүрээлэн буй орчны нөлөөллийн үнэлгээ нь тэдний зээлийн үнэлгээний нэгэн салшгүй хэсэг болжээ. Тус банк зээлийн бодлогоороо дамжуулан хүрээлэн буй орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй үйлдвэрлэлийг дэмждэг байна. Тус банкнаас мэдэгдсэнээр, тэд хүрээлэн буй орчинд хор хөнөөлтэй байх аливаа төслийг дэмждэггүй аж.

Түүнээс гадна, Голомт банк нь Монгол

Улсын Сангийн яам, Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ЖАЙКА)-ээс хамтран хэрэгжүүлж буй Хоёр-шатлалт зээлийн хөтөлбөрийн хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлж буй арилжааны банкууд дундаас хүрээлэн буй орчныг хамгаалах зориулалттай зээл олгож буй цорын ганц оролцогч аж.

4.4 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хэд хэдэн санал санаачилга өмнө нь гарч байсан. Тухайлбал, 2005 онд МУЗГ, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо (ҮЭХ), Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (АОЭНХ) хамтран Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр 2005-2008 онд Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр, 2006-2010 онд Зохистой хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлжээ. Эдгээр хөтөлбөрийн дагуу зохистой хөдөлмөр эрхлэлт гэдэг нь дараах шалгуурыг хангасан байх ёстой аж:

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоосон дүрэм журамтай байх,
- Эвлэлдэн нэгдэх, хамтын үзэл бодлоо илэрхийлэх, хэлэлцэн тохиролцох эрхтэй байх,
- Ажлын байрны аюулгүй байдал, ажлын онцлогоос шалтгаалсан эрүүл мэндийн асуудлын талаар зохицуулсан байх,
- Хүчээр буюу албан хүчээр хөдөлмөр эрхлэхийг хорьсон байх,
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хорьсон байх,
- Ажил мэргэжил олж авахтай холбоотой ялгаварлан гадуурхахыг хорьсон байх.

Зохистой хөдөлмөр эрхлэлт болон Ногоон ажлын байрны өнөөгийн төлөв байдлын талаар ЭЗБӨЧСТ-с НЭЗЗТТ хөтөлбөрийн хүрээнд хийсэн “Ногоон ажлын байрны зураглал” судалгаанд илүү дэлгэрэнгүй тодорхойлсон.

4.5 ЭРЧИМ ХҮЧНИЙ АШИГТ БАЙДАЛ БОЛОН ЦЭВЭР ҮЙЛДВЭРЛЭЛ

Энэ чиглэлээр МҮХАҮТ-ын Цэвэр хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих газраас хүрээлэн буй орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд хэмнэлттэй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зорилгоор Цэвэр үйлдвэрлэлийн зарчмуудыг авч хэрэгжүүлдэг байна.

Тус газар нь Засгийн газар, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр Цэвэр үйлдвэрлэлийн Үндэсний хөтөлбөрийг боловсруулахаар ажиллаж байгаа аж. Тус хөтөлбөр дараах үйл ажиллагааг хамрах юм. Үүнд:

- НҮБХБОХ-өөс гаргасан “Цэвэр үйлдвэрлэл, эрчим хүчний хэмнэлтийн гарын авлага”-ын дагуу үйлдвэр, аж ахуйн нэгжийн эрчим хүч хэмнэх боломжийг тодорхойлох зорилгоор цэвэр үйлдвэрлэлийн үнэлгээ хийх;
- Амстердамын их сургуультай хамтран эрчим хүчний ашигт байдал, Эрчим хүчний компаниудын (ЭХК) талаар тусгайлан сургалт явуулах;
- Аж ахуйн нэгжүүдэд эрчим хүчний менежментийн тогтолцоог нэвтрүүлэх;
- Эрчим хүчний ашигт байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл боловсруулж, хэрэгжүүлэх;
- ЭХК-ийн үйлчилгээний талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх;
- Ногоон ажлын байрны заавар боловсруулах;
- “Ногоон үйлдвэрлэл, ногоон эдийн засаг” цуврал CD боловсруулж гаргах.

Эрчим хүчний ашигт байдлыг нэмэгдүүлэх шууд зорилго бүхий олон улсын байгууллагуудаас санхүүждэг хэд хэдэн хөтөлбөр бий. Тухайлбал, НҮБХХ-өөс Улаанбаатар хотноо Барилга байгууламжийн эрчим хүчний ашигт байдлыг нэмэгдүүлэх (ББЭХАБН) төслийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь Монголын орон сууцны зах зээлд эрчим хүчний хэмнэлттэй барилгын технологи, үйлчилгээ, хүрээлэн буй орчинд ээлтэй хувийн байшингийн дулаалгыг нэвтрүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн санхүүжилтийн тогтолцоог бий болгоход хувь нэмэр оруулах зорилготой юм. Уг төсөлд шинээр ашиглалтад орж буй барилга байгууламжаас гадна гэр, хувийн байшингууд хамрагдаж байгаа бөгөөд 2009-2013 онд 3,815,000 ам.долларын төсөвтэйгээр хэрэгжиж байна.⁹²

Түүнчлэн, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран нийслэлийн 3 сургуулийн дулаан хангамжийг сайжруулах техникийн төсөл хэрэгжүүлсэн. Уг төсөлд №63, №79-1, №79-2 дугаар сургуулиуд хамрагдсан бөгөөд нарны эх үүсвэр ашиглах, дулаалгыг сайжруулах замаар эдгээр сургуулиудын барилгын дулаан хангамжийг нэмэгдүүлсэн байна. Түүгээр зогсохгүй, төслийн хэрэгжилтэд дотоодын ажилчид, инженер, архитекторуудыг ажиллуулсан нь тэднийг хүрээлэн буй орчинд ээлтэй барилгын технологийн талаар газар дээр нь сургасан ач холбогдолтой бөгөөд багш, сургагчдын мөн цэвэр эрчим хүчний модулиар хангасан байна. Төсөл 13 сарын хугацаанд хэрэгжсэн ба 1,517,000 ам.доллар байсан байна.⁹³

4.6 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХУВИЙН ХЭВШЛИЙН САНААЧИЛГУУД

Монголын сэргээгдэх эрчим хүчний салбар нь ногоон эдийн засгийн хамгийн ирээдүйтэй салбар гэхэд болно. Одоогийн байдлаар сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, турших, үйлдвэрлэх чиглэлээр нийт 12 компани, 1 хүрээлэн үйл ажиллагаа явуулж байна.

Өнөөдөр Монголд 2 салхин цахилгаан станц ажиллаж байгаагийн нэг нь Дорноговь аймгийн Хатанбулаг суманд байрладаг ба нөгөө нь Улаанбаатар хотоос 70 км орчим зайд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дээрх Салхитын станц юм. 2013 оны 6 дугаар сарын 20-нд ашиглалтад орсон Салхитын салхин станц нь Монголын анхны томоохон хэмжээний сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр бөгөөд *Монгол Улсын төр, хувийн хэвшил, олон улсын хөгжлийн байгууллагуудын нягт хамтын ажиллагааны дүнд хэрэгжсэнээрээ чухал ач холбогдол бүхий төсөл* юм. Тус станц нь 50 мега ватт буюу сүлжээнийхээ нийт хүчин чадлын 5% гаруйг үйлдвэрлэж буй 31 салхин турбинтай аж.⁹⁴

Салхитын цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажил анх 2011 онд эхэлсэн.⁹⁵ Төслийн санхүүжилтэд хөрөнгө оруулалт болон зээлийн эх үүсвэрээс 47.5 сая ам.долларыг ЕСБХБ, мөн хэмжээний санхүүжилтийг Нидерландын хөгжлийн бакнаас гаргажээ. Уг төслийг Клин Энержи ХХК хэрэгжүүлдэг ба тус компанийн 51%-ийг Монголын технологийн компани болох Ньюком, тус тус 14%-ийг ЕСБХБ болон Нидерландын хөгжлийн банк, үлдсэн 21%-ийг Женерал Электрик ХХК эзэмшдэг байна.⁹⁶

Тус салхин станц нь нүүрстөрөгчийн хийн ялгарлыг 180 мянган тонноор бууруулж, байгаль орчинд ээлгүй эрчим хүчний чиглэлд олгогдсон зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээг бууруулах сайн талуудтай юм. Өөрөөр хэлбэл жилдээ 1.6 сая тонн цэвэр ус хэмнэж, нүүрсний хэрэглээг 122 мянган тонноор бууруулах аж. Түүнчлэн уг төсөл хэрэгжсэнээр ногоон ажлын байр бий болгосон ба оргил үед ажиллаж байсан нийт 500 ажилчдын 94% нь монгол ажилчид байсан байна. Бүтээн байгуулалтын ажил дууссаны дараа тус станцад 25-30 хүн тогтмол ажиллах юм.

Салхит төсөл хэрэгжиж эхэлснээр Монголын сэргээгдэх эрчим хүчний салбарыг гадныхан сонирхох сонирхлыг сэргээсэн гэхэд болно. Энэ төслийн хүрээнд эрчим хүчний салбарт шинэ, дэвшилт технологи, нөү-хау нэвтрүүлсэн.

92 М.Бадраа, М.Санжаасүрэн, А.Мөнхгэрэл (2012). Барилгын дулааны ашигт байдлыг нэмэгдүүлэх төслийн дүнд хугацааны үнэлгээ, Улаанбаатар 2012.

93 АНУ-ын Элчин сайдын яам, Монгол Улс (2012).

94 ЕСБХБ (2013).

95 Д.Бэхбаяр (2013), Хуудас -14

96 ЕСБХБ (2013).

Тус салхин цахилгаан станцаас гадна цэвэр эрчим хүчний бусад эх үүсвэрүүдээс дурдвал, нийт 100 хүртэл киловаттын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал бүхий нарны эрчим хүчний 10 байгууламжийг дараах аймгуудад байгуулсан байна. Үүнд, Өмнөговь (1), Говь-Алтай (3), Баянхонгор (1), Баян-Өлгий (3) аймгууд оржээ. Үүний зэрэгцээ, 150-200 киловаттын хүчин чадал бүхий нар, салхины хосолсон 3 цахилгаан станц мөн багтана.

Түүнчлэн, тус бүр 11-2000 киловаттын хүчин чадал бүхий 11 усан цахилгаан станц байдаг. Өвлийн улиралд гол мөстөн хөлддөг учир одоогоор ашиглагдаж буй усан цахилгаан станцууд нь хүчин чадлынхаа маш бага хэсгийг ашиглаж байна. Дэлхийн байгаль хамгаалах сангаас эдгээр цахилгаан станцуудын ашиг тус нь байгаль орчинд учруулж буй хор хохиролтой зүйрлэхээргүй бага байна хэмээн зовниж буйгаа илэрхийлжээ.

Түүнээс гадна Өмнөговь аймагт нар, салхины ферм шинээр байгуулах төлөвлөгөө бий. Одоогийн байдлаар Ньюком Групп, Японы Софтбанктай хамтран 300 мегаваттын хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах техник эдийн засгийн үнэлгээг хийж байна. Энэ төсөл хэрэгжвэл, Салхитын салхин станцаас 6 дахин илүү хүчин чадалтай болох юм.

Түүнчлэн гэрт оршин суугч өрхүүдийг нарны эрчим хүчээр хангах хэд хэдэн төсөл хэрэгжсэн. Дэлхийн банк Сэргээгдэх эрчим хүч, хөдөө орон нутгийг эрчим хүчээр хангах төслөөрөө дамжуулан Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн 100,000 Нарны гэр үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн уг төслөөс сум, дүүргийн түвшинд цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулахад туслах зорилгоор жижиг сүлжээг засварлах, сэргээгдэх эрчим хүчний хосолсон технологи суулгах замаар тэдгээрийн эрчим хүчний хангамжийг сайжруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна.⁹⁷

Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагаас ногоон эрчим хүчний төслүүдээрээ дамжуулан Монгол дахь ногоон эрчим хүчний тогтолцоог өргөжүүлэх стратегийг боловсруулж байна. Тус төслийн хүрээнд эрчим хүчний салбарын хөгжлийн 3 гол хувилбарыг тодорхойлон боловсруулж үнэлэх замаар Монголын эрчим хүчний салбарын үнэлгээг хийхийн зэрэгцээ ногоон эрчим хүч, ногоон хөгжлийг хангах гол санал санаачилгын төслийг боловсруулж байгаа аж. Энэхүү төслийг Стокхольмын хүрээлэн буй орчны хүрээлэнгийн АНУ дахь төв болон Монголын зөвлөхүүдийн баг хамтран гүйцэтгэж байна.⁹⁸

97 Дэлхийн банк (2013). Монгол Улс: Нүүдэлчин өрхүүдэд зориулсан Зөврийн нарны эрчим хүч

98 Ж.Канг (2013) ДДНХХ-ын Монгол дахь хөтөлбөр, НЭЗТТ-ын хурлын үеэр хийсэн танилцуулга.

4.7 УЛААНБААТАРЫН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ НЬ

Улаанбаатарын агаарын бохирдлыг бууруулах зорилго бүхий олон улсын санхүүжилттэй хэд хэдэн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Агаарын бохирдлын дийлэнх хувийг гэр хорооллын зуухны утаа эзэлдэг учир утаа бага ялгаруулдаг зуух, гэрийн дулаалга зэрэгт чиглэсэн төслүүд зонхилж байна.⁹⁹

АНУ-ын Мянганы сорилтын сан корпорацийн санхүүжилт бүхий эрчим хүч, хүрээлэн буй орчны төсөл (ЭХХБОТ) томоохон төслүүдийн нэгд тооцогдож байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 31.3 сая ам.долларыг гэр хорооллын өрхүүдэд эрчим хүчний хэмнэлттэй, утаа бага ялгаруулдаг зуух, гэрийн дулаалга зэрэг бүтээгдэхүүнийг худалдан авахад татаас болгон өгсөн байна. Хэрэгжилтийн хамгийн оргил үедээ тус хөтөлбөр нь 42 худалдааны цэг, 150 байнгын ажиллагсадтай байсан. Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр утаагүй зуухны худалдан авалтын зардлын 90%-ийг санхүүжүүлж, зуух тус бүрийн зардлыг хамгийн доод тал нь 20 ам.долларт хүргэсэн нь анхны үнийнх нь 10% хувьтай тэнцэж байлаа. МСС-аас 47 сая ам.долларын санхүүжилтийг (төслийн нийт санхүүжилтийн 80% орчим) гаргасан бол МУЗГ-аас үлдсэн 20%-ийг санхүүжүүлжээ.

ЭХХБОТ 2012 оны 11 дүгээр сард хаагдсан. Тус хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд ойролцоогоор 100,000 ширхэг утаагүй зуух, 20,000 ширхэг гэрийн дулаалгын иж бүрдэл, 4500 пин, болон эрчим хүчний хэмнэлтэй 100 байшин зарж, Улаанбаатарын гэр хорооллын 100,000 орчим өрхөд санхүүгийн хэмнэлт гарган, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулжээ.

Уг хөтөлбөрийн дараа Дэлхийн банкнаас утаагүй зуухны хөнгөлөлттэй борлуулалтыг Улаанбаатарын цэвэр агаар төслөөр дамжуулан гүйцэтгэж байна. Тус төсөл нь дараах 3 үе шаттай:

1. Гэр хорооллын бүсийн агаар дахь тоосонцорын агууламжийг бууруулах.
2. Улаанбаатарын төвийн бүсийн агаар дахь тоосонцорын агууламжийг бууруулах. Энэ үе шат нь 4 дэд хэсгээс бүрдэнэ, үүнд: (1) хотын ногоон байгууламж хангалтгүйгээс үүсч буй

99 Гэр халаалтын зуухны нэг үндсэн загварыг 2009 онд Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэгээс (GIZ) боловсруулсан. Зуух нь дулаан хадгалахын тулд тоосгоор гадарладаг учир бага түлш хэрэглэдэг бөгөөд агаарын солилцооны 2 сувагтай учир шаталтын температурыг өсгөн, утаа ялгаралтыг бууруулдаг байна. Энэ зууханд бүх төрлийн түлш, дээд зэрэглэлийн коксжих нүүрс ч хэрэглэх боломжтой бөгөөд төслийн хүрээнд тараагдсан зуух нь уламжлалт зуухнаас 20-30%-иар бага түлш хэрэглэнэ. Гэрийн дулаалгын загварыг НҮБХХ-ийн шугамаар гаргасан ч Монголд үйлдвэрлэсэн. Тэдгээр нь гэрийн гадаргуу бүхэлд нь бүрхэх 3 тусдаа бүрээснээс бүрдсэн. Гэрийн дулаалга нь дулаан алдалтыг бууруулж, сар тутам хэрэглэдэг түлшийг 50%-иар бууруулсан гэсэн тооцоо бий.

тоосыг бууруулах; (2) ДЦС-ын утаа, үнсний хаягдлаас үүсч буй тоосыг бууруулах; (3) дүүргийн халаалтын техник, эдийн засгийн судалгаа, мэдлэгжүүлэх; мөн (4) хямд төсөр орон сууцаар хангах бодлогод техникийн туслалцаа үзүүлэх.

3. Олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулах, хөтөлбөрийн зохион байгуулалт, төслийн менежмент.

Дэлхийн банк болон МУЗГ эдгээрийн хөнгөлөлтийн санхүүжилтийг тэнцүү хуваан гаргаж байгаа. Түүнчлэн, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр МУЗГ 45 сая орчим ам.долларын хөрөнгийг хандивлагчдаас татсан байна. Мөн Дэлхийн банкнаас нэмэлт 15 сая ам.долларын зээлийг Улаанбаатарын Цэвэр агаар санд зориулан гаргасан бөгөөд Нийслэлийн удирдлагаас уг төслийг хариуцан хэрэгжүүлж байна.

Олон улсын дэмжлэг, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслийг цаашид 2-3 жил хэрэгжүүлээд аажмаар зогсоох төлөвлөгөөтэй байгаа юм. Үргэлжлүүлэх 90%-ийн татаасыг олгохын тулд Хас банкнаас утаагүй зуухны борлуулалтаас хамааран сайн дурын карбоны зах зээлээс орж ирэх карбон санхүү-жилтын хөрөнгийг ашиглахаар төлөвлөж байна. Энэ чиглэлээр Хас банк “Зээлийн тогтолцооны магадлан итгэмжлэлийн алтан стандарт”-ыг мөн хариуцан ажилладаг Америкийн MicroEnergy Credits компанитай хамтран ажиллаж байна.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас 2011 оны 8 дугаар сараас 2013 оны 2 дугаар сарыг хүртэл 750,000 еврогийн санхүүжилтийг Улаанбаатарын Цэвэр агаар санаачилгын II шатанд зориулан гаргажээ. Тус хөтөлбөр нь илүү цэвэр түлшний ашиглалтыг дэмжихийн сацуу, үйл ажиллагааны явц, дэг журам, хууль эрх зүйн орчин болон төсвийн үйл ажиллагааг үнэлэх, бэхжүүлэх замаар МУЗГ-ын Цэвэр агаар сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилготой юм. Хөтөлбөрийн хүрээнд агаарын чанартай холбоотой одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль журмыг судалж, шаардлагатай нэмэлт зохицуулалтыг боловсруулахад тусалсан. Түүнчлэн, цэвэр түлшний үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог үнэлэн, сайжруулахад тусалснаар хуваарилалтын тогтолцоог илүү боловсронгуй болгож, зардлыг бууруулж, олон нийтийн ойлголтыг сайжруулсан байна.

Эдгээр хөтөлбөрийн үрдүнгийн талаар зарим үл ойлголцол бий. Тухайлбал, Засгийн газрын харьяа Агаарын чанарын албанаас 2010-2011 онд шилжих жил агаар дахь нарийн ширхэгт тоосонцорын агууламж 20%-иар буурсан гэж мэдэгдсэн хэдий ч энэ нь цаг агаарын нөхцөл байдлаас илүүтэй

хамаарсан байх магадлалтай.¹⁰⁰

Хэдийгээр зарим нэг эерэг үр дүн ажиглагдаж буй ч агаарын бохирдлын хэмжээ онц аюултай хэвээр байгаа бөгөөд асуудлыг бүрэн шийдвэрлэхийн тулд агаарын бохирдлыг илүү ихээр бууруулах шаардлагатай байгаа юм. Саяхан хийгдсэн нэгэн судалгаанд Монголын агаарын чанарын стандартад заасан хэмжээнд хүрэхийн тулд хөрс, бойлуурын эх үүсвэрийн аль алиныг оруулаад гэр хорооллоос ялгаруулж буй тоосонцорын хэмжээг 94%-иар бууруулах шаардлагатай гэжээ.

Өнөөг хүртэл хэрэгжүүлж буй төслүүдийн ихэнх нь агаарын бохирдлын шинж тэмдэг гэхээс эх үүсвэрүүдэд илүүтэй анхаарч ирсэн гэхэд болно. Агаарын бохирдлын үр дагавартай тэмцэх зорилготой нэгэн жижиг хэмжээний төсөл нь Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулиас хамтран хэрэгжүүлж буй “Монголын агаарын бохирдлын төсөл” (МАБТ) юм.

МАБТ-ийн үйл ажиллагаа нь гэр хорооллын хэд хэдэн сургуулийн сурагчдыг хамруулах замаар тэдний гэр бүл, хүрээллийг өргөн хүрээнд хамруулах хэлбэрээр явагддаг. Төслийн гол зорилго нь төсөлд хамрагдагсдад агаарын бохирдол, түүний хор уршиг, урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлэл олгох замаар сэтгэлгээ, зан үйлийг өөрчлөх зорилготой аж. Сурагчдын хувьд амны хаалт зүүх нь ажил биш харин хөгжөөнт тоглоом болгох гэх мэтчилэн хэд хэдэн арга хэмжээнд оролцдог байна.

МАБТ нь, (1) Агаар дахь нарийн ширхэгт тоосонцорын бохирдлоос сэргийлэх амны хаалтын хэрэглээг гэр хороололд нэвтрүүлэх, (2) сайн дурын залуу сургагч нараар дамжуулан Агаарын бохирдлын боловсрол олгох хөтөлбөрийг ЕБС-иудад хэрэгжүүлэх, (3) Улаанбаатар хотод хэрэглэхэд тохиромжтой амны хаалтын эрэлтийг бий болгоход ашиглагдах эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл болон худалдан авагчдын мэдээлэл цуглуулах гэсэн зорилготой.¹⁰¹

4.8 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ

Энэ чиглэлээр хэрэгжсэн хамгийн чухал төсөл нь НҮБХХ-ийн Монгол Улсад Хүрээлэн буй орчны засаглалыг бэхжүүлэх төслийн I, II шат байлаа. Төслийн гол зорилго нь төв болон орон нутгийн түвшинд байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх чадавхийг үе шаттайгаар бүрдүүлэхийн сацуу хуулийн хэрэгжилтийг сайжруулах, үндсэн нөөцийн хэрэглэгчдийн оролцоог өргөжүүлэх явдал аж.

¹⁰⁰ П.Жакоб (2013). Монгол Улс: Халаалтын шинэ...

¹⁰¹ Монголын Агаарын бохирдлын төсөл (2013).

Эхний үе шат нь 2011 оны 2 дугаар сараас 2013 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хэрэгжсэн бөгөөд дараагийн шат нь дөнгөж эхлээд байна.

Тус төслийн зорилт нь: (1) Монгол Улсын хүрээлэн буй орчны хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож бэхжүүлэх; (2) хүрээлэн буй орчны хамрах цар хүрээг өргөжүүлэх; (3) ТББ, иргэний нийгмийн байгууллагуудын хүрээлэн буй орчны засаглалд үр дүнтэй оролцох чадавхыг бэхжүүлэх юм.

Энэхүү төслийн эхний шатанд Монголын хүрээлэн буй орчны олон тооны хуулиудыг судлах, Монголын хүрээлэн буй орчны менежментийг хэрэгжүүлэх тогтолцоог үнэлэх, Хүрээлэн буй орчны стратегийн үнэлгээ болон Байгаль орчны аудитын албан бүтцийг үнэлэх ажлуудыг хийсэн.

Харин төслийн II шат нь дараах зорилтуудтай:

1. Хүрээлэн буй орчны талаарх хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах төлөвлөгөө боловсруулах.
2. Хүрээлэн буй орчны хамрах цар хүрээг өргөсгөх тогтолцоог боловсруулж, Засгийн газраар батлуулах; тухайлбал, аймгуудад уур амьсгалын өөрчлөлтийн номын сан байгуулах, уул уурхайн ажиллагааны зардал, үр ашгийн шинжилгээний загварыг бий болгох.
3. Хүрээлэн буй орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, иргэний нийгмийн байгууллагуудад зориулан нөөц, санхүүжилт татан төвлөрүүлэх стратеги боловсруулах.

Хүрээлэн буй орчны засаглалын чиглэлээр НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй бас нэгэн төсөл нь Монгол Улс дахь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх төсөл юм. Уг төсөл 2010 оны 8 дугаар сараас эхэлсэн бөгөөд Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) менежментийн үр ашиг, санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах зорилготой. Түүнчлэн, тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангаж орлого ба зарлагын зөрүүг нөхөхийн тулд ТХГН-ийн удирдлага, орон нутгийн удирдлага, иргэд, ТББ, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зорилготой юм. Төслийн нийт төсөв 2.0 сая ам.доллар бөгөөд 2015 оны 6 дугаар сард дуусах аж.

Ядуурал, хүрээлэн буй орчны санаачилга (ЯХБОС) нь саяхнаас хэрэгжиж эхэлсэн төслүүдийн нэг юм. Тус хөтөлбөрийг НҮБХХ, НҮБХБОХ хамтран хэрэгжүүлдэг бөгөөд ядуурал, хүрээлэн буй орчны хамаарлыг үндэсний болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, бодлого боловсруулахаас төсөв батлах хүртэл, хэрэгжилтээс хяналт хүртэлх бүхий л шатанд тусгах тухайн улсын санаачилгад дэмжлэг үзүүлэх зорилготой аж. Төслийн зорилго нь байгалийн нөөцөөс хамааралтай ядуу иргэдэд

туслах, тэднийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гадаад орчны бусад нөлөөллөөс ангид байх чадварыг бий болгох явдал юм.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаврыг үндэсний, орон нутгийн болон салбарын хэмжээний төлөвлөлт, түүнчлэн эдийн засгийн шийдвэр гаргах явцад тусгахыг зорьж буй улс орнуудад техник, эдийн засгийн туслалцаа үзүүлдэг байна. ЯХБОС 2013 оны 6 дугаар сард эхэлж, 2017 он хүртэл үргэлжлэх бөгөөд Монгол Улс хамрагдах өндөр магадлалтай. Хөтөлбөрийн хүрээнд НҮБХХ өсөлт, ядуурал, төвлөрлийг сааруулах хүрээнд үндэсний тэргүүлэх чиглэлүүдийг боловсруулж, ядуу иргэдэд илүүтэй нөлөөлөх хүрээлэн буй орчноос үүдэлтэй өөрчлөлтүүдийг оновчтойгоор удирдах зорилго тавьж байгаа юм.

Байгалийн баялгийг зохистой ашиглах сангаас стратегийн хүрээнд Монгол дахь хүрээлэн буй орчны засаглалыг сайжруулахаар ажиллаж байна. УИХ-аас 2012 онд баталсан хүрээлэн буй орчинд учирч буй хор хөнөөлийг бууруулах талаарх хууль дахь зарим заалтууд нь Монгол Улс *Development by Design* стратегийн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч буйн илрэл болсон гэхэд болно. МУЗГ-ын хүсэлтээр тус сан хуулийн хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулах дүрэм журмын төслийг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлж байгаа аж.

4.9 ТОГТВОРТОЙ УУЛ УУРХАЙГ ДЭМЖИХ НЬ

Азийн сангаас санаачлан хэрэгжүүлж буй “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог хангах санаачилга” нь 2010 оны 8 дугаар сард эхэлсэн бөгөөд уул уурхайн ажиллагааны сөрөг нөлөөллөөс байгалийн нөөцийг хамгаалахад туслах зорилготой юм. Нидерландын Вант Улсын Элчин сайдын яам, Швейцарийн хөгжлийн агентлаг, Азийн сангаас хамтран санхүүжүүлж буй уг төсөл нь засгийн газрын харьяа агентлагууд, иргэд, ТББ-ууд, уул уурхайн компаниудтай хамтран хариуцлагатай уул уурхайн ажиллагааг хөгжүүлэх, хүрээлэн буй орчинд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, талууд хоорондын зөрчил сөргөлдөөнийг бууруулах зорилготой.

Тус хөтөлбөрийн хүрээнд 14 аймгийн 39 суманд орон нутгийн хүрээлэн буй орчны ажиглалтын баг байгуулан, байгалийн нөөцийн хариуцлагатай хэрэглээний талаарх иргэдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, байгаль хамгаалах ажиллагаанд тэдний оролцоог идэвхжүүлэх ажиллагаа явуулсны дээр 17 суманд олон талт зөвлөл байгуулах замаар зөрчил, сөргөлдөөнийг бууруулжээ. Түүнчлэн, хариуцлагатай уул уурхайн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, талуудын оролцоог

хангах талаар 16 гарын авлага хэвлүүлсэн бөгөөд байгаль орчны байцаагч, усны инженер, ЕБС-ийн багш нарыг ус, хөрсний чанарын мониторингийн сургалтад хамруулах замаар хүрээлэн буй орчны хамгаалалтад хувь нэмэр оруулсан байна.

Хөтөлбөрийн эхний шат дууссан ба хоёр дахь шат нь жижиг хэмжээний уул уурхай, гар аргаар олборлох ажиллагааны хор хөнөөлийг бууруулах чиглэлээр 2013 оны 6 дугаар сараас хэрэгжиж байна. Төслийн энэ үе шатны хүрээнд зохистой ажил эрхлэлтийн үнэлэмж, нэр хүндийг өсгөх, эрүүл, аюулгүй орчинд ажиллах эрхийг хангах замаар Монголын бичил уурхайн үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилготой. Түүнчлэн, үйл ажиллагааныхаа хүрээнд Өвөрхангай аймгийн Уянга суманд боловсруулсан жижиг хэмжээний уул уурхай, гар аргаар олборлох салбарын нөхөн сэргээлтийн жишиг технологийг нэвтрүүлэх аж.¹⁰²

Үүний зэрэгцээ Швейцарийн хөгжлийн агентлагаас өөрийн “Тогтвортой бичил уурхай” төслөөр дамжуулан бичил уурхайн салбарт дэмжлэг үзүүлж байгаа юм. Уг төсөл нь 2005 онд эхэлж, одоогоор төслийн 3 дахь шатандаа яваа бөгөөд 2014 онд дуусах төлөвлөгөөтэй байна. Төслийн 3 дахь үе шат нь 4,980,000 Швейцарь франкийн төсөвтэй аж. Уг төслийн эхний хоёр шатанд химийн бус аргаар хүдэр боловсруулах технологи нэвтрүүлэх замаар өндөр үр дүнтэй, хүрээлэн буй орчинд ээлтэй уул уурхайн орчинг бий болгох, орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлээр ажиллажээ. Мөн уг төслийн хүрээнд МУЗГ-т Бичил уурхайн тухай хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн ба 2010 оны 4 дүгээр сард тус салбарын үйл ажиллагааг хуульчилжээ. Гэхдээ бичил уурхайн хууль эрх зүйн орчинд нааштай өөрчлөлтүүд гарсан хэдий ч албажуулалтын үйл явц хэт удаашралтай байсан бөгөөд олон тооны бичил уурхай эрхлэгчдийн зохион байгуулалтад орох боломжийг хязгаарлан, ядуурал, уул уурхайн хортой нөхцөлд ажиллах “чөтгөрийн тойрог”-оос гарах боломжийг хязгаарласаар байна.

Тогтвортой бичил уурхайн төслийн санхүүжилтээр 2008 онд Төв аймгийн Борнуур суманд мөнгөн ус ашиглалгүй алт боловсруулах байгууламжийг ашиглалтад оруулсан. Тус байгууламжийг өнөөдөр ХАМО ХХК эзэмшиж буй бөгөөд 60 гаруй ажлын байраар байнга ханган, тус сумын хамгийн том ажил олгогч болоод байна. Эдгээр төслийн үр дүнд өнөөдөр Монголд бичил уурхайг зохистой ажлын байр хэмээн үзэж, хүлээн зөвшөөрөх хандлага дэлгэрч байна.¹⁰³

102 Азийн сан (2013). Монгол Улсад хэрэгжиж буй хүрээлэн буй орчны төслүүдийн баримт мэдээлэл, 2013 оны 11 дүгээр сар.

103 ШХА (2013). Тогтвортой бичил уурхайн төсөл.

4.10 ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨСЛҮҮД

Илүү тогтвортой, бүтээмж өндөртэй хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хэд хэдэн төсөл хэрэгжиж байна. Үүний нэг, Дэлхийн банкны “Монголын Хөдөө аж ахуйн маркетингийн төсөл” 2013 оны 6 дугаар сард эхэлсэн. Уг төслийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас гардан хэрэгжүүлж буй бөгөөд нийт 11.5 сая ам.долларын төсөвтэй юм. Уг төсөл нь мал аж ахуйн бүтээгдэхүүний төрөл зүйл, үйлдвэрлэл, бүтээмжийг нэмэгдүүлэх, зах зээлийг сайжруулах замаар сонгосон сумдад хөдөөгийн хүн амын амьжиргаа болон хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэх явдал юм.

Төсөл 3 хэсгээс бүрдэх ба, үүнд: (1) Мал аж ахуй, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид, фермерүүдийг зах зээлтэй холбох замаар үр ашигтай түншлэлийг бий болгох, малчин өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, (2) Мал аж ахуйн бүтээмж, чанарыг нэмэгдүүлэх. Малын эрүүл мэнд, үржил, селект, хоол тэжээлд анхаарал хандуулах, (3) Удирдлага, зохион байгуулалтад туслах зорилгоор ҮХААЯ-нд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулна.¹⁰⁴

Азийн хөгжлийн банкнаас мөн Ядуурлыг бууруулах Японы сангийн 2.5 сая ам.долларын санхүүжилт бүхий “Уур амьсгалаас үл хамаарах хөдөө орон нутгийн амьжиргааг бий болгох төслийг” хэрэгжүүлж байна. Уг төслийг 2012 оны 6 дугаар сард баталсан бөгөөд малчдад (1) зудын бэлтгэл хангах, хор хөнөөлөөс сэргийлэх, (2) амьжиргааны эх үүсвэрээ шинэчлэх, сайжруулахад нь туслах хэлбэрээр Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа аж. Уг төслийн зорилго нь бэлчээр, усны нэгдсэн менежментийг нэвтрүүлэх, хамтран хадлан тэжээл бэлдэх, үр дүнтэй маркетингийн аргаар сүргийн тоо толгойг зохицуулах явдал юм. Энэхүү төсөл 2013 оны 12 дугаар сард хаагдахаар төлөвлөгдсөн.

ШХА-аас мөн баруун аймгуудад малчдын амьжиргааг сайжруулах зорилго бүхий “Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын санаачилга”-ыг хэрэгжүүлж байна. Ингэхдээ орон нутгийн нөөц бололцоо, үйлчилгээ, ажлын үр чадварыг сайжруулах замаар илүү чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, орон нутгийн болон бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн санал санаачилгыг дэмжих, мал аж ахуйн менежмент, үйлдвэрлэлийн бүтээмж, малчдад туслах үйлчилгээг сайжруулах ажиллагаа явуулах аж.

4.11 ОЙН АЖ АХУЙН ТӨСЛҮҮД

Хоёрдугаар бүлэгт дурдсанчлан НҮБ-ын REDD+ хөтөлбөр Монгол Улсад 2011 оноос

104 Дэлхийн банк (2013). Хөдөө аж ахуйн маркетингийн төсөл

хойш үйл ажиллагаа явуулж байна. Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор юуны өмнө дотоодын холбогдох байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны болон техникийн чадавхыг бэхжүүлэх ажлыг эхлүүлээд байгаа аж.

Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгээс “Биологийн олон янз байдлыг хамгаалах, Уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүлж буй бөгөөд REDD+ хөтөлбөрт мөн дэмжлэг үзүүлж буй. Уг төсөл нь 2012-2015 онд хэрэгжих ба экологийн чухал бүсүүдийг хамгаалалтад авах, тэдгээр бүсүүдэд тогтвортой менежментийг нэвтрүүлэх замаар биологийн олон янз байдлыг хадгалж үлдэх зорилготой юм. Менежментийн арга барилыг уур амьсгалын өөрчлөлтөөс хамааран шинэчилж болохын зэрэгцээ хөдөө орон нутгийн хүн амын амьжиргааг сайжруулах аж. Туршилтын төслүүд Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад хэрэгжиж буй бөгөөд цаашид өргөжин Булган аймгийг хамруулахаар төлөвлөж байна.

Уг төсөл нь дараах 4 хэсэгтэй:

1. *Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого:* хүний хүчин зүйл, үүргийг харгалзан үзэж холбогдох арга хэмжээний санхүүжилтийг хангасны үндсэн дээр хөдөө аж ахуйн бодлого, мал сүргийн менежмент, ойн аж ахуйгаар дамжин хэрэгжинэ.
2. *Ойг гэрчилгээжүүлэх болон REDD+: REDD+* хөтөлбөрөөс боловсруулсан стандартын дагуу ойн аж ахуй, ашиглалт болон карбоны хэмжээний талаар заавар, зөвлөгөө, гэрчилгээг боловсруулах.
3. *Ойн болон байгаль орчны мэргэжилтнүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах:* ойн экосистемийн менежментийн чиглэлээр чадварлаг боловсон хүчин бэлдэх сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах.
4. *Тусгай хамгаалалттай бүс нутаг дахь бэлчээрийн тогтвортой менежмент:* Хангайн бүсийн аймгууд дахь тусгай хамгаалалттай бүс нутгуудад бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ.

МҮХАҮТ-аас мөн цөлжилтийг сааруулах, усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор Говийн бүсэд заг мод суулгах төслийг хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд 330 сая төгрөгийн санхүүжилтээр 500,000 мод суулгахыг зорьж байгаа юм.

4.12 УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН СТРАТЕГИ

Усны менежментийг сайжруулах хэд хэдэн санаачилга гарсан. Тухайлбал, НҮБХХ-өөс “Эко-системд суурилсан дасан зохицох аргаар Усны

нөөц бүрэлдэх үндсэн сав газрууд дахь усны аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг” 2013 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж буй бөгөөд 2017 онд дуусах аж. Төслийн нийт төсөв болох 10.6 сая ам.долларын 5.6 сая ам.долларыг мөнгөн хэлбэрээр харин 5 сая ам.долларыг МУЗГ-аас шаардлагатай үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр гаргаж байгаа юм. Уг төсөл нь газрын болон усны менежментийн арга барил дахь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдлүүдийг бууруулах замаар уулын болон тал хээрийн бүс дэх усны экосистемийг хадгалж үлдэхээр зорьж байна. Үүний зэрэгцээ, эмзэг байдлыг бууруулах, учирч болох саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн ажлууд мөн хийгдэх аж.¹⁰⁵

БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас (КОЙКА) Улаанбаатарын ус, дулаан хангамжийн сувгийг шинэчлэх төслийг 2007-2009 онд хэрэгжүүлсэн. Уг төсөл нь 5 сая ам.долларын төсөвтэйгээр 44 төвийг засварлах, шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн байна. 2010 онд хийсэн судалгаагаар уг төслийг хэрэгжүүлснээр ус, цахилгааны ашиглалт 20 хувиар буурсан гэсэн тооцоо гарчээ. КОЙКА төслийн дараагийн үе шат болгож 2013 оныг дуустал 5 сая ам.долларын нэмэлт санхүүжилтээр дахин 42 төвийг шинэчлэхээр зөвшөөрөөд байна.¹⁰⁶

Австралийн олон улсын хөгжлийн агентлаг, Дэлхийн банкнаас хамтран “Өмнийн говийн бүс нутгийн гүний усны менежментийн” төслийг хэрэгжүүлж байна. Дэлхийн банкны Уулзварын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэгэн хэсэг болсон уг санаачилга нь дахин сэргээгдэх боломжгүй гүний усны нөөцийн менежментийг хэрэгжүүлэх, Засгийн газрын чадавхыг бэхжүүлэх зорилготой аж. Энэ зорилгодоо хүрэхийн тулд 3 аймгийн төвд усны менежментийг хариуцсан шинэ бүтцийг турших, холбогдох яамнаас гүний усанд хяналт тавих чадавхыг бэхжүүлэх юм.

4.13 ТЭЭВРИЙН САЛБАРЫГ “НОГООРУУЛАХ” НЬ

Нийтийн тээврийн салбар “ногоорч” буйн нэгэн илрэл болж 2014 оны 1 дүгээр сард Монгол Улсад байгуулагдсан тээврийн хэрэгслийн анхны үйлдвэр нь ногоон автобусны үйлдвэр байлаа. Экобус ХХК нь Евро IV стандартад нийцсэн, J-800 дизель түлшээр ажилладаг хүрээлэн буй орчиндоо ээлтэй автобус үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд тус үйлдвэрийг Номин Холдинг ХХК-аас санхүүжүүлж байгаа аж.¹⁰⁷

¹⁰⁵ НҮБХХ(2013) Эко-системд суурилсан дасан зохицох...

¹⁰⁶ InfoMongolia (2011). Koica to reinstall the water pipeline system in Ulaanbaatar. 2011 оны 11 дүгээр сарын 3

¹⁰⁷ Дарь (2014). Mongolian first vehicle manufacturer opens, UB Post, 2014 оны 1 дүгээр сарын 16.

ДДНХХ-с БНСУ-ын Тээврийн хүрээлэн, Монголын зөвлөх үйлчилгээний компани болох DEBUNDE ХХК-тай хамтран ногоон нийтийн тээврийн судалгааг хийж байна. Ногоон өсөлтийн санаачилгаас Улаанбаатар хотод ногоон (утаа багатай) нийтийн тээврийг хөгжүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, агаарын бохирдлыг багасгахыг зорьж байна. Тус төслийн хүрээнд дизель автобусуудыг эко автобус болгон шинэчлэх техник эдийн засгийн судалгааг хийх, авто машины утаа ялгаруулалтыг хянах дүрэм журам, зохицуулалтыг сайжруулах боломжийг судлах, нийтийн тээврийг үр ашигтай менежмент, үйл ажиллагааны стратегийг боловсруулах, ирээдүйд эко буудлуудын тоо, цар хүрээг нэмэгдүүлэх ажлын судалгааг хийж байгаа аж.

Тэдний олж тогтоосноор нийтийн тээврийн маршрутыг илүү үр ашигтай болгох, автобусны хурдыг нэмэх зэрэг энгийн аргууд утааны ялгаруулалтыг огцом бууруулах юм.

4.14 БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ САНХҮҮЖИЛТ

Ногоон хөгжилд хувь нэмэр оруулах санхүүжилтийн хэд хэдэн томоохон төслүүд хэрэгжиж байна. Эдгээрийн нэгэн том жишээ нь Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар Япон улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжсэн Жайка-ийн хоёр үе шаттай зээлийн төсөл юм. Энэхүү төсөл нь анх 2006 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа дээр суурилсан жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх загвар төсөл юм.

Төслийн гол зорилго нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг шинээр бий болгох, банк, санхүүгийн байгууллагын чадавхыг сайжруулах, мөн байгаль орчныг хамгаалахад чиглэгдэж байна. Энэхүү зорилтын хүрээнд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн шалгуур, шаардлага хангасан хөрөнгө оруулалтын төслүүдийг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж улмаар тэдгээрийг санхүүгийн хувьд бэхжүүлж цаашдаа бизнесээ улам илүү хөгжүүлэх боломжийг нь бүрдүүлэх зорилготой. Мөн төсөлд оролцогч арилжааны банкуудын урт хугацааны зээлийн судалгаа хийх чадавхыг сайжруулж, бизнес эрхлэгчдийг төсөл бичих тал дээр нь зааж сургаж, зөвлөгөө өгч, тэдгээрийн санхүүгийн дэмжлэг авах боломжийг нь нэмэгдүүлэх явдал юм.

Энэхүү төслийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгосон бөгөөд зээлийн нөхцөл нь төслийн хүрээнд нэг зээлдэгчид олгох зээлийн доод хэмжээ 10,000 ам. доллар, дээд хэмжээ

600,000 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөг, эргэн төлөх хугацаа 3-10 жил, үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа 1-3 жил, жилийн хүүний (хувьсах хүүтэй) хэмжээ 7%-тай байх нөхцөлтэй. Мөн төслийн нийт өртгийн 20-иос багагүй хувийг зээлдэгч өөрийн хөрөнгөөс гаргах бөгөөд төсөл нь техник, эдийн засгийн хувьд хэрэгжих бүрэн боломжтой, эрүүл ахуй, байгаль орчны стандартад нийцсэн, 13 хувиас доошгүй хөрөнгө оруулалтын өгөөжтэй байх зэрэг бусад шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай.

Төслийн эхний шат амжилттай хэрэгжсэн, мөн зээлийн эрэлт их байгаатай уялдуулан Монголын Засгийн газраас үргэлжлүүлэх хүсэлт тавьсныг Японы тал хүлээн авсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2011 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар Японы засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл”-ийн хоёр дахь шатыг санхүүжүүлэх 5 тэрбум иен буюу 80 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн гэрээг соёрхон баталсан.

Төслийн 1-р шат 2007 оны 3-р сараас эхлэн хэрэгжсэн бөгөөд Капитрон банк, Голомт банк, Худалдаа Хөгжлийн банк, Хаан банк, Хас банк, Төрийн банкаар дамжуулан зээл олгогдсон. Нийт 25 сая ам.доллартай тэнцэх хэмжээний зээлийн эх үүсвэрийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг хот суурин газар болон 18 аймгийн 108 аж ахуйн нэгжид олгосон. Харин төслийн 2-р шат 2011 оны 6-р сараас эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд дараах арилжааны банкуудаар буюу Капитал банк, Голомт банк, Хаан банк, Хас банк, Худалдаа, хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкаар дамжуулан зээл олгогдож байна. 2013 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт 225 төслийн зээлийг санхүүжүүлсэн.

5. Хамтын ажиллагаа: НЭЗТТ-ийн зорилтуудыг биелүүлэхийн төлөө талууд хамтран ажиллах нь

НЭЗТТ-ийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, судлаачид болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо чухал юм. Төслийн үр дүнг төслийг хэрэгжүүлэх голлох яамд болох Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам болон бусад яамд, төрийн байгууллагуудын ногоон хөгжлийг дэмжсэн эрмэлзэл, урт хугацааны зорилго, зорилтууд дээр суурилсан хамтын ажиллагаагаар илэрхийлэгдэж болох юм. Түүнчлэн энэхүү төслийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагаа нь зөвхөн нэг засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжих үйл хэрэг бус илүү урт хугацааны үндэсний хөтөлбөрөөр хэрэгжвэл илүү үр өгөөжтэй байх нь дамжиггүй.

Хувийн хэвшлийн хүрээнд бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд ногоон хөгжлийг эрхэмлэх эрмэлзлийг урамшуулах, нэгдсэн стандарт, дүрэм журамтай болоход чиглэсэн арга хэмжээнүүд нь үр дүнтэй. Ингэхдээ МҮХАҮТ, Монголын бизнесийн зөвлөл, мэргэжлийн холбоод зэрэг төлөөлөх байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэх арга замууд байж болно.

Мөн түүнчлэн, олон улсын байгууллагууд болон хандивлагчид ногоон эдийн засагтай холбоотой хэд хэдэн төслүүдийг хэрэгжүүлж байна. Дэлхийн байгаль хамгаалах сан, ДДНХХ зэрэг ТББ-ууд ч мөн нэн чухал түншүүд болох юм.

Одоогийн байдлаар ногоон эдийн засгийг цогцлоон бүрдүүлэх үйл хэрэгт голлох нөлөө бүхий байгаа талуудын талаар товч мэдээлэл орууллаа.

5.1 ЗАСГИЙН ГАЗАР

Өнгөрөгч 2012 оны сонгуулиар бүрэлдсэн Шинэчлэлийн Засгийн газар нь Ардчилсан нам, Монгол ардын хувьсгалт нам, Монголын үндэсний ардчилсан нам, Иргэний зориг-Ногоон намын төлөөллөөс бүрддэг. Засгийн газар нь Ерөнхий сайд, Шадар сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга болон яамдын сайд нараас бүрдсэн нийт 19 сайдын бүрэлдэхүүнтэй.

Өмнөх Засгийн газар 11 яамтай байсан бол одоогийн буюу “Шинэчлэлийн засгийн газар” 16 яамтай болсон. Үүнд “ерөнхий чиг үүргийн” буюу Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүйн яам гэсэн 4 яамд болон чиглэлийн 12 яам орно.¹⁰⁸ Хүрээлэн буй орчны хамгаалал, ногоон эдийн засгийн хувьд голлох үүрэгтэй яам нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яам юм.

¹⁰⁸ Чиглэлийн яамд: Барилга, хот байгуулалтын яам, Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Зам тээврийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ)

нь хүрээлэн буй орчин, ногоон хөгжлийн асуудлаарх төрийн захиргааны төв байгууллага юм. Тус яам нь хүрээлэн буй орчны асуудлаар өргөн хүрээтэй чиг үүрэг хүлээх ба үүнд: байгаль, хүрээлэн буй орчны хамгаалал, байгалийн нөөцийн зохистой хэрэглээ, нөхөн сэргээлт ба экологийн бодлогууд, цөлжилт болон ойн асуудлууд, усны эх үүсвэр, биологийн олон янз байдлыг сайжруулах, хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутаг болон хүрээлэн буй орчны нөлөөллийн үнэлгээ зэрэг болно.

БОНХЯ нь нь анх 1987 онд байгуулагдсан ба 2012 оны сонгуулиас өмнө Байгаль орчны яам нэртэй байжээ. Сонгуулийн дараа тус яамыг ерөнхий чиг үүргийн яам болгож өөрчилсөн ба хөгжлийн талаарх Засгийн газрын шинэ чиглэлийг илэрхийлэхийн тулд нэрийг “ногоон хөгжлийн” болгон өргөжүүлжээ.

Тус яамны эрхэм зорилго: “Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны эрхэм зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг экосистемийн даацад тохируулан байгаль орчны тэнцлийг хангах, байгалийн баялгийг тогтвортой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх замаар ногоон хөгжлийг дэмжиж, тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлэх замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.”

БОНХЯ нь 4 үндсэн чиг үүрэгтэй:

1. Улс орны тогтвортой хөгжилд нийцсэн байгаль орчин, ногоон хөгжлийн хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулж батлуулах, түүнийг дэмжсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, салбарын санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалтаар хангах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
2. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг

бууруулах, байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг олон нийтийн оролцоо, хяналтад тулгуурлан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;

3. Тус яамны ажиллагсдыг хүрээлэн буй орчны хамгаалал, ногоон хөгжлийн чиглэлээрх шинжлэх ухааны ололт нээлт, тэргүүн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх;
4. Хүрээлэн буй орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтийн судалгаа, үнэлгээг хийх, хүрээлэн буй орчны хамгаалал, экологийн тэнцвэрт байдлыг хангахад шинжлэх ухааны ололт дэвшил, ногоон технологийг нэвтрүүлэх.

Тус яам нь 9 газар, 6 хэлтсээс бүрддэг.

Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ) нь 2012 онд шинээр байгуулагдсан. Тус яамны үндсэн чиг үүрэг нь засгийн газрын эдийн засгийн бодлогыг тодорхойлох, боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах явдал юм. Тус яам нь, хөрөнгө оруулалтын бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн нэгдсэн бодлого, зээл тусламж, худалдааны бодлого, дэвшилт технологи болон үндэсний инновацийн тогтолцоо зэргийг хариуцдаг байна.

Түүнчлэн ЭЗХЯ нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудын зээл, тусламжийг хуваарилах эрхтэй.

Тус яамны бүрэлдэхүүнд байдаг *Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар* нь Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, орчныг сайжруулах үүрэгтэй юм. Гол чиг үүргүүдээс дурдвал:

- Монгол Улсыг хөрөнгө оруулалт хийхэд таатай газар хэмээн сурталчлах;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Хөдөлмөр, татвар, гааль, нийгмийн даатгал, гадаадын иргэдийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудаас статистик мэдээлэл цуглуулах,
- Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, төлөөлөгчийн газрыг бүртгэх,
- Гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой бодлого, зохицуулалтыг үнэлэх;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, хэтийн төлөв байдлын таамаг гаргах.

Уул уурхайн яам (УУЯ) нь геологи, ашигт малтмал, газрын тос, түлш шатахууны нийлүүлэлт болон нөөц, ил тод, хариуцлагатай уул уурхайн бодлого, зохицуулалтыг хариуцдаг.

Ашигт малтмалын газар нь (АМГ) тус яамны

бүрэлдэхүүн дэх зохицуулагч агентлаг юм. Тус агентлагийн зорилго нь ашигт малтмалын салбарт баримтлах төрийн бодлогыг боловсруулахад туслах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчид, бусад сонирхсон этгээдэд түргэн шуурхай, найдвартай үйлчилгээ үзүүлэх явдал юм. Агентлагийн стратегийн зорилтууд нь:

- Эрдэс баялгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад геологийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бүх талын таатай орчныг бүрдүүлэх.
- Ашигт малтмалын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх.
- Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах.

Газрын тосны газар нь мөн тус яамны харъяа агентлаг бөгөөд шатахууны импорт, үнийн асуудлыг хариуцдаг.

Эрчим хүчний яам (ЭХЯ) нь эрчим хүчний талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого болон сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх үүрэгтэй.

Тус яамны бүрэлдэхүүнд байдаг *Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв нь (СЭХҮТ)* Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг дагалдуулан 2007 онд Засгийн газраас баталсан Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрийг хариуцдаг гол нэгж юм. СЭХҮТ нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, ашиглалтын судалгаа хийдэг төрийн өмчит үйлдвэрийн газар бөгөөд 49 орчим ажилтантай.

Тус төвийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Тогтвортой хөгжлийн зарчмуудыг Монгол Улсад нэвтрүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрт заасан зорилтуудыг хангах;
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, ашиглалтын дэлгэрэнгүй судалгааг гүйцэтгэх;
- Сэргээгдэх эрчим хүчний техник технологийг судалж Монгол орны нөхцөлд туршиж нэвтрүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүчний шинэ технологийг Монгол Улсад нэвтрүүлэх;
- Орон даяар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, судалгаа хийх болон үндэсний чадавхыг бэхжүүлэх зэрэг болно.

Тус төв нь Судалгаа, төсөл хөтөлбөрийн хэлтэс болон Үйлдвэрлэл, технологийн хэлтэс гэсэн 2 үндсэн нэгжтэй. Судалгаа, бизнесийн хөгжлийн хэлтэс нь сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, туршилт, хэрэглээний чиглэлээр судалгаа хийдэг. Үүнд нарны, салхины, газрын гүний дулааны,

эрчим хүчний бусад шинэ эх үүсвэрүүд болон үйлдвэрлэлийн цэвэр механизмууд багтана. Харин Үйлдвэрлэл, технологийн хэлтэс нь нарын эрчим хүчний үүсгүүрийн үйлдвэртэй бөгөөд, мөн техникийн зураг төсөл, хяналтын бүлгүүдтэй байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам (ҮХААЯ) нь хүнд болон хөнгөн үйлдвэрийн бодлого, аж үйлдвэрийн парк, хүн амын хүнсний хангамж, малаж ахуй, хөдөө аж ахуйн, мал, ан амьтан, ургамлын хорио цээр, малын болон ургамлын гаралтай бүтээгдэхүүний экспорт, импортыг хариуцдаг байна.

Хөдөлмөрийн яам (ХЯ) нь хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, амьжиргааны зардлын асуудлууд, Монгол дахь гадаад ажилчдын асуудал болон ажиллах хүчний экспортоор холбоотой асуудлыг хариуцдаг. Тус яам нь Ногоон ажлын байрны стратегийг боловсруулахад гол түнш байх юм.

ХЯ нь дараах 6 нэгжээс бүрддэг: Мэргэжлийн сургалт, Хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн харилцаа, ЖДҮ, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, Төрийн захиргааны удирдлага.

Түүнчлэн ХЯ-ны харьяанд дараах агентлагууд ажилладаг байна. Үүнд: Хөдөлмөрийн төв бирж; нийгмийн даатгалын бодлогыг хариуцсан Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, ЖДҮ-ийн сан, Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв, Хөдөлмөрийн судалгааны хүрээлэн зэрэг болно.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (ХАХНХЯ) нь хүн амын хөгжил, төлөвлөлтийн асуудлууд, хүүхэд, залуус, эмэгтэйчүүд болон өндөр настны хөгжлийн асуудлууд, түүнчлэн хүйсийн асуудал, нийгмийн халамж болон нийгмийн даатгалтай холбоотой асуудлуудыг хариуцдаг.

Эрүүл мэндийн яам (ЭМЯ) нь хүн амын эрүүлийг хамгаалах асуудлыг хариуцдаг.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд дээр дурдагдсан яамдыг төслийн хүрээнд голлон хамтран ажиллах яамд хэмээн тодорхойлсон. Үүний зэрэгцээ, дараах байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийсэн бөгөөд эдгээр нь ногоон хөгжилд нөлөөлөхүйц зарим үйл ажиллагаанууд явуулдаг байна.

- **Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)** 200 гаруй хууль тогтоомж, 400 гаруй дүрэм журмын хэрэгжилтийг хангах үүрэгтэй байгууллага юм. Хүрээлэн буй орчны бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тус газар эхний эгнээнд явдаг болно.
- **Үндэсний хөгжлийн хүрээлэн (ҮХХ)** нь Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх ухааны академийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг төрийн эрдэм шинжилгээний байгууллага юм. Судалгааны үндсэн 3 чиглэлтэй бөгөөд

үүнд: эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин багтдаг. Сүүлийн 3 жилийн турш тус хүрээлэн уур амьсгалын өөрчлөлтөд, түүнд дасан зохицох эмзэг байдлын үнэлгээг хийж ирсэн. Тэдгээр судалгаа нь голчлон Баянхонгор аймгийн бэлчээрийн газар нутагтай холбоотой нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг судлахад чиглэсэн байна. Харин дараагийн судалгаа нь ногоон хөгжлийн асуудалд голлон анхаарах аж. Энэхүү судалгаандаа 6 аймгийг хамруулахаар сонгоод байгаа бөгөөд аймгуудын газар нутгийн эмзэг байдалд тулгуурлан төсвийн тооцоог хийх замаар эмзэг байдлын үнэлгээ гаргах юм.

Түүнчлэн Стратеги, судалгааны хүрээлэн зэрэг төрийн байгууллагууд байдаг.

Монголын ногоон хөгжлийг дэмжихэд УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны үүрэг оролцоо

Монгол Улсын Их Хурал нийт 7 байнгын хороотой. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо нь тэдний нэг бөгөөд 17-21 гишүүнтэй.

Тус байнгын хорооны чиг үүрэг өргөн хүрээтэй бөгөөд Монгол Улсын хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогыг тэр чигээр нь хамардаг. Тийм ч учир хүрээлэн буй орчны асуудлаар хууль санаачлагчдаас өргөн барьсан УИХ-ын тогтоолын төсөл, хуулийн төслийг хэлэлцүүлэх, санал дүгнэлт гаргах замаар хүрээлэн буй орчны хамгааллын хууль тогтоомж, үйл ажиллагааны зохион байгуулалтад чухал нөлөө үзүүлэх боломжтой юм. Түүнчлэн байнгын хороо нь төрийн бодлого, парламентын санал санаачилгыг засаж сайжруулах санал гаргах болон өөрийн эрх хэмжээний хүрээнд парламентын хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй байдаг.

Ийм өргөн цар хүрээний чиг үүрэг, байр суурь бүхий тус байнгын хороо нь хүрээлэн буй орчны хамгааллыг сайжруулах, Монгол Улсад ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

5.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ БОЛОН АЖИЛ ОЛГОГЧДЫН ХОЛБООД

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ) нь хараат бус ТББ бөгөөд ажил олгогчдын эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийг дэмждэг байна. МАОЭНХ нь анх 1990 онд үүсгэн байгуулагдаж байсан бөгөөд өнөөдөр 21 аймаг, 60 суманд салбартай, 41 мэргэжлийн холбоод, салбарын 12 холбоодыг хамарсан үйлдвэрлэл, барилга, банк санхүү, даатгал, үйлчилгээний салбарын нийт 8100 орчим аж ахуйн нэгжийн эрх ашгийг төлөөлсөн үндэсний хэмжээний байгууллага болтлоо өргөжжээ. Тус холбоо нь

МУЗГ, ҮЭХ нартай хамтран ажиллахын зэрэгцээ Олон улсын ажил олгогч эздийн байгууллагын гишүүн юм.

Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо (МУЭХ) нь анх 1927 онд байгуулагдсан үндэсний худалдааны холбоо юм. Тус холбоо нь 1991-оныг хүртэл ЗХУ-д төвтэй Дэлхийн худалдааны эвлэлүүдийн холбооны гишүүн байсан хэдий ч дараа нь Олон улсын худалдааны эвлэлүүдийн холбоонд нэгдэн оржээ.

5.3 ХУВИЙН ХЭВШИЛ

Судалгааны ажлын явцад ногоон хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь олонд танигдсан хэд хэдэн хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөлтэй уулзсан болно.

Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрлэлийн танхим (МУХАҮТ) нь анх 1960 онд байгуулагдсан бөгөөд олон улсын худалдаа, Монголын хувийн хэвшил дэх хөрөнгө оруулалтыг дэмжиж ажилладаг.

Өнөөдөр тус танхим нь бүх аймгуудад 23 салбар нэгжтэй, 2,700 гаруй гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. МУХАҮТ нь 40 гаруй орны худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажиллан байгаагийн зэрэгцээ Монгол Улсын Арбитрын төвийг ажиллуулдаг байна.

Тус танхим нь Засгийн газар, нийслэл болон орон нутгийн удирдлагуудтай ойр дотно хамтран ажилладаг юм.

МУХАҮТ 2010 онд дэргэдээ **Усны бодлогын зөвлөлийг** байгуулсан. Тус зөвлөлийн зорилго нь: Монгол Улсын гол мөрөн, нуурыг хамгаалах, Монгол Улсын усны тухай хууль эрх зүйн орчныг сайжруулах, Монгол Улсад Усны үнэлэмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, усны талаарх олон нийтийн сэтгэлгээг өөрчлөх, төлөвшүүлэх, усны салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, ус хэмнэх, ахуйн болон үйлдвэрийн бохир усыг цэвэршүүлэх тэргүүний технологийг нэвтрүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх зэрэг болно.

Түүнчлэн 2009 онд Монгол Улсын эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, тогтвортой, эрүүл, үр ашигтай салбар болгохын тулд санаа солилцох, шинийг санаачлах зорилгоор **Эрчим хүчний тогтвортой хөгжлийн зөвлөлийг** байгуулсан. Тус зөвлөлийн үйл ажиллагаа нь: Эрчим хүчний үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих, салбарын өмнө тулгамдаж буй асуудлаар гишүүдийн дунд хэлэлцүүлэг хийж холбогдох арга хэмжээ авах, эрчим хүчний шинэ техник технологи судлаж үйлдвэрлэл ахуйд нэвтрүүлэх, салбарын бодлого боловсруулагчдад зөвлөмж санал дэвшүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн талаар заавар зөвлөмж

гаргаж иргэд болон аж ахуйн нэгжүүдэд түгээх, сэргээгдэх эрчим хүчний судалгаа хийж мэдээлэх зэрэг болно.

Монголын бизнесийн зөвлөл (МБЗ) нь мөн бизнес эрхлэгчдийн томоохон төлөөллийн байгууллага юм. Энэхүү зөвлөлд “Байгаль орны ажлын хэсэг” бий.

Ньюком Групп ХХК нь Монголын цахилгаан холбоо, агаарын тээвэр, сэргээгдэх эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллагын томоохон төлөөлөл юм. Монголын анхны гар утсыг тус группын үүсгэн байгуулсан үүрэн холбооны тэргүүлэгч компани болох Мобиком групп анх 1996 онд нэвтрүүлж байсан. Түүнчлэн, Ньюком 2006 онд Изинис Эйрвэйз агаарын тээврийн компанийг үүсгэн байгуулсан ба 2013 оны 6 дугаар сард ашиглалтад орсон Монголын хамгийн анхны салхин станцыг гардан байгуулжээ. Олон улсын Other Ways байгууллагаас тус группыг “Дэлхийн ногоон өргөмжлөл 2014” шагнахаар мэдэгдээд байгаа билээ.

Банк, санхүүгийн байгууллагууд

Монгол Улсын бизнесийн салбарт санхүүжилтийн дийлэнх хэсгийг арилжааны банкууд, тэдгээрээр дамжсан бизнесийн зээлийн бүтээгдэхүүнүүд эзэлдэг. Өнөөдрийн байдлаар нийт 13 арилжааны банк үйл ажиллагаа явуулж буй. Судалгааны баг банкуудын төлөөлөл болгон Монголын банкны холбоо, Голомт болон Хас банкны төлөөлөлтэй уулзсан. Тухайлбал Хас банкны зүгээс Улаанбаатар цэвэр агаар төсөл, Эко өрхийн зээл, Эко жижиг дунд бизнесийн зээл, Хүлэмжийн хийг бууруулах зорилгоор олгох орон сууц, хашаа байшин худалдан авах зээл гэсэн бүтээгдэхүүн, төслүүд хэрэгжиж байна.

Хас банк нь нийслэл хот болон 21 аймгийг хамран үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 500 гаруй мянган харилцагчдад 98 салбар нэгжээрээ дамжуулан үйлчилгээ үзүүлдэг аж. Түүнчлэн банкны тусгай үйлчилгээ үзүүлэгч нэгжүүдтэй бөгөөд үүнд АМАР үүрэн банкны үйлчилгээний 400 цэг, хадгаламж зээлийн 70 хоршоо багтана. Хас банк нь Монголын хамгийн том бичил зээл олгогч бөгөөд 21,000 гаруй харилцагчтай.

Жишээ болгон авсан Голомт банкны төлөөлөлтэй мөн уулзсан бөгөөд энэ банкны зүгээс мөн ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулж байна.

6.4 ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГУУД

Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын хамтын ажиллагааны буюу тусламжийн байгууллагууд, төслийн талаар тоймловол:

Монгол Улс 1991 оны 2 дугаар сард *Дэлхийн банк* группэд гишүүнээр элссэн. Өнөөдрийг хүртэл Дэлхийн банкнаас Монгол Улсад нийт 578.7 сая ам.долларын зээл тусламж, санхүүжилт олгожээ. Үүний зэрэгцээ Монгол Улс нэмэлт 101.3 сая ам.долларын тусламжийг олон улсын сангуудаас авчээ.

2012 оны 11 дүгээр сарын байдлаар Дэлхийн банкны дэмжлэгээр хэрэгжиж буй нийт 211.1 сая ам.долларын төсөв бүхий 13 хөрөнгө оруулалтын болон техникийн тусламжийн төслүүд болоод нийт 67.4 сая ам.долларын хандивлагчдын санхүүжилт бүхий 41 идэвхтэй хөрөнгө оруулалт байна. Эдгээр төслүүдийн дийлэнх нь дэд бүтцийн хөгжил, эдийн засгийн засаглалыг сайжруулах, уул уурхайн салбар дахь төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд чиглэж байв.

Зээл, тусламжаас гадна Дэлхийн банк нь Монгол Улсыг дунд болон урт хугацааны хөгжлийн зорилтуудаа хэрэгжүүлэх, стратегийн гол чиглэлүүдэд засгийн газрын шинэчлэлийн бодлогыг чиглүүлэхэд шаардлагатай чадавхыг бий болгож, бэхжүүлэх асуудлаар дүн шинжилгээ хийж зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байна.

Дэлхийн Банкны группын зүгээс Монгол Улстай түншлэх стратегийг Үндэсний хөгжлийн цогц бодлогод нийцүүлэн боловсруулсан. Энэхүү түншлэлийн стратегид Дэлхийн Банкны группын зүгээс ирэх 5 жилд дэмжлэг үзүүлэх 3 үндсэн чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

1. Уул уурхайн эдийн засгийг тогтвортой, ил тодоор удирдах талаар Монгол улсын чадавхыг бэхжүүлэх.
2. Хот болон хөдөөд эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой, олон тулгуурт суурь бий болгох.
3. Үйлчилгээний (хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг илүү сайн хүргэх, нийгмийн хамгааллын системийг сайжруулах, гамшгийн эрсдлийн удирдлагыг боловсронгуй болгох замаар эмзэг байдал, өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлын асуудлыг шийдвэрлэх.

Дэлхийн банкны харьяа *Олон улсын санхүүгийн корпораци нь (ОУСК)* Монголын нийт хувийн хэвшилд, тэр дундаа өргөн хэрэглээний бараа, үйлчилгээ, тээвэр ложистик, санхүүгийн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө, барилгын материалын үйлдвэрлэлд зээлийн санхүүжилт олгодог. ОУСК нь ирээдүйтэй аж ахуйн нэгжүүдэд шууд хөрөнгө оруулалт хийх замаар ажлын байр бий болгох,

иргэдийн орлогыг нэмэгдүүлж, улмаар Монголын аж үйлдвэрийн салбарын хөгжилд дэмжлэг үзүүлдэг байна. Ногоон эдийн засгийн хүрээнд ОУСК-ас тээвэр, цэвэр болон сэргээгдэх эрчим хүч, цементийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулдаг аж. Эдгээр төслүүд нь иргэдийн амьжиргааг сайжруулж, ажлын байр бий болгохын зэрэгцээ хөрөнгө оруулагчдын хувьд ашигтай байдаг юм.

Азийн хөгжлийн банк (АХБ) нь МУЗГ-ын албан ёсны хөгжлийн туслалцааны хамгийн том эх үүсвэрүүдийн нэг байсаар ирсэн. Монгол Улс 1991-2011 оны хооронд 45 төслийн хэрэгжилтэд зориулж нийт 825.5 сая ам.долларын тусламжийг тус банкнаас авчээ. Түүнээс гадна Монгол Улс 2007 онд Азийн хөгжлийн сангаас санхүүжилт авах эрхтэй болсноор нэмэлт 172.2 сая ам.долларын санхүүжилтийг мөн авсан байна.

Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн дагуу 2012-2016 онд АХБ-наас МУЗГ-аас хэрэгжүүлж буй хүртээмжтэй, тогтвортой өсөлтийн төлөөх үйл ажиллагаанд туслах юм. АХБ эн тэргүүнд дэд бүтцийн хомсдолыг (нэн ялангуяа зам харилцаа холбоог хангахад шаардагдах) шийдвэрлэж, бүсийн эдийн засгийн интеграцчлалыг хангаж, хотын нийтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. Хоёрдугаарт, энэхүү стратеги нь нийгмийн хөгжилд онцгой анхаарч, нэн ялангуяа мэргэжил, ур чадвар хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлттэй нийцэхгүй байгааг шийдвэрлэх зорилгоор боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээг үр ашигтай хүргэх зорилготой. Энэхүү стратегийн үндэс суурь нь чадавхыг бэхжүүлэх, бодлогын шинэтгэл хийх, төр ба хувийн хэвшлийн түншлэлийн таатай орчинг бий болгох явдал юм.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) болон НҮБ-ын бусад байгууллагууд нь Монгол Улстай 10 гаруй жил амжилттай хамтран ажилласны эцэст 1973 онд Улаанбаатарт Суурин төлөөлөгчийн газраа байгуулсан. Түүнээс хойш НҮБХХ нь Монголын ард түмэнд тэгш эрхтэй, тогтвортой хөгжлийн үндэс суурийг бүрдүүлэхэд туслах үйл ажиллагаа явуулж ирсэн. НҮБХХ нь Монгол Улсын Засгийн газар, ард иргэдэд Мянганы хөгжлийн үндэсний 9 зорилтууд болон хөгжлийн бусад тэргүүлэх чиглэлүүддээ хүрэхэд дэмжлэг үзүүлэх эрмэлзэлтэй юм. НҮБХХ-ийн зорилго нь Монголын ард түмний, тэр тусмаа ядуу, эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг сайжруулах, эрх тэгш байдал, нэр төр, боломжийг бүгдэд олгосон ирээдүйн төлөө ажиллах явдал юм. Монголд НҮБХХ-өөс анхаарч ажиллаж буй 3 чиглэл нь:

- Ядуурлыг бууруулах

- Ардчилсан засаглалыг бэхжүүлэх
- Хүрээлэн буй орчин ба эрчим хүч.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) нь Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2008-2012 оны хооронд 732 сая евро, 2.3 тэрбум еврогийн үнэлгээ бүхий 55 төслийг хэрэгжүүлжээ. Тэдгээр бүх төслүүд нь хувийн хэвшилд чиглэсэн байсан бөгөөд голлон санхүү, хөрөнгийн байгууллагууд, жижиглэн худалдаа, уух бүтээгдэхүүний үйлдвэрлэл, уул уурхайн салбарт төвлөрсөн байв. ЕСБХБ-наас Монголын анхны сэргээгдэх эрчим хүчний төсөл хийгээд хувийн эзэмшлийн үүсгүүр болох Салхитын салхин станцын бүтээн байгуулалтад хөрөнгө оруулжээ.

Тус банк нь үйл ажиллагаагаа МУЗГ-ын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэхийн зэрэгцээ олон улсын санхүүгийн бусад байгууллагууд болон Европын холбоо зэрэг хоёр болон олон талт хамтын ажиллагааны байгууллагуудтай ойр дотно хамтран ажиллах юм. Тус банкнаас баримталж буй стратеги дахь гол сорилтууд болон стратегийн чиглэлүүдийг дурдвал:

- Эрдэс баялгийн бус салбаруудыг дэмжих замаар эдийн засгийн төрөлжилтийг сайжруулах;
- Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тогтвортой өсөлтийг хангах;
- Хариуцлагатай уул уурхайг дэмжих, төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх;
- Дэд бүтцийг шинэчилж, хувийн хэвшлийн оролцоог хангах.¹⁰⁹

Даян дэлхийн ногоон хөгжлийн хүрээлэн (ДДНХХ) мөн Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. БОНХЯ болон Олон улсын ногоон өсөлтийн хүрээлэн (ОУНӨХ) 2011 оны 11 дүгээр сард ногоон өсөлтийг хангах асуудлаар Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Үүний дараа 2013 оны 6 дугаар сарын 3-нд Монгол Улс “Олон улсын ногоон өсөлтийн хүрээлэн байгуулах тухай гэрээ”-нд нэгдсэнээр тус хүрээлэнгийн 19 дэх гишүүн улс болжээ. ОУНӨХ нь МУЗГ-т дээрээс доош чиглэсэн стратегийн чиг хандлага бүхий үндэсний ногоон хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд туслахын зэрэгцээ Монголын хэрэгцээ шаардлагад тусгайлан нийцсэн, доороос дээш чиглэсэн стратегийн хандлага бүхий салбар тус бүрийн ногоон өсөлтийн стратегийг хэрэгжүүлэхэд туслах зорилготой юм. Тус санаачилгад Монгол Улсыг БОНХ-ийн Сайд С.Оюун төлөөлдөг байна.

Гуравдугаар бүлэгт дурдсанчлан 2012 оноос хойш ОУНӨХ Монгол Улсын Ногоон эдийн засгийн хөгжилтэй холбоотой судалгааны 2 төсөл гүйцэтгэсэн: Монгол Улсад Ногоон нийтийн

тээврийг хөгжүүлэх стратеги, Монгол Улсад Ногоон эрчим хүчний тогтолцоог хөгжүүлэх стратеги. ОУНӨХ-ээс мөн уул уурхай, барилга, хөдөө аж ахуйн салбарт ногоон санаачилгуудыг нэвтрүүлэх талаар судалгаа хийхээр зорьж байгаа аж. Монгол Улсад НЭЗТТ-ийг хамтран хэрэгжүүлэх нэгэн чухал түнш нь ОУНӨХ байх болно.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН) нь Монгол Улсад 1991 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 1998 онд Улаанбаатарт төлөөлөгчийн газраа байгуулжээ. Тэдний зорилго нь эдийн засгийн орчинг сайжруулах замаар ядуурлыг бууруулах юм. ГОУХАН нь бодлогын 4 үндсэн чиглэлд нийт 7 хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд тэд бүгд НЭЗТТ-ийн зорилтуудтай шууд болон шууд бус байдлаар холбогдож байна. Тэдгээрийг жагсаавал:

- Тогтвортой дэд бүтэц: Өндөр хүчдэлийн сүлжээнд суурилсан цахилгаан хангамжийн ашигт байдал, болон нийгмийн хөгжил
- Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны шинэчлэл: Хүрээлэн буй орчин болон уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал болон гол ойн сав газрын экосистемийн уур амьсгалын өөрчлөлт, хотжилтод дасан зохицож буй байдал
- Эдийн засгийн хөгжил болон хөдөлмөр эрхлэлт: эдийн засгийн тогтвортой хөгжлийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, Эрдэс баялгийн иж бүрэн санаачилга, Бүс нутгийн эдийн засгийн хөгжил

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА) нь Америкийн хоёр талын туслалцааг Монголд хүргэж буй хамгийн том байгууллага юм. Тус хөтөлбөр нь 2 үндсэн чиглэлийг баримталдаг:

- Хүртээмжтэй өсөлтийн боломжуудыг нэмэгдүүлэх;
- Илүү үр ашигтай, хариуцлагатай засаглалыг бий болгох.

АНУ-ын ОУХА-аас 1991-2010 хүртэл олгосон тусламжийн нийт хэмжээ 200 сая ам.долларыг хол давжээ. Уг хөтөлбөрийг Улаанбаатар дахь АНУ-ын Элчин сайдын яам дээр байрлах 9 хүний бүрэлдэхүүнтэй Суурин төлөөлөгчийн газар удирдан зохион байгуулдаг. Тодорхой төслүүдийг Монголын төр, хувийн хэвшил дэх гэрээт болон санхүүжилт авсан байгууллагуудын сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлдэг байна.

АНУ-ын тусламжийг Монголд хэрэгжүүлсэн бас нэгэн байгууллага нь Мянганы сорилтын сан (МСС) юм. Монголын МСС 2007 оны 10 дугаар сард хоёр орны Засгийн газар гэрээнд харилцан гарын үсэг зурснаар байгуулагджээ. МСС нь 5 жилийн туршид нийт 285 сая ам.долларыг эдийн засгийн өсөлтөөр дамжуулан ядуурлыг бууруулахад зориулсан аж.

¹⁰⁹ <http://www.ebrd.com/downloads/country/strategy/mongolia.pdf>

Уг хөтөлбөр нь нийгмийн 6 салбарыг хамарсан: хөрөнгийн эрх, хот орчмын бэлчээр, мэргэжлийн сургалт боловсрол, эрүүл мэнд, авто зам, эрчим хүчний ашигт байдал зэрэг орно.

Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА) нь 2002 оноос эхлэн хүмүүнлэгийн тусламжаар дамжуулан Монгол Улсад дэмжлэг үзүүлж иржээ. Өнөөдөр ШХА-ийн хөтөлбөрийн зорилго нь удаан хугацааны хөгжлийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхүү чиглэх болсон. Хамтын ажиллагааны стратегийн дагуу бол 2007-2012 онд тус агентлаг дараах үндсэн чиглэлээр тусламж үзүүлнэ гэжээ. Үүнд:

1. Малчдын болон үндэсний түвшинд байгалийн нөөцийн менежмент, мониторингийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин, чадавхыг сайжруулах;
2. Малчдыг МАА-н уламжлалт эрсдлүүдээс урьдчилан сэргийлж, гамшгийн бэлэн байдал, хүрээлэн буй орчны хамгааллыг сайжруулах;
3. Малчдын орлогын эх үүсвэрийн төрлийг нэмэгдүүлж, малын үржил шимийг сайжруулах замаар зорилтот салбарууд дахь орлогыг нэмэгдүүлэх;
4. Монгол-Швейцарийн харилцааг бэхжүүлэх;

Эдгээр тусламжийн зонхилох хэсэг нь Монголын баруун бүсийн аймгуудад хэрэгждэг. ШХА-ийн төсөл хөтөлбөрүүд нийт 10 орчим жил үргэлжилж, жилд 5-10 сая Швейцарь франкийн төсөвтэй байхаар төлөвлөж байгаа юм. Швейцарийн Монголд үзүүлэх тусламжийн нийт хэмжээ нь ирэх 5 жилийн туршид 40 сая Швейцарь франктай тэнцэх аж.

Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА) нь 1990 оноос эхлэн Монголд үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд Төлөөлөгчийн газар нь 1997 онд байгуулагдсан. ЖАЙКА Монголд дараах үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг:

- Уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, Засгийн газрын чадавхыг бэхжүүлэх: Ашигт малтмалын салбарын тогтвортой хөгжил, төрөөс ашигт малтмалын орлогыг зохистой захиран зарцуулах болон макро эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх
- Хүртээмжтэй өсөлтийг хангах нь: ажлын байрны хангамжийг өсгөж, салбарын төрлийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулах
- Улаанбаатар хотын төв суурин газрын чадавхыг сайжруулах
- Дэд бүтэц, хот төлөвлөлт, менежментийг сайжруулах

Тус байгууллагын зүгээс ЖДҮ-г хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах "Хоёр үе шаттай зээлийн төсөл"-ийг хэрэгжүүлж буйг тэмдэглүүштэй.

БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА) нь мөн Монголд хөгжлийн тусламж үзүүлдэг бөгөөд хэрэгжүүлж буй төслүүдийнх нь нэг нь усны дэд бүтцийг хөгжүүлэх төсөл юм. Гэхдээ тус агентлагийн түншлэлийн стратеги болон зорилтууд нь олон улсын тусламжийн бусад байгууллагуудтай харьцуулахад тодорхой бус байна.

Австралийн Олон улсын хөгжлийн агентлаг (АОУХА) нь мөн Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Тус агентлагийн гол зорилго нь сайн засаглалтай, эдийн засгийн хувьд бэхэжсэн, эрх тэгш нийгэм бүхий Монгол Улсыг бий болгоход дэмжлэг үзүүлэх явдал юм.

АОУХА-ийн үйл ажиллагаа нь дараах үндсэн чиглэлүүдтэй. Үүнд:

1. Хүний нөөцийн хөгжил: Австралийн тэтгэлэгт хөтөлбөрөөр дамжуулан Монгол Улсын төр, хувийн хэвшлийн тэргүүлэх чиглэлийн салбаруудын хүний нөөцийг хөгжүүлэх
2. Хөгжлийн төлөөх уул уурхай: Уул уурхайн салбарын засаглалыг сайжруулж, уул уурхайгаас олсон орлогыг хүртээмжтэй, эрх тэгш байдлаар зарцуулах боломжийг хангах, уул уурхайн ажиллагааны нийгэм, хүрээлэн буй орчны нөлөөг үр дүнтэй удирдах
3. Эмзэг бүлгийг дэмжих: хөдөө орон нутгийн эмзэг бүлгийн хүүхдүүдийн ус, эрүүл ахуйн байгууламжийг сайжруулах замаар багш сурагчид, цаашилбал иргэдийн дундах өвчлөлийг бууруулах.

Өнгөрөгч 3 жилийн хугацаанд Австралиас үзүүлсэн тусламжийн хэмжээ 29.6 сая доллартай тэнцэж байгаа бөгөөд 2012-2013 онд 14.6 сая долларын хөгжлийн тусламжийг үзүүлэхээр төлөвлөж байна.

2012-2013 онд АОУХА-аас хэрэгжүүлэх ажлууд гэвэл:

- Хүний нөөцийн хангамжийг сайжруулах зорилгын хүрээнд Монголын 38 оюутныг Магистрын түвшний тэтгэлэгт сургалтад хамруулах
- НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран баруун умард бүсийн аймгуудын эмзэг бүлгийн 7,800 гаруй хүүхдүүдийн цэвэр ус, эрүүл ахуйн байгууламжийг сайжруулах замаар эрүүл мэндэд хувь нэмэр оруулж, сургуульд хамрагдах түвшинг нэмэгдүүлэх
- Уул уурхайн гол бүс нутаг болон олон малчдын төрөлх нутаг болсон өмнийн Говийн бүс нутгийн орон нутгийн удирдлагын гүний усны нөөцийг үр дүнтэй удирдах чадавхыг бэхжүүлэх
- Эдийн засгийн өсөлтийг бий болгохын тулд тогтвортой уул уурхайг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулах.

5.5 ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД

Байгаль орчны үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудолноор байдаг бөгөөдэдгээрийн төлөөлөл болгон дараах байгууллагуудтай уулзав. Эдгээр нь дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа нь танигдсан томоохон байгууллагууд юм.

Байгаль хамгаалах олон улсын байгууллага (Nature Conservancy) анх 1951 онд байгуулагдсан бөгөөд дэлхий даяар экологийн чухал ач холбогдолтой газар нутаг, гол усыг хамгаалах чиглэлээр ажилладаг дэлхийн хамгийн том байгууллагуудын нэг болж хөгжжээ. Тус байгууллага нь 1 сая гаруй гишүүнтэй бөгөөд Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) мөн Монголд идэвхтэй ажиллагаа явуулдаг. Үйл ажиллагааны цар хүрээ нь: байгалийн тусгай нөөцийг хамгаалах үйл ажиллагаа, цэвэр усны экосистемийг хамгаалах, тогтвортой хөгжлийн боловсрол олгох, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, хариуцлагатай уул уурхай.



6. НЭЗТТ-ийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд

Судалгааны явцад Монгол Улс ногоон хөгжлийн урт хугацааны стратегийн бодлогын баримт бичигтэй байх нь зүйтэй болох нь харагдаж байна. Ялангуяа эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны асуудал хүндрэлүүд олноор нүүрлээд буй өнөө үед тогтвортой хөгжлийн бодлого нь эдгээр бэрхшээлийг даван гарч, ирээдүйд учирч болох сөрөг нөлөөллийг бууруулах хамгийн зөв шийдлүүд байж болох юм.

Төр, хувийн хэвшил, ТББ-ууд болон олон улсын байгууллагуудаас Ногоон эдийн засгийг хөгжүүлэх олон төсөл хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж буй боловч тэднийг дэмжин чиглүүлэх нэгдсэн бодлого, зохицуулалт үгүйлэгдэж байна. Энэ нь батлуулахаар зорьж буй ногоон хөгжлийн стратеги өгүүлэгдэж буйн нэгэн илрэл юм. Ийм ч учраас энэхүү стратеги амжилттай хэрэгжих нь тогтвортой хөгжилд хүрэх боломжийг ихэд нэмэгдүүлнэ хэмээн үзэж байна.

НЭЗТТ нь НХС-ийг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын нийгэмлэгээс дэмжлэг туслалцаа авах боломжийг бүрдүүлж байгаа юм. Гэхдээ НЭЗТТ-д оролцогч талуудад чухам хэрхэн туслалцаа үзүүлэх нь одоогоор тодорхой бус хэвээр байна. Тиймээс энэ бүлэгт энэхүү тодорхой бус байдлыг арилгах зорилгоор оролцогч талууд хоорондын мэдлэг мэдээллийн зөрүү, тэргүүлэх чиглэлүүдийн ялгаа, түүнчлэн үйл ажиллагаанд оролцох гол холбогдох талууд болон Монголын НХС-ийн хэрэгжилтийг урагш ахиулах арга замын талаар бидний зөвлөгөөг агуулсан болно.

6.1 МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙН ЗӨРҮҮ БА МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Монголын эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны голлох сорилтууд болон эдгээр сорилтуудыг даван туулахад зориулагдсан бодлого, хөтөлбөрүүдийн талаарх мэдлэгийн хэд хэдэн зөрүү бий. Чухам эдгээр зөрүүг арилгахад НЭЗТТ туслах боломжтой юм.

Хамгийн наад зах нь иргэд, ААН болон төр засгийн түвшинд ч мөн адил Ногоон эдийн засгийн талаарх ойлголт хангалтгүй байна. Мэдлэг тааруу, мэдээлэл дутмаг байдгаас зөв хэрэглээ, хэмнэлт, дахин ашиглалт гэх мэт Ногоон эдийн засгийн үндсэн ухагдахууныг мэддэггүй. Тиймээс одоогийнхоо хандлага, дадал зуршилдаа өөрчлөлт хийх нь үр дүнтэй. Жишээ нь хүрээлэн буй орчны асуудлыг дан ганц уул уурхайтай холбон тайлбарлах хандлага байдаг. Иймд энэ байдлыг зөвөөр таниулан, ухамсарлуулж өөрчлөлтийг бий болгоход сурталчилгаа сургалт болон тэдгээрийг

түгээх арга хэрэгслийг ч нягтлан бодолцох хэрэгтэй.

Хувийн хэвшлийнхний зүгээс аль болох хямд өртөг зардлаар үйл ажиллагаа явуулж ойрын хугацаанд ашгаа нэмэгдүүлэх хүсэлтэй байдаг. Үүнийг урт хугацааны тогтвортой хөгжил ба орлого гэсэн зарчмаар солиход дөхөм болох арга хэрэгслүүдийг санал болгон нийгмийн хариуцлагыг нь өсгөх зайлшгүй шаардлагатай.

Төрийн зүгээс байгалийн нөөцийн тогтвортой бус ашиглалт, үрэлгэн байдлыг зогсоож байгаль орчныг хамгаалах сэдлийг бодлого үйл ажиллагаандаа байнга тусгаж байх нь чухал юм.

Сэтгэлгээ, хандлага, дадал хэвшлийг төлөвшүүлэхэд сургалт семинар зохион байгуулах, эрдэм шинжилгээний бүтээл туурвих, уралдаан зохион байгуулах, багш сургагчдын мэргэжлийг дээшлүүлэх, сургалтад хамруулах зэрэг нь нэн түрүүнд хэрэгжүүлэх алхмууд билээ.

Өнөөгийн байдлаар үүсээд байгаа мэдлэгийн хамгийн том зөрүү болон мэдээллийн хомсдол нь хүрээлэн буй орчны талаар судалгаатай холбоотой байна. Монгол Улсад нүүрлээд буй хүрээлэн буй орчны асуудлуудын талаар олон судалгаа хийгдсэн байдаг. Нэг тайланд “Монгол Улсад хүрээлэн буй орчны хамгаалал, менежментийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд хангалттай мэдээллийн суурь бааз бүрдсэн”¹¹⁰ хэмээн дүгнэжээ. Гэсэн хэдий ч зарим гол асуудлуудын талаар хангалттай мэдээлэл байхгүй байна. Бидний уулзаж ярилцсан хэд хэдэн гол оролцогчид зарим чухал асуудлаарх мэдээлэл, судалгаа хангалтгүй байдаг хэмээж байсан юм.

Жишээ нь Монгол орны усны нөөц, нэн ялангуяа гүний усны нөөцийн тогтвортой байдлын талаар мэдээлэл, судалгаанууд өөр хоорондоо адилгүй, мэдлэгийн ихээхэн зөрүү оршин байгаа нь ажиглагдаж байв. Дэлхийн банкны нэгэн зөвлөхийн хэлснээр хомсдолд орох магадлалтай бүс нутгууд дахь гүний усны нөөц урт хугацааны хэрэгцээ шаардлагыг хангаж чадах эсэх талаар зарим тодорхойгүй асуудлууд бий бөгөөд, илүү нухацтай үнэлэн дүгнэх, усны үр ашигтай төлөвлөлт, удирдлагыг хэрэгжүүлэхийн

¹¹⁰ Тортелл. (2008).

тулд нөөцийн болон эрэлтийн судалгааг дахин нарийвчлан хийх шаардлагатай гэжээ.¹¹¹

Түүнчлэн, уул уурхайн үйл ажиллагааны улмаас учирсан хорхойрлын хэмжээний талаар мэдлэгийн томоохон зөрүү байсаар байна. Хэдийгээр Ашигт малтмалын газар уул уурхайн үйл ажиллагаанд өртсөн газрын хэмжээг бүртгэдэг ч, чухам хэр хэмжээний хохирол учирсан, нөхөн сэргээлтийн ямар түвшний үйл ажиллагаа шаардлагатай талаар мэдээлэл хомс байна. Үүний зэрэгцээ, энэ талаар цуглуулсан мэдээлэл, тоо баримт ихэнхдээ бүрэн бус, олоход хүндрэлтэй бөгөөд эсвэл огт байхгүй байдаг аж.

Мөн зарим судлаачид мал аж ахуйн үйл ажиллагааны тогтвортой бус байдал нь хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө болон уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийн талаарх мэдлэгийн зөрүүнд зовниж буй тухай дурдаж байв.

НЭЗТТ-ээс мэдээлэл тоо баримт цуглуулах болон, судалгааны дүнг олон нийтэд хүртээмжтэй болгох тал дээр туслалцаа үзүүлэх нь үр дүнтэй. МУЗГ-аас дэвшүүлсэн НХС-ийн зорилтуудын биелэлтийг хянахад үнэн бодит мэдээлэл, тоо баримт нэн чухал юм.

Түүнээс гадна, тулгарч буй бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд өнөөдөр хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн үр нөлөөний талаарх мэдлэгийн зөрүү байсаар байна. Тухайлбал, Засгийн газраас дэвшүүлж буй шинэ санал санаачилга, стратегийн талаар гэхэд, жишээ нь ногоон уул уурхайн стратеги, эсвэл эко аялал жуулчлалын шинэ стратеги, мэдээлэл тун хомс бөгөөд олон нийтэд ил болгосны дараа илүү тодорхой мэдээлэлтэй болно гэж найдахаас өөр аргагүй байна. Түүнчлэн, одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд, нэн ялангуяа МУЗГ-ын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үр дүнг хянах, мониторингийн үйл ажиллагаа хангалтгүй, ойлгомжгүй хэвээр байсаар байна. Жишээлбэл, Засгийн газрын Цэвэр агаар сангийн төсвийн зарцуулалтын талаарх нарийн тодорхой мэдээлэл байхгүй, үр дүн тодорхой бус байна.

Монгол Улсад Ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ мөн тодорхойгүй байна. Жишээ нь, сэргээгдэх эрчим хүчний салбарт ихээхэн нөөц бололцоо бий хэмээн үзэж буй. Гэсэн хэдий ч тодорхой төслүүдэд зориулан хийсэн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа хомс. Ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлохын тулд илүү нарийвчилсан судалгаа шаардлагатай байна.

6.2 ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУД

Монголын Ногоон эдийн засгийн хувьд тэргүүлэх салбарууд нь **хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүчний салбар** байна. Үүний зэрэгцээ тээвэр, хог хаягдлын удирдлага, аялал жуулчлалын салбарууд нь Монгол Улсын ногоон хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх юм.

Хөдөө аж ахуйн салбар нь нийт ажлын байрны 35%-ийг хангадаг учир Монголын ирээдүйд нэн чухал ач холбогдолтой юм. Хөрсний доройтол, усны нөөцийн эмзэг байдал, уур амьсгалын өөрчлөлт нүүрлээд буй өнөө үед хөдөө аж ахуйг тогтвортойгоор хөгжүүлэх нь ногоон эдийн засгийн хувьд онцгой ач холбогдолтой. Тус салбарт өнөөгийн байдлаар олон тооны санаачилга, төсөл хөтөлбөр хэрэгжиж буй хэдий ч тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, үр дүнгийн үнэлгээ, мониторинг шаардлагатай байгаа юм.

Монголд сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, нэн ялангуяа салхи, нарны эрчим хүчийг ашиглах нөөц боломж ихээхэн бий. Улс орон, компаниуд хүлэмжийн хийн ялгаруулалт багатай эрчим хүч эрэлхийлэхийн хэрээр Монголын хувьд сэргээгдэх эрчим хүч экспорт, импортын чухал бүтээгдэхүүн болох магадлалтай. Салхитын салхин станц нь сэргээгдэх эрчим хүчний том хэмжээний төсөл Монголд амжилттай хэрэгжих боломжтой гэдгийг харуулсан чухал жишээ юм. Олон улсын түншүүдийн хөрөнгө оруулалт, дэмжлэгтэйгээр энэ салбар цаашид Монголын тэргүүлэх салбарын нэг болж хөгжих боломжтой.

Нүүрсний хэрэглээгээ багасгаж чадахгүй байсан ч өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлт нийлүүлэлтэд эзлэх сэргээгдэх эрчим хүчний хувийг тогтмол өсгөх, нүүрсний утааны ялгарлыг бууруулахад чиглэсэн технологийг нэвтрүүлэх арга замуудыг эрэлхийлэх шаардлагатай. Иймд эрчим хүчний салбарт баримтлах бодлого болон хөрөнгө оруулалт нь аль болох төрөлжүүлэлтийг дэмжих нь зүйтэй.

6.3 НЭЗТТ-ИЙН АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ГОЛ ТАЛУУД

МУЗГ-аас ногоон хөгжилд хүрэхэд чиглэсэн хууль эрх зүйн зохицуулалтыг хангах баримт бичгийг боловсруулж эхэлсэн. Хор хохирол багатай уул уурхайн салбар болон хүрээлэн буй орчинд ээлтэй, өндөр бүтээмжтэй хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр зарим ахиц дэвшлүүд гарч байгаа нь сайшаалтай. Жишээ нь зуун мянган нарны гэр төсөл амжилттай хэрэгжсэний дээр Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2007) батлагдсанаар Салхитын салхин

111 А.Арена (албан бус ярилцлага, 2013 оны 1 дүгээр сарын 21)

станцыг байгуулах, сэргээгдэх эрчим хүчний салбарыг цаашид хөгжүүлэх хууль эрх зүйн суурийг тавьж өгсөн.

Төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хөрөнгө оруулагчдын хувьд Монголын ногоон үзэл баримтлалыг бататгаж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл хэргийг дэмжиж буй. Цаашид энэхүү санаачилгад бизнес эрхлэгчид болон иргэдийг хамруулахын тулд дэмжлэг, татаасны зөв хуваарилалт бүхий өргөн цар хүрээтэй бодлого хэрэгжүүлэх нь үр дүнтэй.

Засгийн газрын мөрийн хөтөлбөр нь “мөрөөдлийн” уриа лоозон болж бодит биелэлт нь хангалтгүй байх хандлага ажиглагддаг. Нөгөө талаас байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл ба хэрэглээг дэмжих, хохирол учруулсан тохиолдолд тооцох хариуцлагыг илүү тодорхойлох нь чухал юм.

Түүнчлэн уул уурхайн үйл ажиллагаа, ялангуяа жижиг хэмжээний уул уурхай, гар аргын олборлолтын үйл ажиллагааг албан хэлбэрт шилжүүлэхэд чиглэсэн ажлуудыг хийснээр “далд” учруулсан хохирлыг алгуур ил тод болгох, хууль эрх зүйн хүрээнд асуудлыг шийдвэрлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулахад ихээхэн дөхөм болно. Үүнтэй мөн адил ХАА болон бусад салбарт өөрчлөлт хийх гээд амжилтад төдийлөн хүрдэггүй зарим асуудлууд дээр хууль эрх зүйн хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлж өгөхөд анхаарах нь чухал юм.

Хүрээлэн буй орчинд нүүрлэж буй бэрхшээлийг даван туулах, Рио+20 бага хурлын үеэрх амлалтаа биелүүлж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд МУЗГ Ногоон хөгжлийн стратегийг (НХС) хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тус стратегийг УИХ-ын Намрын чуулганаараа авч хэлэлцсэн боловч хараахан батлаагүй байгаа юм. Энэхүү баримт бичиг батлагдсан тохиолдолд, Монгол Улс ногоон хөгжлийн замаар замнахын тулд хүрэх ёстой зорилго, үзүүлэлтүүд тодорхой болгох юм. Тиймээс Засгийн газар, нэн ялангуяа Байгаль орчин, ногоон хөгжлийн яам нь НЭЗТТ-ийн чухал түнш болно.

Гэхдээ Засгийн газар нь ногоон хөгжлийг эрчимжүүлэхээр ажиллаж буй цорын ганц оролцогч биш. Хувийн хэвшлийн зарим байгууллагууд ногоон эдийн засгийн ач холбогдлыг ойлгон, ногоон хөгжилд хүрэх арга замыг мөн эрэлхийлж байна.

Монголын бизнесийн байгууллагуудын томоохон төлөөллийн бүлэг болох МҮХАҮТ өөрийн боловсруулсан ногоон стратегийг “5x20” зорилгын хүрээнд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн Монголын бизнесийн зөвлөлд байнгын ажлын таван хэсэг байдаг бөгөөд эдгээрийн нэг нь бизнесийн байгууллагын төлөөллүүдээс бүрдсэн

“Байгаль орчны ажлын хэсэг” байна. Түүнчлэн, Хас, Голомт зэрэг банкууд ногоон зээл, хөрөнгө оруулалтыг нэвтрүүлэх стратегийг хэрэгжүүлж байгаа юм. Ньюком зэрэг компаниуд сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийж байна.

Үүний зэрэгцээ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд агаарын бохирдлыг бууруулах, усны менежментийг сайжруулах төслүүдийг санхүүжүүлж байгаа бөгөөд сэргээгдэх эрчим хүчний дэд бүтэц байгуулах зориулалтаар зээл тусламж олгож байна. Түүнчлэн, Байгаль хамгаалах сан зэрэг ТББ-ууд тус тусын хүрээлэн буй орчны төслийг хэрэгжүүлж байна.

6.4 НЭЗТТ-Д ӨГӨХ САНАЛ ЗӨВЛӨМЖҮҮД

МУ-ын засгийн газрын Ногоон хөгжлийн үзэл баримтлалыг УИХ-аар батлуулан хэрэгжүүлэхэд НЭЗТТ төслийн тусламж, хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой. Судалгаанаас харахад ногоон хөгжлийн стратегийг боловсруулж, НЭЗТТ-ийн хэрэгжилтийг сайжруулахын тулд дараах таван чиглэлд голлон анхаарлаа хандуулахыг зөвлөж байна. Эдгээр нь:

1. Ногоон хөгжлийн үндэсний стратегийг урт хугацааны хөтөлбөр болгон хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах.
2. Энэхүү стратегийн хөтөлбөр нь зөвхөн нэг яамны ажил хэрэг бус бусад яамд, холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлэгч байх. Ингэхдээ одоогийн байгаа баримт бичгүүдэд тулгуурлан ногоон хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлоход чиглэсэн хэлэлцүүлгүүд өрнүүлж санал асуулга авах, ногоон хөгжлийн холбогдолтой төсөл, санаачилгуудыг цогцоор судлан оруулах;
3. Хөрөнгө оруулалтын үр ашигтай, тасалдахгүй байх байдлыг сайжруулахад анхаарч бодлогын хүрээнд шийдвэрлэх арга замуудыг эрэлхийлэх. Тухайлбал одоогийн хөрөнгө оруулалтууд болон тодорхой зорилтууд бүхий төслүүдийн үр дүнг үнэлэн хэмжихэд дэмжлэг үзүүлэн шийдвэрлэхээр зорьж буй зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч хамтран ажиллах. Улмаар хөрөнгө оруулалтын тасалдлыг нөхөх арга замыг тодорхойлоход туслах.
4. Ногоон хөгжлийн талаар сургалт, сурталчилгааны дутмаг байдлыг нөхөхөд анхаарах;
5. Шинэ дэвшилт технологи, инновацийг нэвтрүүлэх, бүтээн байгуулалтанд байгаль орчинд ээлтэй ногоон технологи ашиглахад дэмжлэг үзүүлэх, бусад улс орнуудад хэрэгжсэн сайн жишээнүүдээс туршлага солилцох;

Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд дараах асуудлуудад анхаарах нь үр дүнтэй:

1. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, стратегиудын хүрээнд хэрэгжих боломжтой, бодит зорилтуудыг дэвшүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлэх;

БОНХЯ-наас боловсруулсан НХС УИХ-аар батлагдсан ч суурь өөрчлөлтөд хүргэхгүй байх бодит эрсдэл оршин байна. Тухайлбал, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар (2006) ДНБ-ий 1.5%-ийг судалгаа, хөгжүүлэлтэд зориулна гэж заасан. Гэхдээ тус салбарын одоогийн санхүүжилт энэ хувийн хаана ч хүрэхгүй гэсэн таамаг бий. Үүний гол шалтгаан нь энэ төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, хангах тогтолцоо байхгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Байгаль орчны асуудалд анхаарлаа хандуулдаг эрдэм шинжилгээний төрөлжсөн байгууллага байхгүй, мэргэжлийн үнэлгээ хийх боловсон хүчний чадавх сул тул энэ чиглэлээр эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж хэлэлцүүлэг өрнүүлэх нөхцөл бүрдэхгүй байна. Иймд онол арга зүй болон практикийн арвин судалгаа, эрдэм шинжилгээ, загварчлал хөгжүүлэх боловсон хүчнийг бэлдэж, институтийг байгуулах нь зүйтэй.

Түүнчлэн НХС-ийн төсөл дээр хангалттай хэлэлцүүлэг хийгдээгүй гэх нь бий. БОНХЯ тус стратегийг бусад гол яамдаар хэлэлцүүлээгүй учир хэрэгжилтэд шаардлагатай арга хэмжээг тусгаж чадаагүй байх магадлалтай.

БОНХЯ бусад үндсэн чиглэлийн яамдтай нэгдмэл ойлголтод хүрэх нь чухал. Үүнд Уул уурхайн яам, Эрчим хүчний яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамд багтах юм. Эдгээр болон бусад яамд тус бүр Ногоон хөгжлийн стратегийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагааны төлөвлөгөө нь бодит байдалд хэрэгжих боломжтой байх шаардлагатай. Хэрэв НХС-д дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай тухайн яам санал нийлэхгүй байгаа тохиолдолд үүнийг харилцан ойлголцол, зөвшилцлийн зарчмаар шийдэх нь чухал.

Түүнээс гадна, төлөвлөгөөнд тусгасан зорилт нь зөвхөн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад бус харин монголчуудын өдөр тутмын амьдралд тулгамдаж буй асуудлуудыг бодитойгоор шийдвэрлэх боломжтой байх нь чухал. Өөрөөр хэлбэл зөвхөн нар, салхины эрчим хүчийг ашиглаж байж л “ногоорох” гэсэн ойлголтоос салах хэрэгтэй.

НЭЗТТ зөвхөн зорилго, зорилтууд дэвшүүлээд зогсохгүй, аж үйлдвэрийн салбарууд өөрсдийн үйлдвэрлэлийн нөөц бааз дээрээ тулгуурлан тус тусын ногоон технологийг хөгжүүлэх, цаашилбал хүрээлэн буй орны асуудлуудад зориулсан эрэлтэд суурилсан шийдлүүдийг боловсруулан гаргахад шаардлагатай стратегиудыг боловсруулахад мөн

анхаарах хэрэгтэй.

2. Дотоодын болон олон улсын санхүүжилт бүхий хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах

Монголд Ногоон эдийн засгийг хөгжүүлэхийн тулд төсөл хөтөлбөрүүдийн зохион байгуулалт, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай. Үүнд, ногоон хөрөнгө оруулалт, ногоон ажлын байр, хүрээлэн буй орчны чиглэлээрх төслүүд багтана. Монголд хүрээлэн буй орчны чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн байгууллага, төсөл хөтөлбөрүүд харьцангуй олон бий. Эдгээр хөтөлбөрүүд ихэвчлэн ҮХЦБ болон Засгийн газрын Мөрийн хөтөлбөрт тусгасан зорилтуудтай уялдсан байдаг. Эдгээр төслүүд нь тус тусдаа харилцан адилгүй зорилго, зорилтуудтай байдаг хэдий ч зохицуулалт, уялдаа холбоог сайжруулснаар харилцан ашигтай байхаас гадна тус бүрийнх нь үр дүнд эергээр нөлөөлөх боломжтой.

Түүнчлэн, ногоон хөгжлийн асуудлуудын зөвхөн шинж тэмдэг бус суурь шалтгаанд анхаарал хандуулах шаардлага тулгарч байна. Жишээлбэл, гэр хорооллын өрхүүдийг орон сууцанд оруулах, эсвэл хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг багасгахын тулд бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх зэрэг холыг харсан санаачилгыг нь гэр хорооллын зуухнаас ялгарах утааг бууруулах зэрэг богино хугацааны үйл ажиллагаатай хавсран хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм.

Гэхдээ энэ нь хялбар ажил биш юм. Тухайлбал, хөрсний доройтлын зарим хувь нь олон мянган жилийн турш уламжлагдаж ирсэн нүүдлийн мал ахуй болон малын тоо толгой өссөнтэй холбоотой. Мөн Тортеллын дурдсанчлан “Эдгээр төслийн үр дүнг хойш нь татаж байдаг учир эдгээр суурь шалтгаантай тэмцэх нь дандаа хялбар байдаггүй. Хэрэв суурь шалтгааныг шийдвэрлэж чадвал, гаргаж буй шийдлүүд нь илүү тогтвортойгоор хэрэгжих боломж бүрдэх юм.”¹¹²

Олон улсын хандивлагчдаас санхүүжүүлж буй төслүүдийг Ногоон хөгжлийн чиглэл рүү татах ажиллагаа явуулах нь шинж тэмдэгтэй тэмцэхэд тустай. Энэ уялдаа холбоог хангах чиг үүрэг нь Эдийн засгийн хөгжлийн яамны үүрэг хэмээн харагдаж байна. Тус яам нь Монгол Улсад олгож буй олон улсын зээл тусламжийг хуваарилах үүргийг хүлээдэг.

Ер нь Монголын төрийн бодлогод дутагдаж байгаа нэг гол зүйл бол төрийн залгамж чанар байхгүй явдал юм. Түүнчлэн судалгаанд тулгуурлаж бодлого боловсруулахаас авхуулаад, бодлого хоорондын уялдаа, бодлогын хэрэгжилт, хяналт, үнэлгээ хийх арга барил хангалтгүй, мөн эргээгээд судалгааны ажил орхигддог зэргээс

харвал ерөнхий засаглал сул байгааг илтгэж байна. Мөн яамд байгууллага хоорондын уялдаа, салбар дундын зохицуулалт муу байгаа зэргийг харгалзан үзэж Ногоон эдийн засгийн стратегиар дамжуулан хөгжлийн бодлогыг зангидаж засаглалыг сайжруулах нь чухал юм.

3. Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны одоогийн нөхцөл байдлыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд;

МУЗГ-аас санаачлан хэрэгжүүлэхээр зэхэж буй зарим бүтээн байгуулалтын төсөл хүрээлэн буй орчны хор хохирлыг улам даамжруулах эрсдэлтэй байна. НЭЗТТ-ээс эдгээр төслийн чиглэлийг үнэлэх, шаардлагатай тохиолдолд залруулахад туслалцаа үзүүлэх шаардлагатай.

Тухайлбал, Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулахуйц боловсруулах үйлдвэрийн дэвшилт технологи нэвтрүүлэх зорилготой. Гэсэн хэдий ч, тус цогцолбор дээр хэрэгжих үйл ажиллагааны дийлэнх нь шатамхай түлш ашиглах аж. Тиймээс төслийн чиглэлийг эргэн харж, нарны хавтангийн үйлдвэрлэл зэрэг илүү ногоон чиглэлүүдийг багтааж өгөх нь Ногоон хөгжлийг сайжруулах чухал алхам болох юм.

Ногоон хөгжлийн үндсэн шалгуур, өсөлтийн хүчин зүйл болон хэмжих үзүүлэлтүүдийг тодорхой болгож улмаар өнөөгийн байдлаар хэрэгжиж байгаа баримт бичгүүдийн хэрэгжилтэнд фокус үнэлгээ өгөх нь зүйтэй юм.

4. Хөрөнгө оруулалтын дутагдлыг нөхөх нэмэлт эх үүсвэрийг тодорхойлох нь

Монголын хүрээлэн буй орчны өнөөгийн төлөв байдлын талаар ихээхэн судалгаа хийгдсэн. “Монгол Улсад хүрээлэн буй орчны хамгаалал, менежментийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд хангалттай мэдээллийн суурь бааз бүрдсэн.” байна хэмээн зарим мэргэжилтнүүд дүгнэж байна.

Гэсэн хэдий ч судалгаанд оролцсон хэд хэдэн байгууллагын төлөөлөл Монголын усны нөөц, уул уурхайн үйл ажиллагааны бодит хор хөнөөл, малын бэлчээрийн асуудлаар шаардлагатай мэдээлэл дутагдалтай бөгөөд тодорхойгүй байгаа хэмээсэн юм. Ногоон эдийн засгийг хөгжүүлэх үйл ажиллагааныхаа хүрээнд эдгээр чиглэлээр нэмэлт судалгаа явуулах шаардлага НЭЗТТ-д тулгарч болзошгүй.¹¹³

Техникийн туслалцаа үзүүлэх, хүрээлэн буй орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй технологи боловсруулах ажиллагаа мөн НЭЗТТ-ийн үйл ажиллагааны чухал хэсэг болно. Жишээ нь МҮХАҮТ болон МБЗ зэрэг байгууллагуудаар дамжуулан ногоон хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагуудад хүрч ажиллах боломжтой.

Түүнчлэн, НЭЗТТ-ээс МҮХАҮТ-ын эрчим хүчний хэмнэлтийн талаарх гарын авлага, мэдээллийг орчуулах, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын санал санаачилгын талаарх Засгийн газрын харьяа агентлагууд, олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх боломжтой.

НЭЗТТ-ээс мөн техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэх боломжтой. Цаашид, Монголын аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэл явуулахын зэрэгцээ, эрчим хүч хэмнэж болдог гэдгийг харах юм. Гэхдээ үүнийг санхүүжүүлэх чадвар, хөгжүүлэх чадварын хоорондын зөрүү нь олон аж ахуйн нэгжийн хувьд тулгамдсан асуудал байж мэдэх юм.

Судалгаанд оролцогчид мөн НЭЗТТ-ээс хүрээлэн буй орчны болон эрчим хүчний хэмнэлттэй дэд бүтцийг хөгжүүлэх төслийн техник эдийн засгийн судалгаа хийхэд туслалцаа үзүүлэхийн ач холбогдлыг цохон тэмдэглэж байв. Ногоон эрчим хүчний талаар техник эдийн засгийн судалгаа олонтаа хийгдэж байсан ч, тэдний олонх нь санхүүжилт олоход шаардлага хангахгүй байсан хэмээжээ.

5. Хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх бодлогыг үнэлж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд

Өнөөг хүртэл дотоод гадаадын төсөл хөтөлбөр, санхүүгийн дэмжлэг туслалцаа, зээл зэргийг хаана, юунд үндэслэж, хэрхэн татан төвлөрүүлж ирсэн асуудлууд төдийлөн тодорхой байгаагүй. Энэ нь магадгүй хөгжлийн урт хугацааны зорилго, стратеги, чиглэл бүрхэг байгаатай холбоотой байж болох юм.

Төслийн үндэслэлийг зөв гаргаж ирэхээс гадна, хожим гарч ирэх үр дүнг нэгтгэн дүгнэх, цаашилбал бусад бүс нутаг, ижил төрлийн асуудал эсвэл өөр салбарт дахин туршиж хэрэгжүүлэх бололцоотой эсэх талаарх дүгнэлт зөвлөмж байдаггүй. Жишээ нь агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хэрэгжсэн олон төслүүдийн үр дүнг тус тусад нь оновчтой үнэлэхэд бэрхшээлтэй байна.

Бүс нутаг, хүн ам болон салбарын хэмжээнд харилцан адилгүй цар хүрээг хамарсан мөн хөрөнгө төсөвтэй төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа. Гэвч тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, тойм ойлголт хангалтгүй бөгөөд мэдлэгийн зөрүүтэй явсаар байна.

6. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврууд, хүн амын хот суурин газар руу шилжих хөдөлгөөн ихсэж буйг анхааран хэрэгжүүлэх алхамууд

Цаг агаарын таагүй нөхцөл байдал, тухайлбал цөлжилт, усны хомсдол, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдлээс болж мал нь хорогдож амьжиргааны эх үүсвэрээ алдсан малчид хот руу чиглэсээр байна.

Нөгөө талаас уул уурхайн бүс нутагт оршин

суудаг малчид хэт тоосжилт, усны бохирдол, бэлчээрийн доройтолд нэрвэгдэх явдал гарсаар байна.

Тухайлбал, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн олборлож буй эрдсийн төрөл зүйл, үйл ажиллагаа, стандарт даган мөрдөлт, хэрэгжүүлэлт зэргийн харилцан адилгүй байдлаас үүдэж хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө ерөнхийдөө өндөр байна. Энэ нь учруулсан хор хөнөөлийн төрөл, хэмжээ, үнэлгээний нэгдсэн ойлголт тохируулга дутмаг бөгөөд хариуцлага тооцохтогтолцоо ойлгомжгүй байдагтай холбоотой юм. Иймд хөдөө орон нутагт хэрэгжүүлэх Ногоон эдийн засгийн хөгжлийн бодлого нь дараах шинж чанарыг хангасан байх:

- Болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгаатай байх
- Учирсан хохирол хөнөөл, үр дагаварыг зөөлрүүлэх, багасгах, арилгахад чиглэсэн мэдээллүүд байх
- Нийгэм, эдийн засаг хүрээлэн буй орчны нөхөн сэргээлтийн бодлого, журамтай байх

Үүний зэрэгцээ олон монголчууд эдийн засгийн өсөлтөөс үүдэн гарч буй боломжуудыг ашиглахын тулд хот суурин газрыг зорьж байна. Өмнөхийн нэгэн адил хот, хөдөөгийн эрс тэс ялгаа хэвээр байгаа бөгөөд жишээ нь хот суурин газрын бараг бүх хүн ам, харин хөдөө орон нутгийн иргэдийн дөнгөж 53% сайжруулсан эх үүсвэрээс ундны усны хэрэглээгээ хангаж байв. Иймд Монгол Улсын хэмжээнд:

- Газар зүй, хүн ам зүйн (нас, хүйс, чадавх) болон нийгмийн (боловсрол, мэргэжил) бүх түвшинд гарааны нөхцлийг ижил бүрдүүлж тэгш бололцоог олгох.
- Зорилтот бүлгүүдэд зориулж ажил эрхлэх, боловсрол эзэмших зэрэг нөхцөл бололцоог бүрдүүлж өгөх
- Шилжин ирэгсдэд чиглэсэн тусгай бодлого, хөтөлбөрүүдийн уялдаа холбоо
- Хотын хөгжил, тогтмол сайжруулах бүтээн байгуулалт




Ашигласан материалын жагсаалт

- Хөрсний бохирдол аюулын харанга дэлдэж байна, 2012 оны 2-р сарын 8 <http://www.news.mn/content/96725.shtml>; <http://english.news.mn/content/96843.shtml>
- Азийн хөгжлийн банк: Монгол Улсын байгаль орчны үнэлгээ, 2005 оны 11 сар <http://translate.google.de/translate?hl=de&sl=en&tl=mn&u=http%3A%2F%2Fwww.adb.org%2Fdocuments%2Fcountry-environmental-analysis-mongolia>
- Азийн хөгжлийн банк, Тээвэр болон худалдааг хөнгөвчлөх үнэлгээний баримт бичиг, Улаанбаатар хот, 2008 оны 7 сар; <http://www.adb.org/documents/transport-and-trade-facilitation-potential-better-synergies-mongolia>
- Азийн хөгжлийн банк, Азийн хөгжлийн төлөв байдал: Азид тулгарч буй тэгш бус байдал нэмэгдсэн нь; 47 хуудас
- Алдрич энд Мэлвилл, “Монгол Улсын Байгаль орчны эрх зүйн барим бичиг уул уурхайн салбарт үзүүлж буй нөлөөлөл”, 2012 оны 10-р сарын 8, Хоган-Ловэллс <http://www.hoganlovells.com/revision-of-environmental-laws-in-mongolia-and-its-impact-on-the-mining-sector-10-08-2012/>
- Д.Алтантуяа, З.Зонгруй; “Монгол Улсын хатуу хог хаягдлын менежмент: Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын боловсруулалтын дүн шинжилгээ”; 2012 он <http://www.must.edu.mn/pdf/7420Dashnyam%20Altantuya.Shanghai.pdf>
- Ази номхон далайн эрүүл мэндийн тогтолцоо болон бодлогын ажиглалтын төв (2013) “Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцооны үнэлгээ” http://www.wpro.who.int/asia_pacific_observatory/hits/series/mng/en/
- Австралийн хамтын ажиллагааны нийгэмлэг; “Монгол Улсын өмнөд хэсгийн гүний усны менежмент” <http://www.aid.gov.au/countries/eastasia/mongolia/Pages/economic-development-init-1.aspx>
- М.Бадраа, М. Санжаасүрэн, А. Мөнхгэрэл; “Барилгын салбарын эрчим хүчний үр ашгийн төслийн дунд хугацааны үнэлгээ”, Улаанбаатар 2012 он
- Б.Баяртогтох; “Моргэйжийн эхлэл ба төгсгөл-Монголын эдийн засаг, Дугаар 15, 2013 оны 8 сар
- Монгол Банк; “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээ” 2013 он http://www.mongolbank.mn/ipotek_statistic.aspx?id=2_43
- Д.Бэхбаяр, “Бид нарт бас мөрөөдөл бий” Монголын эдийн засаг, Дугаар 13, 2013 оны 7-р сар
- “С. Дэмбэрэл Иргэний зориг намд элсэв”; 2011 оны 10-р сарын 28 <http://www.business-mongolia.com/mongolia/2011/10/28/s-demberel-becomes-member-of-civil-will-party/>
- Н.Чойбалсан; “Монгол Улсын цэвдэг болон хөрсний бүтцийн судалгаа– Олон улсын 7-р бага хурал” (Хурлын тэмдэглэл), Нордиканы хурал Дугаар 55, 1998 он
- “Улаанбаатар хотын дундаж температур”; Улаанбаатар, Монгол Улс 2013 он www.climatemps.com; <http://www.mongolia.climatemps.com/temperatures.php>
- Дарь; Монголын анхны машин үйлдвэрлэл нээгдэв, УБ пост, 2014 оны 1-р сарын 16
- Б.Даринчулуун, “Монгол Улс:Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын товч үнэлгээний тайлан”, 2011 оны 9-р сарын 12, ЗГХЭГ, МУЗГ
- Европын Сэргээн босголт хөгжлийн банк, “Монголын анхны салхин парк салхит эрчим хүчээ үйлдвэрлэж эхлэв”. 2013 оны 6-р сарын 20
- АНУ-ын ЭСЯ, “Монгол Улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр АНУ-ын ОУХА болон ГОУХА хамтран ажиллаж байна” хэвлэлийн мэдээ; 2012 оны 5-р сарын 4

- Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв- “Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан 2012”
- Эдвардс.Т; “Уул уурхайгаас хамааралтай Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөөс сэргээгдэх эрчим хүч рүү зүтгэж байна.” 2013 оны 6-р сарын 5; Ройтерс; Улаанбаатар хот
- “Хэвлэлийн хамтарсан мэдэгдэл:Уул уурхай, олон нийттэй харилцах алба: Монгол малчид Оюу толгой уурхайд Рио Тинто компанийн эсрэг гомдол гаргав.” 2012 оны 10-р сарын 12 <http://www.escr-net.org/node/365339>
- С.Фишер, Б.Түвшинтөгс, А.Гүрнэй, Г.Рагчаасүрэн, М.Бегг, Б.Буянцогт, Л.Эсмэдэх болон Б.Чадраабал нарын “Оюу толгойн зэсийн уурхайн хөгжил: Монгол Улсын макро эдийн засгийн үр дагаврын үнэлгээ”, БиАйИ тайлан, Канберра хот
- Монгол Улсын засгийн газар; “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлах тухай” МУЗГ-ын 2008 оны 2- р сарын 12-ний тогтоол
http://mofa.gov.mn/coordination/images/stories/resource_docs/nds_approved_eng.pdf
- Монгол Улсын засгийн газар; Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай “Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт” ЗГ-ын 2012 оны 12-р сарын 22-ний 193-р тогтоол
- МУЗГ-ын тогтоолын төсөл, Хавсралт 1 “Ногоон хөгжлийн үзэл баримтлал”
- МУЗГ-ын тогтоолын төсөл, Хавсралт 2 “Дунд хугацааны ногоон хөгжлийн хөтөлбөр”
- Т.Хилкер, Э.Нацагдорж, Р.Ш.Варинг, А.И. Ляпустин, И.Ванг нарын “Хиймэл дагуулын ажиглалтаар Монголын тал нутагт тархсан бэлчээрийн хомсдол” Глобал өөрчлөлт сан, 2013 он
- И.Хамбер, “Монгол Улс Самурай бондоос 1 тэрбум.ам доллар босгоно”; Блумберг 2013 оны 9-р сарын 15
- Олон улсын валютын сан; “Дэлхийн эдийн засгийн төлөв байдал”, 2013 оны 10-р сар
- Инфо Монгол; “Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОИКА) Улаанбаатар хотын ус цэвэрлэх байгууламжийг дахин шинэчилнэ.”; 2011 оны 11-р сарын 3
- Инфо Монгол; “Гал үндэстэн хөдөлгөөний гишүүд галт зэвсэг, гранатаар занал учруулсан хэргээр баривчлагдсан байна”; 2013 оны 9-р сарын 16 <http://www.infomongolia.com/ct/ci/6693>
- Инфо Монгол; “Өнөөдрийн байдлаар “Чингис” бондоос 347 сая ам.доллар үлдсэн гэж ерөнхий сайд Н.Алтанхуяг мэдэгдэв.” <http://www.infomongolia.com/ct/ci/6020>
- Инфо Монгол; “Монгол дахь донор байгууллагуудад ЖДҮ-ийг хөгжүүлэх хөтөлбөрийг танилцуулав” 2013 оны 11-р сарын 28 <http://www.infomongolia.com/ct/ci/7085#>
- П.Жекоб; “Монгол Улс: Шинэ халаалтын технологи агаарын бохирдлын тэмцэл”; 2013 оны 3-р сарын 8 www.eurasianet.org
- Ж.Канг Дэлхийн ногоон өсөлтийн институт, “ДНӨИ-ийн танилцуулга НЭЗТТ хэлэлцүүлэгт танилцуулав”; 2013 он
- М.Жон “Бохирдолд бүрэн орсон Монгол Улс цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах гэж байна” Нью Йорк Таймс, 2012 оны 12-р сарын 3
- Б.Хүдэр, Нийгмийн халамжийн тухай хууль; Монголын өдөр тутмын эдийн засгийн тойм, 2012 оны 1-р сарын 23 <http://www.mongoliaeconomy.com/law-on-social-welfare-revised-beneficial-for-many/>
- Б.Хүдэр; “Монгол Улс ногоон хөгжлийн бодлогтой болох хэрэгтэй” 2013 оны 7-р сарын 5; Монцаме мэдээллийн агентлаг <http://www.montsame.gov.mn/en/index.php/politics/item/1378-mongolia-to-have-policy-on-green-development>
- Лию ИИ, Иван ЖП, МкКаб МФ, дө Жөү РАМ, ван Дижк АЙЖМ, эт ал “Монголын тал нутаг дахь уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн дортойтол” ПлоС 1, 8(2): e57599

- Р.Маршал, Ф.Никсон, Би.Вольтерс; “Монгол Улс дахь эдийн засгийн бодлого, ядуурлын үр дагаврыг тогтоох нь”, 2008 оны 2-р сар, БиВиПиАй судалгааны ажил 27.
- Монгол Улсын Гадаад харилцааны яам 2009 он; “Монгол Улсын Үндэсний Мал аж ахуйн хөтөлбөр” (Драфт); <http://www.mofa.gov.mn/mn/images/stories/busad/mmeng.pdf>
- Монгол Улсын Гадаад харилцааны яам 2010 он; “Малчдад чиглэсэн ЗГ-ын бодлого” орчуулга
- Монголын Уул уурхайн үзэсгэлэн, вэбсайт 2013 он <http://www.miningandconstructionmongolia.com/en/index.asp>
- Ашигт малтмалын газар; Уул уурхайн салбарын статистикийн мэдээ, 2013 оны 8-р сар www.mram.gov.au
- Монгол Улсын Агаарын бохирдлын төсөл; <http://www.indiegogo.com/projects/mongolian-air-pollution-project>
- Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхим (МҮХАҮТ); “Ногоон ном: Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу”, Улаанбаатар, Монгол Улс 2013 он
- Үндэсний статистикийн хороо; Сарын тойм 2013 он <http://www.nso.mn/v3/index2.php>
- Үндэсний статистикийн хороо; 2013 он, 1212 мэдээллийн сан; <http://www.1212.mn/en/>
- Үндэсний статистикийн хороо; “Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллого” 2010 он <http://www.toollogo2010.mn/index.php?language=en>
- П.Болормаа; “Бичил уул уурхай: Монгол улсын жендерийн тэгш байдал, тогтвортой амьжиргаа; 11-р бүлэг: Бичил уурхайн холбоодыг тогтвортой амьжиргаанд хүргэх, орон нутгийн хөгжлийг дэмжих нь” хянан тохиолдуулсан Кунтала Лахира-Дүт; Канберра хот: Ази-Номхон дайлан байгаль орчин Монограф 6; АНУ хэвлэлийг эрхлэн гаргав. Австралийн Үндэсний их сургууль
- Швейцарийн олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг; “Тогтвортой бичил уурхай төсөл”; 2013 он <http://www.sam.mn/>
- М.Шари, Салон: Алишер Али, “Монгол улсын өсөлт”, Глобал Финанс сэтгүүл, 2012 он <http://www.gfmag.com/archives/153-may-2012/11751-salon-alisher-ali-mongolian-growth.html#axzz2giPXuTVm>
- П.Тортэлл, А.Боржидхан, Э.Нандинсүрэн; “Монгол Улс дахь байгаль орчны менежментийн зохион байгуулалтын бүтэц”; Улаанбаатар болон Веллингтон хот, 2008 оны 8-р сар
- А.Цэнддаваа; “Монгол Улсын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд”; Хуралдааны агуулга онцгой нөхцөл байдалд ур чадварыг хөгжүүлэх нь 2010 оны 9-р сарын 28-30, Токио хот
- П.Товуудорж; “Монгол Улсын эрчим хүчний хөтөлбөр, бодлогын арга хэмжээ: Бүс нутгийн хамтын ажиллагааны цар хүрээ”; Зүүн хойд Азийн наймдугаар чуулганаар Эрчим хүчний хамтын ажиллагааны ахлах албан тушаалтны хорооны танилцуулга 2013 оны 4-р сарын 10-11, Улаанбаатар хот
- УБ Пост, “БОНХЯ-ны агаарын бохирдлыг бууруулах тайлан” 2013 он <http://ubpost.mongolnews.mn/?p=6578>
- НҮБ-ийн байгаль орчны хөтөлбөр; Монгол Улс 2001 он “Монгол Улс: Төрийн байгаль орчин”; Ази Номхон далайн бүс нутгийн нөөцийн НҮБ-ийн байгаль орчны төв, Тайланд
- НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, “Барилгын эрчим хүч хэмнэлт” Монгол Улс, 2012 он
- НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр; “Монгол Улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: Тулгарч буй бэрхшээлүүд ирээдүйд авч хэрэгжүүлэх арга хэмжээ”, Улаанбаатар 2012 он
- НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр; “Монгол Улс дахь байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь” II-р шат; НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр хамтарсан төслийн баримт бичиг <http://www.undp.mn/snrm-segm.html>
- НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Монголын тухай <http://www.undp.org/content/mongolia/en/home/countryinfo/>

- НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр; “Монгол Улс: 2013 оны Хүний хөгжлийн илтгэлийн зэрэглэлийн өөрчлөлт, Хүний хөгжлийн индексийн ач холбогдол”; <http://hdrstats.undp.org/images/explanations/MNG.pdf>
- НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр “Ногоон эдийн засаг гэж юу вэ?” 2013 он <http://www.unep.org/greenconomy/AboutGEI/WhatisGEI/tabid/29784/language/en-US/Default.aspx>
- Бэт Ваттс; “Монгол Улсын хүнд цаг үе; Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар хөдөлгөөний сэтгүүл; Дугаар1,2003 он http://www.redcross.int/EN/mag/magazine2003_1/20-21.html
- Дэлхийн банк; “Монгол орны ойн салбарын тойм”; 2003 он
- Дэлхийн банк; “Улаанбаатар хотын Агаарын чанарын шинжилгээ: Агаарын чанарыг сайжруулж эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах нь”; 2011 оны 12-р сар
- Дэлхийн банк 2012 он; “Зүүн Ази, номхон далайн бүс, Монгол улсын Байгаль орчны тойм” <http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/COUNTRIES/EASTASIAPACIFICEXT/EXTAPREGTOPEMIRONMENT/0,,contentMDK:20266325~menuPK:537827~pagePK:34004173~piPK:34003707~theSitePK:502886,00.html>
- Дэлхийн банк 2013 он; Мэдээллийн сан, Монгол Улс <http://data.worldbank.org/country/mongolia>
- Дэлхийн банк 2013 он; Улс ба зээлийн бүлэг <http://data.worldbank.org/about/country-classifications/country-and-lending-groups>
- Дэлхийн банк 2013 он; “Зүүн Ази, Номхон далайн бүсийн байгаль орчин; Нидерланд-Монголын байгаль орчны шинэчлэлийн Итгэлийн сан” (HEMO)
<http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/COUNTRIES/EASTASIAPACIFICEXT/EXTAPREGTOPEMIRONMENT/0,,contentMDK:21080050~pagePK:34004173~piPK:34003707~theSitePK:502886,00.html>
- Дэлхийн банк; “Хөдөлмөрийн зах зээлд жендерийн тэгш бус байдал, Бодлогын зөвлөмж”
- Дэлхийн банк; Төслүүд болон үйл ажиллагаа: “Улаанбаатар цэвэр агаар төсөл” <http://www.worldbank.org/projects/P122320/ulaanbaatar-clean-air-project?lang=en>
- Дэлхийн банк; “Монгол улс: Нүүдлийн малчдад зориулсан зөөврийн нарны эрчим хүч” 2013 оны 4-р сарын 8 <http://www.worldbank.org/en/results/2013/04/08/portable-solar-power-for-nomadic-herders>
- Дэлхийн банк; “Ядуурлын түвшин 2012 онд 27.4%-иар буурав” 2013 оны 5-р сарын 21
<http://www.worldbank.org/en/news/press-release/2013/05/21/poverty-rate-came-down-to-27-4-percent-in-2012>
- Дэлхийн банк; “Монгол Улсын эдийн засгийн тойм”, 2013 оны 11-р сар
- Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага; Мэдээллийн сан: “Хотуудын агаарын бохирдол” 2013 он http://www.who.int/phe/health_topics/outdoorair/databases/en/index.html
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага; “Засгийн газрын мөрийн хөтөлбөр 2012-2016”, (албан бус орчуулга) 2012 он http://www.wpro.who.int/countries/mng/mongolia_government_action_plan_2012-16.pdf
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн сан; “Ундны ус, эрүүл ахуйг сайжруулах нь”; ДЭМБ-ийн хэвлэл, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Женев, Швейцарь
- М. Золжаргал, (2013). “Цөлжилт Монгол орны нутаг дэвсгэрийн 77%-д нөлөөлж байна.” УБ Пост; 2013 оны 9-р сарын 20 <http://ubpost.mongolnews.mn/?p=610>
- М.Золжаргал; “Улаанбаатар 2015 он гэхэд усны хомсдолд орно”; 2013 оны 3-р сарын 22



Энэхүү судалгааны тайланг Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (НЭЗТТ) хөтөлбөрийн эхний үе шатны хүрээнд хийгдэх ажлын нэг хэсэг болгож бэлтгэв. Ногоон эдийн засгийн төлөв байдлын судалгаа нь НЭЗТТ-ийн зүгээс ирээдүйд өндөр үр ач холбогдолтой байж болох үйл ажиллагаануудыг тодорхойлж, өөр хоорондоо уялдаатай нэгдсэн бодлогоор хангах нөхцөл байдлын загвар судалгаанд хувь нэмэр оруулж байгаа юм.

ЭЗБӨЧСТ-ийн зүгээс энэхүү тайланг бэлтгэхэд тоо баримт, мэдээллийн албан ёсны, үнэн бодитой эх сурвалжуудыг ашиглахыг эрмэлзэн, бүхий л боломжийг эрэлхийлэн ажилласан боловч, Ногоон эдийн засгийн талаархи мэдээлэл зөвхөн энэхүү судалгаагаар хязгаарлагдахгүй. Энэхүү тайланг ашигласны улмаас үүдэн гарах аливаа хохирлыг төвийн зүгээс хууль эрх зүйн хүрээнд хариуцахгүй болно.

Түүнчлэн энэхүү тайлан нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яам болон НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн албан ёсны байр суурийг илэрхийлээгүй бөгөөд ямарваа нэгэн хариуцлага хүлээхгүй болно.